

# ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН НИЙГЭМЛЭГ

МОНГОЛ УЛС

## ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗАВСРЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ

**Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн үнэлгээ:**

*Олон улсын хөгжлийн нийгэмлэг болон Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд боловсруулав.*

*Р.Антана Элсон, Шигео Кашиваги (Олон улсын валютын сан),  
Зафер Эсэвит, Жон Пэйж (Олон улсын хөгжлийн нийгэмлэг) нар  
батлав.*

## 2001 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр

1. Монгол улсын Засгийн газар 8 сарын турш Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг (ЯБСЗББ)-ийг боловсруулав. Энэхүү завсрын баримт бичигт ядуурлыг бууруулах талаар Засгийн газрын баримтлаж буй бодлого болон цаашид хэрэгжүүлэх стратегийн гол чиглэлүүдийг тодорхойлжээ. ЯБСЗББ-ийг оролцооны арга дээр тулгуурлан боловсруулсан бөгөөд цаашид бүрэн хэмжээгээр боловсруулахад авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хавсаргасан байна. Тус баримт бичиг нь ЯБСЗББ-т тавигддаг бүх шаардлагыг хангасан бөгөөд оролцооны арга дээр тулгуурлан боловсруулагдах бүрэн хэмжээний баримт бичгийн үндэс, Монгол улсад ОУВС болон Дэлхийн банкнаас дэмжлэг үзүүлэхдээ баримтлах бодлогын хүрээг хангалттай тодорхойлсон баримт бичиг болжээ гэж дүгнэж байна.

2. Энэхүү Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг нь дараах дөрвөн давуу талтай юм. Үүнд: (i) Засгийн газраас дэвшүүлсэн макро эдийн засгийг тогтворжуулах, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогын үзүүлж буй нөлөөллийг судлаж, үнэлгээ өгсөн; (ii) ядуурлын талаарх тоо баримтад үнэлгээ өгөх, мэдээллийн хомсдлыг тодорхойлсон; (iii) стратегийг боловсруулах ажилд иргэний нийгэм зэрэг сонирхогч талуудын оролцоог эхнээс нь хангасан; (iv) оролцогч талуудын сонирхлыг нарийвчлан судалсан зэрэг болно. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийг боловсруулах явцад яам, холбогдох газруудыг өргөн оролцуулсан, харилцан зөвшилцөлд хүрсэн "Монголын Засгийн газрын жинхэнэ өмчлөлийн" бодлогын баримт бичиг болсныг цохон тэмдэглэх нь зүйтэй юм.

3. Гэхдээ Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийг боловсруулах болон түүнд дурьдсан арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.

Нэгд, эдийн засгийн өсөлтийг дэмжих шинэчлэл нь ядуучуудад амьдралаа төвхнүүлэх боломж олгох буюу орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх эсвэл нийгмийн хамгааллын тогтолцоогоор дамжуулан хуваарилалт хийх хоёр арга хэлбэрийг аль болох зөв хослуулах.

Хоёрт, Монгол улсын санхүүгийн өнөөгийн чадавхийг харгалзан зах зээлийн өрсөлдөөн, үр ашгийг сайжруулах зарчмууд дээр суурилсан хувийн хөрөнгө оруулалтыг аль болох нэмэгдүүлж, улмаар түүнийгээ илүү үр өгөөжтэй ашиглах таатай орчин бүрдүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлэх.

Гуравт, ядуурлыг бууруулах стратеги нь дунд хугацааны төрийн бодлого, хөтөлбөрүүдийн чиглэлийг тогтоох, санхүүгийн хэрэгцээг тодорхойлох, тэргүүлэх чиглэлийг зөв гаргаж, улмаар төсвийн зарлагын дунд хугацааны хүрээнд тусгаж өгөх зэрэг болно. Ингэснээр санхүүгийн чадавх хомс үед нөөцийг улам оновчтой хуваарилах тогтолцоог бүрдүүлнэ.

Дөрөвт, ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг нь ядуурлыг бууруулах стратегийн эцсийн үр дүнг аль болох бодитой тогтоох, явцыг дүгнэх хяналт-шинжилгээний үзүүлэлтийг зөв тодорхойлох явдал юм. Энэ нь тийм ч хялбар биш бөгөөд Засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүтэц, чадавхийг бэхжүүлэх, гадаадын хандивлагчдаас нэлээд хэмжээний туслалцааг авах шаардлага гарна.

4. Түүнчлэн, ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг нь:

♣ Төсөвт хүндрэл учруулахгүйгээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг

дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, түүний үр өгөөжийг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийн шинэ эх үүсвэр болон шинэчлэлийн арга замуудыг тодорхойлох;

♣ Монгол улсын зах зээлийн эдийн засаг руу шилжиж буй шилжилтийн үеийн макро хүрээнд тохирсон ядууралтай тэмцэхэд дорвитой нөлөө үзүүлэхүйц бодлого, хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

♣ Гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төслүүдийг оролцуулан санал болгож буй хөтөлбөрүүдийн өртгийг нарийвчлан тогтоож, төсвийн эх үүсвэртэй уялдуулан ОУВС, Дэлхийн банктай тохирсон макро эдийн засгийн хүрээнд тусгах;

♣ Худалдааны бодлого, эрчим хүчний салбар болон төрийн албаны шинэчлэл, өмч хувьчлал зэрэг бүтцийн өөрчлөлтийн гол арга хэмжээг явуулахад нийгмийн болон ядуурлын байдалд үзүүлэх нөлөөллийг судлах, эмзэг хэсгийхэнд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, тэрчлэн эрсдэл, тэр дундаа гадаад орчны болон байгалийн гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох;

♣ Өрхийн орлого, зарлагын 2002 оны судалгаанд үндэслэн ядуурлын түвшин, түүний хандлагыг дүгнэх, нөөцийн хуваарилалтын талаар олон нийтэд мэдээлэл тархаах болон Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн үр дүнд үнэлгээ өгөх;

♣ Дэлхий дахины дэвшүүлсэн зорилтуудтай уялдуулан тус улсын стратегийн хэрэгжилтийг жил бүр хянах үүднээс үр дүнгийн гол үзүүлэлтийг тодорхойлох;

♣ Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг боловсруулах явцад оролцооны аргыг улам өргөжүүлж, аль болох эртнээс Улсын Их Хурал болон нийгмийн эмзэг бүлгийн төлөөллийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг болно.

5. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын бусад баримт бичгүүдэд үндэслэн боловсруулагдсан бөгөөд баримт бичгийн төсөлд Дэлхийн банк, ОУВС-ийн мэргэжилтнүүд болон бусад хандивлагчдын өгсөн саналуудыг тусгасан байна.

## I. ОРШИЛ

6. УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнгээр эрх баригч нам нийт 76 суудлаас 72-ыг авснаар Засгийн газраа 2000 оны 8-р сард шинээр байгуулсан байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах зорилт дэвшүүлснийг Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт тусгалаа. Улс орны хязгаарлагдмал нөөцтэй уялдуулан өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн бодлогоо тодорхойлж, тэргүүлэх чиглэлийг тогтоосон байна. Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн үеийн 10 гаруй жилд нэлээд амжилтад хүрсэн боловч шийдвэрлэвэл зохих олон асуудлууд байсаар л байна. Эдгээрээс санхүүгийн чадварыг бэхжүүлэх, хүний нөөцийн хөгжлийг бататгах нь юунаас ч чухал юм. Саяхан 2001 оны 5 сард зохиогдсон Монголд хандивлагчдын зөвлөлдөх уулзалтаар Засгийн газрын бодлогыг зөв тодорхойлж, харин хэрэгжүүлэх чадавх хангалтгүй гэж дүгнэсэн юм. Иймд үндэсний чадавхийг бэхжүүлэх, шийдвэр гаргах явцыг улам оновчтой болгоход бүхий л талын дэмжлэг үзүүлэхээ хандивлагчид амласан билээ.

## II. ЯДУУРЛЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТОО БАРИМТ, СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ БОЛОН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

7. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг нь тоон болон чанарын өргөн хүрээг хамарсан мэдээлэл дээр суурилсан байна. Үүний дотор 1995, 1998 онуудад хийгдсэн Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа (төдийлөн хооронд нь харьцуулах боломжгүй), Үндэсний статистикийн газраас жил болгон явуулдаг Өрхийн орлого, зарлагын судалгаа, Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа зэрэг нь ядуурлын талаарх дүгнэлт гаргах суурь мэдээлэл болжээ. Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа нь ядуурлыг бууруулах стратегийг тодорхойлоход бодит байдлыг олон талаас нь дүгнэх, олон нийтийн санаа бодлыг тусгахад чухал үүрэгтэй байна.

8. Бодлого боловсруулагчдыг суурь мэдээллээр хангах зорилгоор Үндэсний статистикийн газар нь олон жилийн турш өрхийн орлого, зарлагын судалгаа болон ядуурлын талаарх түүвэр судалгаа явуулсан боловч үр дүн нь хоорондоо зарим талаар харьцуулах боломжгүй зэрэг дутагдалтай тал байна. Тухайлбал, түүвэрлэлтийн зохиомжийг өөрчлөх, ядуурлын шугамыг өөрөөр тодорхойлох зэргээс хамааран судалгааны үр дүнг шууд харьцуулан үзэхэд хязгаарлагдмал байна. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт энэ байдлыг дүгнэн шинээр явуулахаар бэлтгэж буй өрхийн орлого, зарлагын судалгааны аргазүйн талаар сонирхогч талууд нэгдмэл ойлголтод хүрсэн байх нь чухал гэж дурьдсан байна. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг боловсруулах явцад эхлүүлсэн төрөл бүрийн судалгаа, шинжилгээний ажил нь судалгааны нэгжүүд болон холбогдох яамдад мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар нэлээд боломжийг олгохоор байна. Өөрөөр хэлбэл, өрхийн талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснээр судалгааны ажлыг өргөжүүлэх, ядуурлын талаар нэгдсэн ойлголтод хүрэхэд чухал нөлөө үзүүлнэ.

9. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулах явцад гарах мэдээллийн хэрэгцээ, хомсдолыг тодорхойлсон, түүнийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд хандивлагчдын дэмжлэгийг хүссэн Статистикийн ерөнхий төлөвлөгөө бэлтгэх нь чухал юм. Ядуурлыг бууруулах

стратегийн завсрын баримт бичгийн сүүлийн хэсэгт шаардлагатай мэдээллийн жагсаалтыг урьдчилсан байдлаар хавсаргасан бөгөөд Мэдээлэл тархаах ерөнхий стандарт, Засгийн газрын хэрэгцээг үндэслэн мэдээллийн хомсдолыг багасгахад чиглэсэн иж бүрэн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй байна. Мөн одоогоор бэлтгэл ажлыг хангаж буй өрхийн орлого, зарлагын өргөжүүлсэн судалгааг Засгийн газраас дэмжиж, ядуурлын шугамыг тогтоох, хянах суурь судалгаа болгох нь зүйтэй гэсэн зөвлөмжийг мэргэжилтнүүд гаргаж байна. Саяхан явуулсан хүн амын тооллого нь өрхийн орлого, зарлагын судалгааны түүвэрлэлтийн хүрээг тогтооход чухал ач холбогдолтой болсон байна. Одоогоор Үндэсний статистикийн газрын мэдээлэл цуглуулах, удирдах үйл ажиллагааг боловсронгуй болгох, чадавхийг бэхжүүлэхэд олон улсын байгууллагууд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Засгийн газраас гаргасан хүсэлтийг харгалзан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагууд Үндэсний статистикийн газарт туслалцаа үзүүлж байна. Үзүүлж буй туслалцааны үр дүн нь Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг боловсруулахад сайтар нөлөөлөх нь дамжиггүй. Мөн ядуурлын талаар шинжилгээ, судалгаа хийх судалгааны нэгж байгуулах тухай Засгийн газрын шийдвэрийг мэргэжилтнүүд дэмжиж байна.

**10.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт бусад мэдээллийн хомсдол, тухайлбал, худалдааг чөлөөлөх бодлого нь хөдөлмөрийн зах зээл, бизнесийн орчин, орлого хуваарилалт, ажил эрхлэлтэд хэрхэн нөлөөлсөн, хүйсийн асуудлыг нарийвчлан судлах зэрэг асуудлыг тусгасан болно. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт бодлогын асуудлыг өргөн тусгах зорилгоор өрхийн орлого, зарлагын судалгааг төсвийн зарлагын тойм судалгаа, нийгмийн эмзэг бүлгийнхэн (гудамжны хүүхдүүд г.м)-ийг хамруулсан сэдэвчилсэн судалгааны дүнгээр баяжуулах боломжтой юм. Нийгмийн эмзэг бүлэгийхэнд чиглэсэн тогтвортой бодлого хэрэгжүүлэхэд эдгээр судалгаа нь чухал үүрэгтэй юм.

**11.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг нь хяналт-шинжилгээний үзүүлэлт тодорхойлох тал дээр, тэр дундаа нийгмийн салбарын хүрээнд нэлээд чармайлт гаргасан байна. Гэвч Засгийн газраас дэвшүүлсэн 2005 он гэхэд ядуурлыг 50 хувиар бууруулна гэсэн зорилт нь дэндүү шахуу байна. Иймд хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой болгох үүднээс зорилтот үзүүлэлтээ хяналт-шинжилгээний үзүүлэлттэй уялдуулан дахин авч үзэх нь зүйтэй. Дэлхий нийтийн Мянганы хөгжлийн зорилтуудын зэрэгцээ эрчим хүчний салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн салбарын хөгжилтэй уялдуулан ядууралтай тэмцэх талаарх зорилтуудыг дэвшүүлэх нь чухал юм. Мөн хяналт шинжилгээг аль болох ил тод болгоход чиглэсэн бусад үзүүлэлтийг Засгийн газраас санал болгож буйг мэргэжилтнүүд бүрэн дэмжиж байна. Төсвийн зарлагын тойм судалгаа болон хяналт-шинжилгээнд иргэний нийгмийг хэрхэн оролцуулах талаар ч дурьдсан байна. Иймд эдгээр үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Азийн хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагууд дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

### **III. БОДЛОГЫН АСУУДАЛ**

**12.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт (i) макро эдийн засгийн тогтворжилтыг бататгах; (ii) хувийн хэвшил дээр тулгуурласан

экспортын үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах; (iii) хүн ам, түүний дотор ядуучуудад эдийн засгийн өсөлтийн үр шимийг нийгмийн салбарын үйлчилгээг сайжруулах болон зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эмзэг бүлэгийхэнд үзүүлэх сөрөг үр дагаврыг аль болох зөөлрүүлэх зорилгоор нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан хүртээх гэсэн үндсэн гурван чиглэлээр ядуурлыг бууруулах стратегийг тодорхойлсон байна. Иймээс энэхүү бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд төр болон хүн амын хоорондын нягт хамтын ажиллагаа чухал учраас ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулахад иргэний нийгмийн оролцоо хангахад анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд уг баримт бичигт тусгагдсан бодлоготой үндсэндээ санал нэгтэй байгаа бөгөөд ил тод байдал, хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгох, санхүү, мөнгөний оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар төрийн удирдлагыг сайжруулах нь чухал гэдгийг анхааруулж байна. ЯБСЗББ-т тусгасан бодлогын чиглэлүүд нь Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр, Санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдсан гэж дүгнэж байна.

**13.** Баримтыг бүрэн хэмжээгээр боловсруулахад ядуурлыг бууруулах болон өсөлтийг хангах асуудлыг иж бүрнээр нягтлан үзэх, энэ дагуу баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тогтоох, өртөг зардлыг бодитой зөв тооцох ажлыг чанаржуулах нь чухал юм. Хэдийгээр завсрын баримт бичигт төсвийн удирдлага, хяналтыг сайжруулах замаар засаглалыг боловсронгуй болгох талаар тусгасан хэдий ч энэ нь хангалтгүй учраас бүрэн баримт бичигт энэ асуудлыг анхаарах нь зүйтэй юм.

**14.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт тусгасан дунд хугацааны макро эдийн засгийн хүрээ нь Олон улсын валютын сантай тохиролцсон хөтөлбөрт заасан төсөв, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, мөнгөний удирдлагын шууд бус арга хэрэгслүүдийг өргөн ашиглах, зах зээлийн чөлөөтэй хөрвөх ханшны тогтолцооны бодлоготой нягт уялдсан бөгөөд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зарчимтай бүрэн тохирч байна. Мөн дунд хугацаанд гадаад салбарын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, инфляцийн түвшинг нэг оронтой тоо хүртэл бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хүргэснээр ядуурлыг дорвитой бууруулах үндсийг бүрдүүлэхээр заажээ. Макро эдийн засгийн тогтвортой орчин болон өргөн хүрээг хамарсан бүтцийн өөрчлөлтүүд нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах суурь болох юм.

**15.** Гэвч ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт тусгасан макро эдийн засгийн хүрээнд төрийн албаны шинэчлэл, өмч хувьчлалын орлоготой холбоотой тооцоог нэлээд тоймлон тусгасан байна. Иймд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Төсвийн зарлагын тойм судалгаа болон шинэчлэлийн бусад хөтөлбөрүүдийг үндэслэн эдгээр тооцоог дахин нарийвчлан хянаж бүрэн баримт бичигт тусгах нь зүйтэй юм. Мөн ДНБ-ний өсөлтийг дунд хугацаанд 6 хувьд хүргэх зорилтыг хангах үүднээс өсөлтийн эх үүсвэрүүд, тэдгээрийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хамт тусгаж өгөх нь зүйтэй юм.

**16.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт мөнгө, зээлийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, банкны бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэхийг онцлон тэмдэглэсэн байна. Сүүлийн жилүүдэд банкууд, тэр дундаа улсын

банкнаас хувийн хэвшилд зээлийг тодорхой бодлогогүй олгосноос шалтгаалан банкны салбарт хямрал гарчээ. Урьд онуудад макро эдийн засгийн тогтвортой бус байдал, тэр дундаа санхүүгийн салбарын удирдлага, хяналт, хариуцлага сул байсныг завсрын баримт бичигт дурьдсан байна. Мөн улсын нөөц, хөрөнгийн ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ хөрөнгө оруулалт, хуримтлалыг дэмжсэн санхүүгийн зохистой зуучлалын тогтолцоог ялангуяа орон нутагт бий болгох нь чухлыг онцлон тэмдэглэж байна. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын цар хэмжээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор банкны зээлийн бодлогыг зах зээлийн зарчимтай бүрэн уялдуулах талаар тусгаж өгөх нь зүйтэй юм.

**17.** ЯБСЗББ-т дурьдсаны дагуу Засгийн газраас баримтлаж буй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах бодлого, банкны салбар дахь эрхзүйн орчныг боловсронгуй болгох талаар дэвшүүлж буй арга хэмжээг дэмжиж байна. Санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлж буй зорилтуудтай уялдуулан төв банкнаас тавих хяналтын тогтолцоог бэхжүүлэх нь чухал. Иймд ОУВС, ОУХН-ийн дэмжлэгтэйгээр хөрөнгийн ангилал, бүртгэл, хяналт, аудитын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй юм. Мөн банк, ялангуяа гадаадын банкинд шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох сонголтын шалгуурыг тогтоож, чанд мөрдөж байхыг төв банкинд зөвлөж байна. Ийнхүү ЯБСЗББ-т банкуудын төлбөрийн чадварыг бэхжүүлнэ гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дээрх шалгуур үзүүлэлтийг тогтоох боломжтой юм. Мөн банкинд итгэх итгэлийг сэргээх, бататгах зорилгоор хадгаламжийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх талаар судалж үзэх нь зүйтэй юм.

**18.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих зорилтын хүрээнд өмч хувьчлалыг эрчимжүүлэх талаар Засгийн газраас дэвшүүлж буй зорилтуудыг дэмжиж байна. Засгийн газраас Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг батлаж, үл хувьчлах хөрөнгийн жагсаалтыг хүчингүй болгосон нь чухал эхлэл юм. Иймд ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт хувьчлалын хөтөлбөрийн зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг мэргэжилтнүүд зөвлөж байна. Энэ төлөвлөгөөнд тухайн санхүүгийн жилд хувьчлах үнэ цэнэтэй томоохон үйлдвэр, аж ахуйн газруудын жагсаалт, эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийн дунд хугацааны арга хэмжээг тусгах нь зүйтэй юм.

**19.** Хэдийгээр хувийн хэвшил дээр суурилсан эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулна гэсэн зорилт дэвшүүлсэн боловч арга замуудыг төдийлөн тодорхой заагаагүй байна. Тухайлбал, ЯБСЗББ-т гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар бүрхэг тусгагдсан байна. Иймд бүрэн баримт бичигт эдгээр асуудлыг нарийвчлан тусгаж, салбарын бодлого ядууралд хэрхэн нөлөөлөх талаар тодорхой зааж өгөх нь зүйтэй юм. Үүнд: ядуучуудын зах зээлд хүрэх боломжийг нэмэгдүүлэх, хувийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд үйлчлэх хууль, журмыг хялбаршуулах, хүн амын давхаргуудад санхүүгийн, үүний дотор банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээний хүртээжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Үүнээс гадна ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт гадаад худалдааг чөлөөлөх, үүнтэй уялдан хуваариалалтын тогтолцоонд хэрхэн нөлөөлөх талаар дэлгэрэнгүй

тусгах нь зүйтэй юм.

**20.** Дунд хугацааны макро эдийн засгийн бодлогын үндсэн зорилго нь төсвийн зарлагын удирдлага, төвлөрсөн ба орон нутгийн төсвийн харилцааны тогтолцоог боловсронгуй болгох замаар улсын төсвийн удирдлагыг сайжруулахад оршиж байна. Иймд бүрэн баримт бичигт төсвийн зарлагын удирдлагыг боловсронгуй болгосноор төсвийн сахилга хэрхэн дээшлэх талаар тодорхой тусгаж өгөх нь зүйтэй юм. Хэдийгээр одоогоор хэлэлцэгдэж буй Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль Монгол улсын төрийн албыг үндсээр нь шинэчлэх боловч ЯБСЗББ-г хүлээгдэж буй үр дүнгийн шинжилгээ, төрийн удирдлагын түвшингийн хариуцлагын тогтолцоо, хэрэгжүүлэх үеийн эрсдэлийн талаар сайн тусгаж өгөөгүй байна. Энэ талаар төсвийн тойм судалгаа тодорхой мэдээллээр хангана гэж үзэж байна. Иймд тойм судалгааны үр дүн нь Засгийн газраас явуулж буй шинэчлэлийн бодлого, түүний нийгмийн үйлчилгээний чанар, ядуучуудад хүртээх талаар явуулах арга хэмжээний үр дүнд нөлөөлөх болно. Үүний зэрэгцээ төсвийн хөрөнгийн зарцуулалт, нийгмийн салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн ядуучуудад үзүүлж буй нөлөөллийг үнэлэх талаар нэмэгдэл судалгаа хийх нь зүйтэй байна.

**21.** Засгийн газар санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох замаар бүртгэл, тайлагналт, нягтлан бодох бүртгэл, аудит болон хяналт-шинжилгээг бэхжүүлэх талаар тодорхой алхмуудыг хийж эхлэсэн бөгөөд төрийн сангийн хяналтыг сайжруулах зорилгоор Төв банканд дээр төсвийн нэгдсэн дансыг нээсэн байна. Энэ талаар Олон улсын валютын сангийн санхүүгийн зөвлөх, Азийн хөгжлийн банкны Санхүү, эдийн засгийн яамны зөвлөх болон Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн санхүүгийн техникийн туслалцааны төсөл дэмжлэг үзүүлж байна. Эдгээр шинэчлэлийн дүнд Засгийн газрын бүртгэл болон санхүүгийн тогтолцооны удирдлагыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, ялангуяа ядуучуудад үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой болно.

**22.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт төрийн албаны шинэчлэлийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд хийхээр тусгасан байна. Төрийн албыг чадваржуулах, үр ашигтай, өрсөлдөөний зарчмаар ажиллуулах нь ядуурлыг бууруулах стратегийн салшгүй хэсэг мөн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хүний нөөцийн ашиглалт, ялангуяа нийгмийн үйлчилгээг ядуучуудад хүргэх асуудлыг бэхжүүлэхэд энэхүү шинэчлэл чухал ач холбогдолтой юм. Гэвч ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт энэ талаар тодорхой санал дэвшүүлээгүй байна. Төсвийн зарлагын тойм судалгаа нь төрийн албыг мэргэжлийн хувьд чадварлаг, цомхон болгон шинэчлэхэд нэлээд дэмжлэг үзүүлэх болно. Иймээс төрийн албаны шинэчлэлийн стратеги, арга замуудыг бүрэн баримт бичигтээ нарийвчлан тусгах нь зүйтэй юм.

**23.** Эрчим хүч, тээвэр, бүс нутгийн хөгжил болон байгаль орчныг хамгаалах зэрэг асуудлыг ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт өргөн тусгасан нь ядууралтай тэмцэх үйлс нь зөвхөн нийгмийн чиглэлийн асуудал биш олон салбарыг хамарсан цогц стратеги мөн гэдгийг нотолж байна. Гэвч Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт тусгагдсан бодлого нь нийгмийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд хэт их анхаарал тавьж, нөөцийн хуваарилалтын үр ашиг, үйлчилгээний чанарыг хэрхэн дээшлүүлэх болон тодорхой хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг хангалтгүй тусгасан байна.



Өөрөөр хэлбэл, эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнгийн үнэлгээг сайн тооцохгүй бол нийгмийн салбарын дэд бүтцийн хөгжилд оруулсан их хэмжээний хөрөнгө оруулалт үр дүн муутай, эсвэл санхүүгийн хувьд тогтворгүй болох юм. Ялангуяа, эрүүл мэндийн салбарт энэ байдал ажиглагдаж байна. Хэдийгээр тоног төрөөхөмж, байшин барилгыг шинэчлэх шаардлага байгаа боловч нөгөө талаар хөдөөгийн ядуучуудад эрүүл мэндийн суурь үйлчилгээ үзүүлэх сан бүрдүүлэх нь эн тэргүүний зорилт болж байна. Монгол улсын хувьд ДОХ-ын тархалт анхаарал татах гол асуудал биш боловч бүх нийтийн боловсролын үйлчилгээгээр дамжуулан сургалт явуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт зөвлөж байна. Боловсролын салбарын хувьд ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичиг нь хөдөөгийн нүүдэлчин хүн амд хүргэх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарын талаар иж бүрэн тусгах нь зүйтэй юм. Үүнийг дунд хугацааны төсвийн бодлоготой уялдуулах замаар хийх хэрэгтэй.

**24.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт дурьдсанаар боловсрол эзэмшигчид болон хөдөлмөр эрхлэгчдийн хүйсийн ялгааг арилгахад хүндрэлтэй байна (Боловсрол эзэмшигчдэд эмэгтэйчүүд, хөдөлмөр эрхлэгчдэд эрэгтэйчүүд тус тус давамгайлж байна). Мал маллахад 1990-ээд оны үеэс хүн хүчний шаардлага нэмэгдэж, хөвгүүд олноор малчин болсноос суурь боловсролыг охидууд илүү эзэмших болсон байна. Мөн боловсролын бусад шатанд ч эмэгтэйчүүд давамгайлж байна. Гагцхүү дээд түвшингийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, харьцаа тэгш бус байна. Иймд Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар хүйсийн тэгш байдлын бодлогын талаар дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, халамжийн тогтолцоо, эрүүл мэнд болон хоол, тэжээлийн талаар төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар тусгаж өгөх нь чухал байна. Энэ талаар Засгийн газраас төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж буй одоогийн туршлагыг дэмжиж байна.

**25.** Ажилгүйдлийг багасгах нь ядуурлыг бууруулах Засгийн газрын бодлогын гол чиглэл бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн талаарх статистик мэдээллийг сайжруулах шаардлагатайг ЯБСЗББ-т дурьдсан байна. ЯБСЗББ-т дурьдсанаар хувийн салбарын үйл ажиллагааг дэмжих хууль, эрхзүйн таатай орчныг бүрдүүлж, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн зах зээлийн хяналт шинжилгээг бэхжүүлэх, үр дүнтэй сургалт, дадлагын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар чухал үүрэгтэй гэж заасан байна. Мөн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах нь ядуучуудыг дэмжих чухал хэрэгсэл мөн гэдгийг онцлон тэмдэглэсэн юм. Мөн бүрэн баримт бичигт саяхан батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын заалтын хэрэгжилтийн нөлөөллийн талаарх шинжилгээ, тэдгээрийн өртөг, үр дүнг тооцож тусгах нь зүйтэй. Мөн ядуурлыг бууруулахад нийгмийн хамгааллын тогтолцоо, үүний дотор жинхэнэ ядуучуудад чиглэсэн халамжийн тэтгэвэр, тэтгэмж чухал үүрэгтэй гэдгийг ЯБСЗББ-т цохон тэмдэглэсэн байна. Үүний дотор одоогийн үйлчилж буй нийгмийн халамжийн тогтолцоо (ДНБ-ний бараг 7 хувьтай тэнцэх) -ны үр ашгийг нарийн тооцон үзэж, ядуурлыг бууруулахад хэрхэн нөлөөлж буй талаар дүгнэлт гаргах нь зүйтэй юм. Иймд төсвийн дарамтыг нэмэгдүүлэхгүйгээр тэтгэврийн сангийн хэмжээ болон хамралтыг өргөжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг судлах хэрэгтэй.

26. Өргөн уудам нутаг дэвсгэртэй, эрс тэс уур амьсгалтай Монгол орны нөхцөлд дэд бүтцийн оновчтой бодлогогүйгээр ядуурлыг бууруулах, тогтвортой өсөлтийг хангах үйл явцыг хэрэгжүүлэх боломжгүйг ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт дурьдсан байна. Засгийн газар хүн амыг зах зээлийн үйлчилгээтэй холбох, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах нь үйлдвэр, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлж, цаг агаарын эрсдэлээс хамгаалах нэг нөхцөл гэж үзсэн байна. Дээрх арга хэмжээ нь их хэмжээний хөрөнгө оруулалтыг шаардах учраас ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт зардлыг нарийвчлан тооцож тусгах нь зүйтэй юм. Ингэхдээ эрчим хүч болон тээврийн одоо байгаа хүчин чадлыг шинэчлэх, засварлахад түлхүү анхараах нь чухал юм. Иймээс Засгийн газрын зүгээс Мянганы зам барих төлөвлөгөөг дахин хянахыг зөвлөж байна.

27. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, шилжих хөдөлгөөнийг тогтворжуулах зорилгоор бүсчилсэн хөгжлийн загварыг ЯБСЗББ-т зөв тусгасан байна. Гэхдээ энэхүү үзэл баримтлалыг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх талаар тодорхой зааж өгөөгүй байна. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд ЯБСЗББ-т үйлдвэр, үйлчилгээг дэмжих талаар санал болгож буй арга хэмжээ, худалдааны чөлөөт бүс байгуулах зэрэг зорилтуудыг төсвийн тогтвортой байдалтай уялдуулан эргэж харах нь зүйтэй юм. Дэлхийн банк ба ОУВС-ийн мэргэжилтнүүд Монгол улсын санхүүгийн боломж, нөөцтэй уялдуулан бусад орнуудын туршлага дээр үндэслэн тус орны нөхцөлд тохирсон бүсчилсэн хөгжлийн стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна. Олон улсын жишгээс үзэхэд татвар ба хөрөнгө оруулалтын урамшуулал, дэд бүтцэд оруулж буй хэт их хэмжээний хөрөнгө оруулалт, захиргаадалтын зээл олгох, хамгаалалтын хэт хатуу бодлого явуулах, ажиллах хүчний хөдөлгөөнийг хэт хязгаарлах зэрэг нь эдийн засгийн нийт өсөлт, ядуурлыг бууруулахад зарим талаар сөрөг нөлөө үзүүлж болдог юм. Иймд бүрэн баримт бичигт хотын ядуурал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судлаж, баримтлах бодлогын чиглэлийг боловсруулан тусгах хэрэгтэй.

28. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт хөдөөгийн хөгжил болон эрсдэлийн удирдлага зэрэг хоёр асуудлыг бүрхэг тусгасан байна. Иймд бүрэн баримт бичигт Засгийн газрын зүгээс оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгааны дүн дээр үндэслэн ядуучуудын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, тэдгээрийн өмчийг хамгаалах бодлогыг тодорхойлох нь зүйтэй юм. Үүнд нэгд, ган, зудаас урьдчилан сэргийлэх, ялангуяа бэлчээрийг хамгаалах, хоёрт, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар тусгах нь зүйтэй юм. Эдгээр асуудлаар Олон улсын хөгжлийн нийгэмлэгтэй хамтарч хэрэгжүүлэх Тогтвортой амьжиргааг дэмжих төсөл зохих үр дүнгээ өгөх болно.

29. Монгол улсын шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад хандивлагчид тууштай дэмжлэг үзүүлж ирлээ. Хэдийгээр бодлогын гол чиглэлээр нэгдсэн ойлголтод хүрсэн боловч төлөвлөж буй бодлогын арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг тогтоох, хэрэгжүүлэх арга замуудыг нарийвчлан судлах шаардлага байна. Иймд бүрэн баримт бичигт гадаадын зээл, тусламжийг зохицуулах талаар Засгийн газрын үүргийг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын удирдан чиглүүлэх, зохицуулах үүрэг нь гадаадын тусламжийн ашиглалтад онцгой ач холбогдолтой юм.

#### IV. БЭЛТГЭЛ АЖИЛ

**30.** Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн бэлтгэл ажлыг Монгол улсын Засгийн газар санаачлан идэвхтэй зохион байгуулж, яамдуудын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоо, харилцан зөвшилцөх явц сайн байсныг цохон тэмдэглэж байна. Яамд, Монголбанк, ҮСГ-ын төлөөлөгчдийг оролцуулан техникийн ажлын хэсгийг СЭЗЯ ахлан ажилласан байна. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийн бодлогын зөвлөлийг Санхүү, эдийн засгийн сайд болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд удирддаг юм байна. Эхний шатанд ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулах үндсэн чиглэл, шинжилгээний аргуудын талаар Олон улсын хөгжлийн нийгэмлэг, Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд Санхүү, эдийн засгийн яамтай хамтран семинар зохион байгуулав. Энэхүү семинарт хандивлагчид, хувийн хэвшил, хот, хөдөөгийн төрийн бус байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид оролцсон байна. Ингэснээр ЯБСЗББ-ийг боловсруулах ажлыг эхлүүлжээ. Боловсруулах явцад завсрын баримт бичгийн 7 төслийг бэлтгэсэн бөгөөд 3 дахь хувилбараас эхлэн хандивлагчид, төрийн бус байгууллагуудаас санал авч эхэлсэн юм. Мөн уг баримт бичгийг боловсруулах явцыг Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд дэмжиж, Засгийн газрын бэлтгэсэн төсөлд өөрсдийн саналаа өгч байжээ.

**31.** Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулахад оролцооны аргыг ялангуяа хөдөө, орон нутагт очиж ядуучуудтай зөвлөлдөх замаар улам өргөжүүлэх хэрэгтэй юм. Иймд ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулахад төрийн байгууллагын бүх шатны оролцоо, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлах, бүсчилсэн семинарыг зохион байгуулах тухай саналыг Олон улсын хөгжлийн нийгэмлэг болон Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд дэмжиж байна. Иргэний нийгэм бол Монголын улс төрд чухал байр суурь эзэлдэг бөгөөд стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах ажилд тэднийг өргөн ороцуулах нь чухал юм. Олон улсын байгууллага болон Засгийн газрын хамтран зохион байгуулсан Хөгжлийн төлөө хэлэлцүүлэг болон бусад семинарт иргэний нийгмийн төлөөлөгчдийг оролцуулсан нь оролцоог улам өргөжүүлжээ. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулахад иргэний нийгмийн оролцоог улам өргөжүүлэхээр заасны дагуу мэргэжилтнүүд харилцан зөвшилцөл, ойголцолд хүрэх, оролцоог хангах тал дээр техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Харин бүрэн баримт бичгийг боловсруулах явцад анхнаас нь УИХ-ын төлөөллийг өргөжүүлэхийн чухлыг тэмдэглэж байна. Ингэснээр ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилт, хяналтыг төсвийн төслийг боловсруулах, батлах үйл ажиллагаатай нягт уялдуулах хэрэгтэй.

## **V. СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ**

**32.** Төсвийн нөөц, хөрөнгө хомс байгаагаас шалтгаалан Засгийн газраас нийгмийн салбарт дэвшүүлсэн өргөн хүрээтэй зорилтуудыг бүгдийг шийдвэрлэнэ гэвэл макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд хэрэгжүүлэхээр санал болгож буй бодлого, арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг зөв тогтоох хэрэгтэй. Тэргүүлэх чиглэлийг аль болох ил тод, тодорхой шалгуурын дагуу тогтоохыг зөвлөж байна.

**33.** Зарим нэгэн сонирхол хэт давамгайлах, шахалтад орсноос улбаалан

бизнес эрхлэх таатай орчныг сулруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтад садаа хийх, ядуучууд болон төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд Засгийн газар, Төв банкнаас арилжааны банкны зээлийн бодлогод шахалт үзүүлснээр (тодорхой үйлдвэр, салбарыг дэмжих зорилгоор захиргаадалтын зээлийг олгох гэх мэт) банкуудын төлбөрийн чадвар, үр ашигт сөргөөр нөлөөлж, улмаар төсвийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэл байж болох юм.

**34.** Мөн ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт байгаль, цаг уур, гадаад орчноос шалтгаалсан эрсдэл их байдгийг дурьджээ. Монгол улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн (зэс, ноолуур, алт)-ий дэлхийн зах зээлийн үнийн уналт, ган, зуд зэрэг байгалийн гамшигт Монгол улсын эдийн засаг өртөмтгий хэвээр байна. Иймээс энэхүү нөлөөллөөс шалтгаалан макро эдийн засгийн тогтворжилт алдагдах, эдийн засгийн өсөлт саарах, улмаар ядуурлыг бууруулахад сөргөөр нөлөөлөх магадлал байна.

**35.** Өөр нэг эрсдэл бол гадаадын хөрөнгийн урсгалтай холбоотой юм. Дунд хугацаанд Монгол улсын санхүүгийн тогтвортой байдал нь гадаадын хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжаас ихээхэн хамаарах болно. Хөнгөлөлттэй бус нөхцлөөр гадаадын зээлийг авахаас татгалзах нь зүйтэй юм. Хэдийгээр Монгол улс их өртэй ядуу орон (ННРС)-д өрийн хөнгөлөлт үзүүлэх нөхцөл бүхий орнуудын тоонд ороогүй боловч гадаад өрийн дарамт нь өндөр байна. Иймээс дунд хугацаанд гадаад нөхцөлд өртөмтгий байдлаа бууруулах гол нөхцлүүдийн нэг бол гадаад орнуудтай хийх хоёр талын төлбөр тооцоо, тухайлбал, ОХУ-аас 1991 оноос өмнө авсан шилжих рублийн зээлийн асуудлыг цэгцлэх болон гадаад өрийн удирдлагыг бэхжүүлэх явдал чухал юм.

**36.** Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт тусгахаар санал болгож буй зорилтууд нь хэт өргөн хүрээтэй, стратегийг хэрэгжүүлэх эхний үед бэрхшээлтэй тулгарч болзошгүй юм. Байгууллагуудын ядмаг бүтэц, зохион байгуулалт нь стратегийг хэрэгжүүлэх, түүнчлэн баримт бичгийг боловсруулах ажилд ч сөргөөр нөлөөлөх талтай юм. Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичигт тусгагдах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, тухайлбал, төрийн албаны шинэчлэл, эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны зорилт зэрэг нь цаг хугацаа, хамрах хүрээний хувьд их өргөн билээ. Иймээс Монгол улсын Засгийн газар болон ОУВС, Дэлхийн банкны зүгээс стратегийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор өсөн нэмэгдэж буй өөрчлөлтийг дүгнэх замаар хянаж, дүгнэх болно. ЯБСЗББ-т дурьдсаны дагуу Засгийн газрын ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гадаад хандивлагчдын дэмжлэгтэйгээр хийх нь зайлшгүй юм. Иймээс Засгийн газрын удирдлага дор хандивлагчид үзүүлж буй дэмжлэгээ уялдуулан зохицуулах нь чухал юм.

## VI. ДҮГНЭЛТ

**37.** ЯБСЗББ-ийг боловсруулах үйл явц болон баримт бичиг нь Засгийн газраас иргэний нийгэм болон бусад сонирхогч талуудтай хамтран ядууралтай тэмцэх асуудлаар хүч чармайлтаа нэгтгэн гаргаж буйг нотлож байна. Түүнчлэн, Монгол улсын Засгийн газраас боловсруулсан ЯБСЗББ нь ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг бүрэн хэмжээгээр боловсруулах үндэс суурь болох бөгөөд Олон улсын хөгжлийн нийгэмлэг, Олон улсын валютын сангаас үзүүлэх дэмжлэгийн үндэс болж байна. Дэлхийн банкны болон Олон улсын валютын сангийн гүйцэтгэх захирлууд энэхүү дүгнэлтийг дэмжин батлах нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргаж байна.

\* \* \*

**Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр болон Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигтэй холбогдсон Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн үйл ажиллагааг 2001 оны 9-р сараас 2002 оны 12-р сарын хооронд хэрэгжүүлэх төлөвлөгөө**

Байгууллага	Үйл явдал	Хэрэгжих хугацаа
Дэлхийн банк болон ОУВС	Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичгийг боловсруулж, мэргэжилтнүүдийн хамтарсан дүгнэлт гаргах	2001 оны 9-р сар
ОУВС	Гурван жилийн хугацаатай хэрэгжих Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг Захирлуудын зөвлөлөөр батлуулах	2001 оны 9-р сар
Дэлхийн банк, ОУВС болон Азийн хөгжлийн банк	Улсын төсвийн зарлагын тойм судалгааг хийх	2002 оны 2-р сар
Дэлхийн банк	Тогтвортой амьжиргааг дэмжих төслийн бэлтгэлийг хангах	2002 оны 3-р сар
ОУВС	Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн явцын эхний тойм, гэрээний 4-р зүйлийн хэрэгжилтийг гаргах (2002)	2002 оны 3-р сар
Дэлхийн банк болон ОУВС	Ядуурлыг бууруулах стратегийн бүрэн баримт бичгийг боловсруулж, мэргэжилтнүүдийн хамтарсан дүгнэлт гаргах	2002 оны 9-р сар
Дэлхийн банк	Тусламжийн хөтөлбөрийн стратегийг боловсруулах	2002 оны 9-р сар
ОУВС	Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хоёр дахь тоймыг хийх	2002 оны 9-р сар
Дэлхийн банк	Ядуурлыг бууруулах стратегийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтийн зээлийг олгох	2002 оны 9-р сар

## Товч зөвлөмж

Ядуурлын талаарх тодорхойлолт, хяналт-шинжилгээ, үнэлгээ	Хандивлагчдын дэмжлэг
<ul style="list-style-type: none"> <li>◆ Ядуурлыг хянах, шинжлэх мэдээллийн суурийг Өрхийн орлого, зарлагын 2002 оны судалгааны дүнгээр гаргах</li> <li>◆ Өрхийн орлого, зарлагын судалгааг бусад сэдэвчилсэн судалгааны дүнгээр (жишээ нь: эмзэг бүлэг, төсвийн зарлагын тойм судалгаа г.м.) баяжуулах</li> <li>◆ Төсвийн зарцуулалтыг хянахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, үндэсний хөтөлбөрүүдийн үр ашгийг шинжлэн дүгнэх</li> <li>◆ Хот, суурин газрын ядуурлын шалтгаан, тэр дундаа хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөний нөлөөллийг судлах</li> <li>◆ Судалгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор судалгааны үр дүнг тархаах арга хэмжээг сайжруулах</li> <li>◆ Тоо баримтын дутагдал, хомсдолыг тодорхойлж, түүнийг арилгах төлөвлөгөө боловсруулах</li> <li>◆ Стратегийн хэрэгжилтийг (ялангуяа эрчим хүч, дэд бүтцийн салбарын хянах үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох)</li> </ul>	<p>Олон улсын хөгжлийн нийгэмлэг (ОУХН)</p> <p>ОУХН</p> <p>ОУХН/ОУВС/АХБ/НҮБХХ</p> <p>ОУХН/НҮБХХ</p>
<p><b>Эдийн засгийн бодлого</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>◆ Эдийн засгийн өсөлтийн эх үүсвэрийг тодорхойлж, түүнийг дэмжих арга замыг тусгах</li> <li>◆ Макро эдийн засгийн хүрээнд ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэй хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлийг тогтоож, тэдгээрийн өртгийг тооцох</li> <li>◆ Ядуучуудад туслалцаа үзүүлэхдээ нийгмийн халамжийн тогтолцоонд суурилдгийг багасгаж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэхэд анхаарлаа хандуулах</li> <li>◆ Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг хэрхэн хангах талаар тодорхой зааж, ядуучуудад үзүүлэх нөлөөллийг нарийвчлан тогтоох</li> <li>◆ Дунд хугацаанд өмч хувьчлалын явцыг эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хувьчлах үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн жагсаалтыг хуваарийн хамт гаргах</li> <li>◆ Худалдааны бодлого болон ноолуурын экспортод ногдуулсан татварын нөлөөллийг судлах</li> <li>◆ Эрчим хүчний салбар дахь шинэчлэл нь ядуурал ба бусад нийгмийн асуудлуудад хэрхэн нөлөөлөх талаар судлах</li> </ul>	<p>ОУХН/АНУОУХХН</p> <p>ОУХН/АНУОУХХН</p>

<p><b>Төсвийн удирдлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>◆Макро эдийн засгийн хүрээнд тусгасан нийгмийн салбарын шинэчлэлийн (тухайлбал, төрийн албаны шинэчлэл) өртгийг тооцож, өмч хувьчлалын орлогыг зөв тодорхойлох</li> <li>◆Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдснаар нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, түүний эдийн засаг, төрийн удирдлагад үзүүлэх нөлөөлөл, дагалдах эрсдэлийг тооцох</li> <li>◆Төрийн албан хаагчийн цалингийн түвшинг хэвээр хадгалж, үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэх</li> <li>◆Төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг оновчтой болгох</li> <li>◆Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн өртөг, үр ашгийг тооцож, шаардлагатай бол төлөвлөгөөний өөр хувилбарыг олон улсын туршлага дээр суурилан боловсруулах</li> </ul>	<p>ОУХН/ОУВС</p> <p>АХБ/ОУВС/ОУХН</p> <p>ОУХН</p> <p>ОУВС</p> <p>ОУХН/ОУВС</p>
<p><b>Салбарын бодлого</b></p> <p><b>Санхүүгийн салбар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>◆Санхүүгийн салбарын төлбөрийн чадварыг бэхжүүлэх, хяналтын стандартуудыг олон улсын жишигт хүргэх</li> <li>◆Банкны зээл олгоход баримтлах арилжааны шалгууруудыг нэвтрүүлэх талаар судлах</li> </ul>	<p>ОУХН/ОУВС/АХБ</p>
<p><b>Нийгмийн салбар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>◆Дэд бүтцийг өргөжүүлэхээсээ илүү нийгмийн үйлчилгээний үр ашиг, чанарыг дээшлүүлэхэд анхаарах</li> <li>◆Хөдөөгийн ядуу өрхүүдэд эрүүл мэндийн суурь үйлчилгээг хүртээх, ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаар олон нийтийг хамарсан сургалтыг өргөжүүлэх</li> <li>◆Нүүдэлчин өрхүүдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг судлах</li> <li>◆Боловсрол эзэмших ба ажил эрхлэлтэд хүйсийн тэгш байдлыг хангах талаар судлах</li> <li>◆Саяхан батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн, өртгийг тооцох</li> <li>◆Ядуурлыг бууруулахад одоогийн үйлчилж буй халамжийн тогтолцооны үр ашгийг тооцож, дүгнэлт гаргах</li> <li>◆Тэтгэврийн шинэчлэлийг төсвийн ачаалалтай уялдуулан хийх</li> <li>◆Хүмүүсийн бие даан хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх талаар судлах</li> </ul>	<p>АХБ</p> <p>АХБ</p> <p>ОУХН</p>
<p><b>Дэд бүтэц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>◆Юуны өмнө эрчим хүч, дэд бүтцийн одоо байгаа хүчин чадлыг бүрэн ашиглах асуудлыг анхаарч, "Мянганы зам" барих ажлын төлөвлөгөөг хянах</li> </ul>	



<b>Хөдөөгийн хөгжил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>◆ Ядуучууд, ялангуяа хөдөөгийн ядуучуудыг дэмжих, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, өмч хөрөнгийг хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах</li> </ul>	
<b>Оролцооны үйл явц</b>	
<ul style="list-style-type: none"> <li>◆ Өргөн оролцоог ялангуяа УИХ-ын гишүүд болон нийгмийн эмзэг бүлгийн оролцоог өргөжүүлэх</li> <li>◆ Гадаадын зээл, тусламжийг хуваарилах, зохицуулахад Засгийн газрын тэргүүлэх үүргийг тусгах</li> </ul>	НҮБХХ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

# **ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗАВСРЫН БАРИМТ БИЧИГ**

**Улаанбаатар 2001 оны Зургаадугаар сар**

## АГУУЛГА

I. Оршил	22
II. Монгол улсын эдийн засаг ба ядуурлын өнөөгийн байдал	
А. Эдийн засаг	23
Б. Ядуурал	26
III. Ядуурлыг бууруулах стратегийн гол бүрэлдэхүүн хэсгүүд	33
А. Ядуурлыг бууруулах ерөнхий стратеги ба макроэдийн засгийн орчин Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт	35
Хувийн хэвшилд тулгуурласан өсөлтийг дэмжих	37
Төсвийн бодлого	38
Б. Хүний тогтвортой хөгжил	41
Б-1. Боловсрол	42
Б-2. Эрүүл мэнд	46
Б-3. Хөдөлмөр эрхлэлт	50
Б-4. Нийгмийн хамгаалал	52
В. Дэд бүтцийн хөгжил	54
В-1. Эрчим хүчний хангамж	54
В-2. Тээвэр	56
В-3. Мэдээлэл ба харилцаа холбоо	57
В-4. Нийтийн аж ахуйн ба ахуйн үйлчилгээ	58
Г. Бүс нутгийн ба хөдөөгийн хөгжил	59
Д. Байгаль орчны хамгаалал	62
Е. Засаглал	66
Ё. Дунд хугацааны зорилтууд	67
IV. ЯБСББ боловсруулах зохион байгуулалтын бүтэц	69
V. ЯБСББ боловсруулах хэрэгжүүлэх оролцоог хангах	71
VI. Ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний үзүүлэлтүүд	72
<b>Хүснэгтүүд:</b>	
1. Ядуурлын үзүүлэлтүүд (хувь)	26
2. Ядуу өрхийн тоо өрхийн тэргүүлэгч ба байршлаар, 1998 (хувь)	28
3. Хөдөлмөрийн насны хүн амын бүтэц, байршлаар, 1998 (хувь)	32
4. Ажил эрхлэлтийн түвшин, 1998 (хувь)	32
5. Нийгмийн салбарын төсвийн зарлагын дүн	41
6. Хөдөлмөрийн насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшингээр, 1998 (хувь)	42
7. Ядуурлын тархалт ундны ус болон дулааны хангамжийн эх үүсвэрээр (хувь)	48
8. Хэрэглээний бүлгээр дундаж орлогын хуваарилалт	51
9. Хүн амын ажил эрхлэлт, жилийн эцэст, 1992-2000 (мянган хүнээр)	53
10. Нийгмийн даатгалын сангаас олгосон өндөр насны тэтгэвэр (2000 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)	53
11. Ядуурлын тархалт гэрэлтүүлэг ба түлшний эх үүсвэр, байршлаар (хувь)	55
12. Макроэдийн засгийн хүрээ, 1997-2004	68
13. Макроэдийн засгийн зарим үзүүлэлтүүд, 1997-2004	74
14. Эрүүл мэндийн салбарын үзүүлэлтүүд, 1990-1999	75
15. Боловсролын салбарын үзүүлэлтүүд, 1990-1999 (хувь)	76
<b>Шигтгээ:</b>	
Баталгаагүй ба эмзэг байдлын хэлбэр	33
<b>Хавсралтууд:</b>	
1. Ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүд	78
2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын хэв загвар (матриц)	79
4. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг боловсруулахад оролцсон хүмүүсийн нэрс	85
5. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулахад шаардагдах мэдээлэл	87
6. Ядуурлыг бууруулах стратегийг боловсруулах ажлын төлөвлөгөө	88

**Мөнгөний тэнцүү чанар** (2001 оны 1-р сарын байдлаар)  
 Мөнгөний нэгж - төгрөг 1097 төгрөг = 1 ам.доллар

<b>Товчлол ба хураангуйлал</b>	
АХБ	Азийн хөгжлийн банк
МБ	Монголбанк
ЭЗХТЗ	Эдийн засгийн харилцан туслах зөвлөл
ЕХ	Европын холбоо
ТБГ	Төсвийн бодлогын газар
ХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ӨЭ	Өрхийн эмнэлэг
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХАБХСЗ	Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ӨОЗС	Өрхийн орлого, зарлагын судалгаа
ЭМЕТ	Эрүүл мэндийн ерөнхий төлөвлөгөө
ЭМСХХ	Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр
ОУХН	Олон улсын хөгжлийн нийгэмлэг
ОУВС	Олон улсын валютын сан
ЯБСЗББ	Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг
ХААТС	Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа
ЭЗСБСБ	Эдийн засаг ба санхүүгийн бодлогын санамж бичиг
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
ХЗДХЯ	Хуульзүй, дотоод хэргийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ДБЯ	Дэд бүтцийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ХААДТ	Хүн амын амьжиргааны доод түвшин
БОЯ	Байгаль орчны яам
УИХГ	Улсын Их Хурлын гишүүн
НИК	Нефть импорт концерн
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ЯБХГ	Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газар
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
ТЗТС	Төсвийн зарлагын тойм судалгаа
ОААТҮС	Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа
ЯБӨХХ	Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр
ЯБСББ	Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг
ТАДТ	Тогтвортой амьжиргааг дэмжих төсөл
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТАСИС	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын техникийн туслалцааны хөтөлбөр
ТСНД	Төрийн сангийн нэгдсэн данс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ДБ	Дэлхийн банк
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

## **I. Оршил**

1. Монгол улс 1990 оноос хүний эрхийг дээдэлсэн ардчилсан нийгмийг цогцлон байгуулах их үйлсийг эхэлж, улмаар нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэл хийж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг эргэлт буцалтгүй сонгосон билээ.

2.Ардчилсан өөрчлөн байгуулалтын сүүлийн 10 жилд Монгол улсын Засгийн газар олон улсын банк, санхүүгийн байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар макро эдийн засгийн үндэс суурийг бүрдүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан нээлттэй эдийн засгийн бүтцийг бий болгоход багагүй ахиц олж байна.

3.Засгийн газраас үнэ, ханш, гадаад худалдааг чөлөөлөх, банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх, бүтцийн өөрчлөлт хийх, төрийн өмчийг хувьчлах, эдийн засгийн үйл ажиллагааг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн хөтлөх эрхзүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх, нийгмийн хамгааллын сүлжээний үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийг тогтворжуулах зэрэг бодлого, арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлж байна.

4.Зах зээлийн харилцаанд шилжих талаар эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээг нийгмийн хөгжлийн чиг хандлага, шилжилтийн үеийн сөрөг үр дагаварыг даван туулахад чиглэгдсэн нийгмийн бодлогыг цогцолбороор хэрэгжүүлээгүйгээс ажилгүйдэл, ядуурал, гэмт хэрэг зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Мөн хөдөө орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломж хомс учраас хүн амын хот руу шилжих хөдөлгөөн ихсэж, хот, суурин газарт ядуурал улам нэмэгдэх, гүнзгийрэх хандлагатай байна.

5.Монгол Улсын Засгийн газар эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, үйл ажиллагааны хөтөлбөр болон бодлогын чанартай бусад баримт бичигтээ тусгасны дагуу дунд хугацаанд ядуурлыг бууруулах зорилт тавин ажиллаж байна. Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт ажилгүйдлийг бууруулах, улсын салбарын удирдлагыг сайжруулах, нийгмийн суурь салбарын үйлчилгээний хүртээмж, хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх зэрэг Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж байна. Бодлогын чанартай энэхүү баримт бичиг нь эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэх, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, олон нийт болон хандивлагчдын оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт Монгол улсын Засгийн газар итгэлтэй байна.

6.Монгол улсын Засгийн газар нь хувийн хэвшилд суурилсан, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогоо дэлхий нийтийн хөгжлийн зорилтуудтай нийцсэн ядуурлыг бууруулах стратегитай уялдуулан хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаж байна.

7.Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичиг нь өнөөгийн эдийн засаг, ядуурлын байдал, ядуурлыг бууруулах бодлогын үндсэн чиглэл, уг бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтын асуудал, оролцоог хэрхэн хангах, хэрэгжилтийг хянах үзүүлэлт зэргийг тусгасан таван хэсгээс бүрдэж байна. Уг баримт бичгийн нэгдүгээр бүлэгт шилжилтийн үйл явцыг нийгэм-эдийн засгийн хөгжлийн үүднээс авч үзэх бөгөөд энэ хүрээнд төрөл бүрийн судалгааны тоо баримтад тулгуурлан ядуурлын дүр төрхийг үнэлэн дүгнэсэн юм. Хоёрдугаар бүлэгт ядуурлыг бууруулах талаар Засгийн газраас дунд хугацаанд баримтлах макро эдийн засаг, нийгэм, дэд бүтэц болон байгаль орчны салбарын хөгжлийн үндсэн зорилтуудыг тодорхойлсон цогц бодлогыг тусгасан болно. Дараагийн хоёр бүлэгт ядуурлыг бууруулах бодлогыг

хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын асуудал, уг бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх явцад иргэд, олон нийтийн өргөн оролцоог хангах асуудлыг тодорхойллоо. Мөн хэрэгжилтийг хянах хяналт-шинжилгээний үзүүлэлт, бодлогын хэв загвар (матриц), статистикийн хүснэгтүүд болон холбогдох бусад баримтуудыг хавсаргасан болно.

## **II. Монгол улсын эдийн засаг ба ядуурлын өнөөгийн байдал**

### **A. Эдийн засаг**

8.Хуучин ЗХУ-аас үзүүлж байсан тусламж зогсож, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагаа задарсан нь Монгол улсын 1990-ээд оны эдийн засгийн байдалд хүндээр нөлөөлөв. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1990-1992 онд 20 гаруй хувиар буурав. Энэ хугацаанд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ мөн 20 хувиар буурав. Импортын хэмжээ эрс багасч, 1990 онд 924 сая ам. доллар байснаа 1992 онд 388.4 сая ам. доллар болов. ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин 1990 онд 32 хувь байсан бол 1992 онд 11 хувь болтлоо буурчээ. Инфляцийн жилийн түвшин 1992 онд оргилдоо буюу 325.5 хувьд хүрсний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин өсч, ажил идэвхтэйгээр эрэлхийлж Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 1992 онд 54.9 мянгад хүрчээ.

9.Эдийн засгийн энэ байдлыг үнэлж Засгийн газраас хуучин тогтолцооны үед хатуу тогтоон мөрдөж байсан бараа, үйлчилгээний үнэ, тарифыг үе шаттайгаар чөлөөлөх, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, банкны хоёр шатлалтай тогтолцоонд шилжих, гадаад худалдааг либеральчлах, валютын хөвөх ханшны тогтолцоонд шилжих, инфляцийг бууруулахад чиглэсэн мөнгө, санхүүгийн хатуу бодлогыг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөн өрнүүлэх талаар холбогдох хууль тогтоомжийг гарган мөрдүүлэх, хувийн хэвшлийг хөгжих таатай орчин бүрдүүлэх зэрэг шинэчлэлийн алхмуудыг эхлүүлсэн юм.

10.Засгийн газраас хэрэгжүүлсэн эдгээр бодлого, арга хэмжээний үр дүнд эдийн засагт сэргэх хандлага ажиглагдах болсон байна. ДНБ-ий хэмжээ 1992 онд 2.5 хувиар буурч байсан бол 1994 онд 2.3 хувиар нэмэгдэж, түүнээс хойш өсч ирлээ. Харин 2000 онд цаг агаарын хүндрэл, шүлхий өвчний тархалт зэргээс шалтгаалж ДНБ-ний өсөлт дөнгөж 1.1 хувь болтлоо өсөлт нь саарав. Инфляцийн түвшин 1992 онд 325.5 хувьд хүрснээ саарч 1994 онд 66.3 хувь болон буурч, 1995-1999 онд дунджаар 27 хувь болсон бөгөөд 2000 оны эцэст 8.1 хувьд хүрэв. Гадаад худалдааны алдагдал 1992 онд 32.0 сая ам. доллартай тэнцэж байсан бол 1994 оноос гадаад худалдааны тэнцэл эерэг болж, 1994 онд гадаад худалдааны тэнцэл 102.6 сая ам. долларын ашигтай байсан боловч 1996 оноос жилд дунджаар 110.0 сая ам. долларын алдагдалтай байх болов. Мөн гадаад валютын албан нөөц 1992 онд 4.6 сая ам.доллартай тэнцэж байсан бол 1994 онд 40.0 сая ам.долларт хүрч нэмэгдэв. Харин 1995-1999 онд гадаад валютын нөөц эрс нэмэгдэж жилд дунджаар 80.0 сая ам.доллартай тэнцэх болж, 2000 оны эцэс гэхэд 140.6 сая ам. долларт хүрэв. Ажилгүйдлийн түвшин 1996 оноос хойш аажмаар буурч Хөдөлмөр зохицуулалтын албаны мэдээгээр 2000 оны эцэст 4.6 хувь болов. Харин хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын тоо баримтаас үзэхэд бодит ажилгүйдлийн түвшин 17 хувь байна.

11.Азийн санхүү, эдийн засгийн хямралын уршгаар зарим нэр төрлийн

бараа, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ эрс унасан нь цөөн нэрийн бүтээгдэхүүн экспортлодог манай улсын хувьд экспортын орлого ихээхэн буурахад нөлөөлөв. Манай улсын 1999 оны экспортын нийт орлогын 33 хувийг бүрдүүлж байсан зэсийн дэлхийн зах зээлийн үнэ 1995 онд нэг тонн нь 3000 ам.долларт хүрч байсан бол 1999 онд 1480 ам.доллар хүртлээ эрс буурав. Үүний зэрэгцээ энэ хугацаанд алт, ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ ч буурлаа. Гадаад худалдааны тэнцэл 1995 онд 58.0 сая ам.долларын ашигтай байсан бол 2000 онд 141.9 орчим сая ам.долларын алдагдалтай болов.

**12.**Гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс гадна өнгөрсөн 1999-2000 оны өвөл, хавар байгаль, цаг уурын байдалд огцом өөрчлөлт гарч, цас их орж зуд нүүрлэснээс нийт малын 10.4 хувь буюу 3.5 сая толгой мал хорогдож, 2.7 сая мал хээл хаясан байна. Үүний уршгаар эдийн засагт зонхилох хувь эзэлдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс буурч, улмаар эдийн засгийн өсөлтийн хурдцыг сааруулан олон зуун малчдын өрхийн амьжиргаанд хүнд цохилт болов.

**13.**Удирдлагын болон байгууллагуудын чадавх хангалтгүйгээс төдийлөн тогтворжоогүй макро эдийн засгийн орчинд сөргөөр нөлөөлөв. Өмч хувьчлал, түүний ач холбогдол, хэрэгжүүлэх арга замын талаар ард түмэнд дутуу ойлгуулсан, шинээр хувьчилж авсан эзэд бизнес эрхлэх удирдлагын чадвар сул, зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийн хомсдолоос улбаалан ард түмэн өмч хувьчлалын явцыг төдийлөн дэмжээгүй юм. Мөн эргэлтийн хөрөнгийн гачаалаас шалтгаалан аж ахуй эрхлэгчид, ялангуяа тоног төхөөрөмжөө шинэчилж чадахгүйд хүрч, зарим аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоосны гадна түүхий эд, технологийн нийлүүлэлт тасарснаар ашигтай ажиллаж байсан зарим үйлдвэр, салбарын үйл ажиллагаа зогсох буюу доголдоход хүрсэн байна.

**14.**Төсөвт татварын орлого 1998 онд багасгасан нь гадаад худалдааны нөхцөл муудсанаас үүдэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон ногдол ашгийн орлогын хэмжээ эрс буурсантай холбоотой юм. Ийнхүү үнийн уналтаас шалтгаалан төсвийн орлого эрс буурч байхад төсвийн зарлагыг хэмнэх тал дээр дорвитой арга хэмжээ аваагүйгээс улсын санхүүгийн чадавхи улам муудсан байна. Үүний зэрэгцээ санхүүгийн байдлыг хүндрүүлэх өөр нэг шалтгаан бол банкны салбар дахь хямрал юм. Өнгөрсөн 1996 оноос хойш нийтдээ 12 банк дампуурч эдгээрийн заримынх нь хохирлыг нөхөх зорилгоор гаргасан бондын хүүгийн төлбөрт 9 тэрбум төгрөг төлсөн нь төсвийн ачааллыг улам нэмэгдүүлжээ. Арилжааны банкуудаас олгосон зээлийн 30 орчим хувь нь 2000 оны байдлаар чанаргүй зээлийн ангилалд орсон байна. Мөн хөрөнгө оруулалтын хэмжээ ДНБ-ний 24 хувьд хүрч, түүний үр өгөөж маш доогуур хэвээр байна.

**15.**Дээр дурьдсан гадаад худалдааны таагүй нөхцөл, төсвийн хэт өндөр ачааллаас шалтгаалан төсвийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувь жил бүр нэмэгдэж 1996 онд 7,9 хувьтай байснаа 1998 онд 14,3 хувь, 1999 онд 12,0 хувьд хүрчээ. Төсвийн алдагдал 2000 оны байдлаар ДНБ-ий 6,8 хувьтай тэнцэж байв. Өөрөөр хэлбэл төсвийн орлого байнга буурч, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн өртөг хэт өндөр байснаас хамааран ядуучуудад чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээний зардал улам багассан байна. Монгол улсын гадаад өр 1996 онд ДНБ-ий 46 хувьтай тэнцэж байсан бол 1999 онд 94 хувьд хүрэв.

**16.**Өнгөрсөн 10 жилийн хугацаанд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн явцад нэлээд ахиц гарсан гэж дүгнэх боломжтой юм. Монгол

улсын эдийн засаг сүүлийн 6 жил дараалан өсч, инфляцийн түвшин нэг оронтой тоонд хүртэл буурлаа. Эдийн засгийн хүрээнд хэрэгжсэн бүтцийн өөрчлөлтийн дүнд эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж, ДНБ-ийн 70 гаруй хувийг үйлдвэрлэх болов. Монгол улсын эдийн засгийн нээлттэй байдал улам өргөжиж, Монгол улсын иргэд амьдралаа өөрийн хүсэл эрмэлзлийн дагуу зохиож, эрхэм зорилгодоо хүрэх эрх, эрх чөлөөт боломжоор хангагдан, чөлөөт өрсөлдөөний зарчмаар бизнес эрхлэх таатай орчин бүрдэж эхлэв.

**17.** Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгмийн салбарын хөгжлийг түргэтгэхэд шийдвэрлэвэл зохих асуудлууд байсаар л байна. Экспортын хэт өрөөсгөл бүтэц нь эдийн засгийн гадаад орчны нөлөөлд хэтэрхий өртөмтгий байдалд хүргэж, дотоод эргэлтийг хангахад одоогийн хүрсэн эдийн засгийн өсөлт хангалтгүй байна. Эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэх банкны тогтолцоо сул хэвээрээ байгаа бөгөөд төрийн өмчийн оролцоотой банкууд давамгайлсаар байна. Энэ нь банкны салбарт хувийн хэвшилд итгэх итгэлийг сулруулж, гадаадын хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлаж байна. Хувьчлагдсан аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны ашиг доогуур, хүний нөөц болон удирдлагын чадавх сул байна. Төрийн оролцоо, удирдлага, хяналт хангалтгүйгээс шалтгаалан боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээ сул, нийгмийн халамжийн сүлжээний хүртээмж муу байна.

## Б. Ядуурал

**18.** Хүн амын амьжиргааны түвшингийн 1998 онд явуулсан судалгаанаас үзэхэд өнөөдөр монголын хүн амын 36 хувь нь ядуу байна. Ядуурлын түвшин 1994-2000 оны хооронд нэмэгдээгүй боловч ядуурал гүнзгийрч, орлогын тэнцвэрт байдал улам алдагдсаар байна. Монголд хийгдсэн (ХААТС, ОААТҮС) судалгаанаас үзэхэд дараах таван бүлгийн хүмүүс 1) олон хүүхэдтэй, ганц бие өрх, 2) 100-аас доош малтай өрх (өрхийн гишүүдийн тоо болон бүтцээс хамаарч), 3) ажилгүйчүүд, 4) боловсролгүй (суурь боловсролгүй) хүмүүс, 5) эмзэг бүлэгийнхэн (өндөр настан, тахир дутуу, гудамжны болон өнчин хүүхдүүд) ядууралд өртөх нь элбэг байдаг байна.

### Хүснэгт 1. Ядуурлын үзүүлэлтүүд (хувь)

	Хамралтын хүрээ, P0		Гүнзгийрэлтийн индекс, P1		Ялгааны индекс, P2	
	1995	1998	1995	1998	1995	1998
Хот	38.5	39.4	12.2	13.9	5.7	7.1
Улаанбаатар	35.1	34.1	10.4	13	4.5	7.4
Хөдөө	33.1	32.6	8.9	9.8	3.6	4.4
Улсын дүн	36.3	35.6	10.9	11.7	4.8	5.6

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

**19.** Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор манай улсын нутаг дэвсгэрт 541.1 мянган өрхөд 2373.5 мянган хүн байнга оршин сууж байна гэсэн дүн гарлаа. Нийт хүн амын 56.6 хувь нь хотод, 43.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Хүн амын нийт дүнд эмэгтэйчүүд 50.4 хувь, эрэгтэйчүүд 49.6 хувийг тус тус эзэлж байна.

**20.** Монгол улсад Өрхийн орлого, зарлагын судалгааг 1966 оноос явуулж эхэлсэн юм. Өрхийн нийт тоо нэмэгдэхийн хэрээр түүвэрлэлтэд хамрах өрхийн



тоо 1000-1500 өрх болж өргөжсөн юм. Уг судалгааны явцад зөвхөн орлого, зарлагын хэмжээг тодорхойлохоос гадна орлогын эх үүсвэр, хэрэглээний загвар, амьжиргааны түвшин, түүний доод хэмжээг тогтоодог. Өрхийн орлого, зарлагын судалгаа нь ядуурлын түвшин, инфляци болон үндэсний тооцоо зэрэг статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох суурь болдог учраас энэ судалгааны аргачлал, хамрах хүрээг оновчтой болгох шаардлагатай байна. Одоогоор Үндэсний статистикийн газар нь Дэлхийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Өрхийн орлого, зарлагын судалгааг ядуурлын талаар дүгнэлт гаргах суурь мэдээлэл болгох чиглэлээр боловсронгуй болгохоор ажиллаж байна. Ядуурлын талаар гаргасан анхны судалгаа бол 1994 онд ҮСГ-аас явуулсан ядуурлын үзлэг юм. Үзлэгийн дүнгээр 1994 онд нийт хүн амын 26,5 хувь ядуу байсан гэсэн тоо гарсан юм. Ядуурлын шугамыг амьжиргааны доод түвшингээр тогтоодог юм. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуульд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшинг 2000 оны 12 дугаар сарын эцэст 14700-19300 төгрөг гэж зарласан юм. Харин уг түвшингийн 40 хувиас доош орлоготой буюу хүнснийхээ наад захын хэрэгцээг хангаж чадахгүй өрхийг нэн ядуу өрх гэж тодорхойлдог.

**21.** Монгол Улсын төрөөс хүн амын амьжиргааны байдлын талаар олон улсын байгууллагуудын тусламж дэмжлэгтэйгээр хэд хэдэн судалгаа явууллаа. Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох анхны судалгааг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 1995 онд явуулсан юм. Энэхүү судалгаагаар монголын хүн амын 36 хувь ядуу амьдралтай байна гэсэн дүн гарсан болно. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Үндэсний статистикийн газраас 1998 онд явуулсан Хүн амын амьжиргааны түвшинг тогтоох хоёр дахь судалгааны дүнд Монгол Улсын хүн амын 35.6 хувь, хот суурин газрын хүн амын 39.4 хувь, хөдөөгийн хүн амын 32.6 хувь ядуу амьдарч байна гэсэн дүн гарлаа. Хэдийгээр дээрх хоёр судалгааны дүнг шууд харьцуулах боломжгүй боловч ядуурлын байдлыг харуулах үүднээс судалгааны дүнг харьцуулж үзэв. Өөрөөр хэлбэл, 1995 оны судалгааны дүнтэй харьцуулахад 1998 онд ядуу хүн амын хамралтын хүрээ Улаанбаатар хотод буурч, бусад хот, суурин газарт өссөн байна. Ялангуяа ядуурал аймгийн төв, хот суурин газарт илүүтэй төвлөрч байгааг судалгааны дүн харууллаа. Энэ судалгааны дүнгээс үзвэл:

◆ Ядуу хүн амын хэрэглээний ялгааг илэрхийлдэг хэрэглээний гүнзгийрэлтийн индекс 9.8-13.9 хувьд хүрч, ядуурлын ялгааны индекс 1995 оноос 0.8-2.9 нэгжээр өссөн байна.

◆ Орлогын тэнцвэргүй байдлын илэрхийлэл Жини коэффициент 1995 онд 0.31 хувь байсан бол 1998 онд 0.35 хувь болж өссөн байна.

→ Ядуурал нь ажил эрхлэлттэй шууд холбоотой байна. Хот, суурин газрын хөдөлмөрийн насны ядуу хүн амын 27.3-38.8 хувь нь ажил эрхлээгүй байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажилгүйчүүдийн 60 шахам хувийг ядуучууд эзэлж байна.

→ Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний зардал ядуу айл өрхийн амьжиргаанд дарамт болж, эрүүл мэнд, боловсролын суурь үйлчилгээг хүртэж чадахгүйд хүргэж байна. Тухайлбал, өрхийн орлогоос боловсролд зориулан зарцуулж байгаа зардал 1998 онд 1995 оныхоос 4-5 дахин нэмэгдэж, хүнсний бус зардалд эзлэх хувийн жин 9.3 нэгжээр өссөн байна. Мөн 8-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин 87.3 хувь, сургууль завсардалт 9.3 хувь байна. Сургууль завсардалт хөдөөд илүүтэй байгаа бөгөөд сургууль завсардсан хүүхдүүдийн 43.8 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй байна.

→ Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг чинээлэг өрхүүд ядуу өрхүүдтэй

харьцуулахад илүү хүртэж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний сарын дундаж зардлыг хэрэглээний түвшингээр авч үзвэл хамгийн өндөр орлоготой бүлгийн нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал нэн ядуу хэсгийнхний зардлаас 9 дахин их, ядуу хүний эмнэлгийн байгууллагад хандах давтамж ч буурсан байна. Өрхийн байршлаас хамаарахгүйгээр ядууралд олон ам бүлтэй, мөн эмэгтэй тэргүүлэгчтэй өрх илүү өртөж байна. Тухайлбал, нэн ядуу өрхийн 24.6 хувь, ядуу өрхийн 18.3 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

## Хүснэгт 2. Ядуу өрхийн тоо, өрхийн тэргүүлэгч ба байршлаар, 1998 (хувь)

Өрхийн тэргүүлэгч, хүйсээр	Нийслэл	Аймгийн төв	Сум	Хөдөө
Эрэгтэй	21.4	39.1	28.5	25.2
Эмэгтэй	43.8	53.2	51.7	23.6

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

◆ Хүн амын орлогын гуравны нэг нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, 20 гаруй хувь нь хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэлийн орлогоос, 30 хувь нь өрхийн өөрийн хувийн аж ахуйгаас, 10 хувь нь бусдаас үнэгүй авсан хэрэглээнээс бүрдэж байна. Энэ нь өрхийн байршлаас ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, хот, суурин газрын хүн амын орлогын 40-60 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж эзэлж байхад хөдөөгийн хүн амын орлогын дөнгөж 7 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж, 60-аад хувийг өрхийн аж ахуйн орлого эзэлж байна. Харин ядуу хүмүүсийн орлогын гол эх үүсвэр нь цалин, тэтгэвэр, тэтгэмж байна. Монгол Улсын хүн амын суурьшил, ажил эрхлэлтээс голлон хамаарч хүн амын орон сууцны төрөл, хэрэглээ ялгаатай байдаг. Мал аж ахуй эрхлэн жилийн дөрвөн улиралд нүүдэллэн явдаг хөдөөгийн хүн амын дийлэнх нь гэр сууцанд амьдардаг байхад хот, суурин газрын хүн амын тодорхой хэсэг нь байшин сууцанд амьдарч байна. Хот, суурин газарт ядуучуудын дийлэнх нь гэрт амьдарч байгаа бөгөөд энэ нь сууцны зардал, төлбөртэй шууд хамааралтай юм. Хөдөөгийн өрхүүдийн дийлэнх нь энгийн халаалттай гэр сууцанд амьдардаг бөгөөд 27-30 орчим хувь нь хамгаалалтгүй худгаас ундны усны хэрэгцээгээ хангаж байна.

**22.** Эрүүл мэнд, боловсролын салбарт олсон ололтууд саарч, иргэдийн орлого буурч, гэр бүлийн амьдралд хүндрэл бэрхшээл тулгаран гэмт хэрэг, зөрчил нэмэгдэж байсан үед Засгийн газар НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын байгууллагууд, монголыг дэмжигч орнуудтай удаа дараа зөвлөлдсөний үндсэн дээр 1994 оны 6 дугаар сард Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ЯБҮХ)-ийг боловсруулан баталж хэрэгжүүлж эхэлсэн юм. Төвлөрлийг сааруулах, олон нийтийн оролцоог хангах зарчимд тулгуурлан олон салбарыг хамарсан тус хөтөлбөр нь хүн амын амьжиргааны түвшин муудах, хүний нөөцийн чадамж доройтох хандлагыг багасгах гол зорилготой байлаа.

**23.** ЯБҮХ-ийн хүрээнд эмзэг бүлгийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар ажлын түр байр бий болгох, сургуулийн өмнөх болон суурь боловсролыг дэмжих, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн суурь үйлчилгээг сайжруулах, насанд хүрсэн тахир дутуу иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тэднийг хамруулах болон тахир дутуу хүүхдэд боловсрол олгох зэрэг 13 мянга гаруй жижиг төслийг алслагдсан сум, хороо, багт хэрэгжүүлэв. Эдгээр төслийг

хэрэгжүүлэх үүсгэл санаачилга орон нутгаас гарч байсан нь онцлог юм.

#### **24.Хөтөлбөрийн хэрэгжилтээс дараах үр дүн харагдаж байна. Үүнд:**

◆Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ядуурлыг бууруулах төслүүд нь ядуу хүмүүсийн амьдралд эдийн засаг, нийгмийн үр нөлөөгөө үзүүлж, үр ашгаа өгсөөр байна. Хүн амыг орлого бий болгох төсөлд хамруулах болон нийтийг хамарсан ажлын явцад түр ажлын байраар хангах замаар ядуу өрхийн 30 гаруй хувийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүллээ. Тэдний ихэнх нь ур чадвар, бизнесийн мэдлэг шинээр эзэмшиж, өөрөө өөртөө итгэлтэй аж төрж, улмаар ядуурлаас гарсан нь энэхүү хөтөлбөрийн гол үр дүн юм.

◆Малчин ядуу өрхүүдийн амьжиргааны тогтвортой байдлыг хангах зорилгоор 2200 гаруй малчин өрхөд 107 орчим мянган толгой малыг гэрээгээр олголоо. Малжуулах төслийн зэрэгцээгээр малчин өрхийн зарим хэсэг нь газар тариалан давхар эрхлэн өөрсдийн ахуй амьдралаа дээшлүүлж байна.

◆Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа орлого бий болгох үйл ажиллагаанаас эмэгтэйчүүд ихээхэн хэмжээний ашиг хүртэж байна. Орлого нэмэгдүүлэх төсөлд хамрагдаж байгаа нийт хүмүүсийн 65 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүний зэрэгцээ төрийн бус байгууллагуудаар дамжуулан төсөл боловсруулах болон төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслүүд, мөн хөдөөгийн эрүүл мэндийн төслүүд, нэн ялангуяа эхчүүдийн амрах байрыг тохижуулах төслөөс эмэгтэйчүүд ашиг хүртэж байна.

◆Нийтийг хамарсан ажлын төслүүд нь ажлын түр байр бий болгохоос гадна орон нутгийн эдийн засаг болон нийтийн эрүүл мэндэд урт хугацааны туршид үр нөлөөгөө үзүүлж байна. Зам гүүр, далан, усгалтын суваг зэрэг нь хөдөөгийн хүн амд удаан хугацааны туршид үр ашгаа тогтвортой өгч байна. Түүнчлэн ундны усан хангамж, нийтийн халуун ус болон халаалтын сүлжээ, орчны ариун цэврийн төслүүд нь эрүүл энх, сайн сайхан байдлыг хангахад тодорхой хувь нэмэр орууллаа.

◆Суурь болон сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх, хөдөөгийн эрүүл мэндийг сайжруулах төслүүдийг улсын хэмжээнд хэрэгжүүлснээр сургууль, цэцэрлэгт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг багасгах, эх нялхсын эндэгдлийн түвшинг бууруулахад дэмжлэг үзүүлж байна.

**25.Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд, гадаад орнуудын дэмжлэг туслалцаатайгаар эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, байгаль орчны салбарт цөөнгүй хөтөлбөр, төсөл хэрэгжүүлснээр манай улсын ядуурлын хурдац саарсан хэдий ч дорвитой буураагүйгээс ядуурал нь өнөөгийн тулгамдсан асуудал хэвээр байна. Ядуурлыг бууруулах болон нийгмийн чиглэлийн бусад хөтөлбөр, төслүүдийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох зэрэг өргөн хүрээний бодлоготой уялдуулан цогцолбороор авч үзэх нь зүйтэй гэсэн сургамжийг авлаа.**

**26.Ядуурлыг бууруулах болон нийгмийн чиглэлийн бусад хөтөлбөр, төслүүдийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, инфляцын түвшинг тогтворжуулах, банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох зэрэг өргөн хүрээний бодлоготой уялдуулан цогцолбороор авч үзэж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн сургамжийг авлаа. Энэ нь өөрөөр хэлбэл ядуурлыг бууруулах**

хөтөлбөрийн ойлголт, зарчмууд нь хичнээн ул суурьтай байсан ч үүнийг өргөн хүрээтэй, хүний хүчин зүйлсэд чиглүүлсэн бөгөөд ажлын байр ихээхэн шаардсан өсөлтийн стратегитэй уялдуулахгүй, ийм стратегид суурилуулахгүйгээр ядуурлыг дорвитой бууруулахгүй гэсэн үг. Энэ ажлын хүрээнд хөдөө орон нутагт банк, санхүүгийн шуурхай үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий банкны салбарыг хөгжүүлж, бэхжүүлэх асуудал тавигдаж байна. Хөдөө орон нутгийн банкууд орон нутагт бэлэн мөнгө болон хуримтлалыг бий болгосноор мөнгөн хөрөнгийн хөрвөлт болон бартерийн худалдааны асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх юм. Нөгөө талаас одоогийн байгаа байгууллагуудын бүтэц, чадавхийг хэвээр нь байлгах буюу хөгжүүлэх шаардлагатай байна.

**27.** Ядуурлыг 1994 оноос 1999 оныг хүртэлх хугацаанд ихэвчлэн тоон үзүүлэлтэд тулгуурлан үнэлдэг байсан бол саяхан эхэлсэн Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа нь ядуурлыг чанарын хувьд авч үзэх боломжийг олголоо. Энэ судалгаа нь бүхэлдээ оролцооны аргад тулгуурласан бөгөөд ингэснээр Засгийн газарт ядуучуудын дуу хоолой, тэдний байдал, мөн чанар болон түүнийг сайжруулахаар баримталж буй бодлогын талаар ядуучуудын үнэлгээ, дүгнэлтийг сонсох боломжийг олгосон юм.

**28.** Үндэсний статистикийн газар 2000 онд Дэлхийн банк болон бусад хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа явуулав. Энэ судалгааны зорилго нь ядуурлын талаархи статистикийн тоо мэдээллийг чанарын үзүүлэлтүүдээр баяжуулах, өмнө нь 1995, 1998 онд хийгдсэн Ядуурлын үнэлгээ болон Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаанд нэмэлт мэдээлэл өгөхөд оршино. Энэ нь үндэсний хэмжээнд оролцооны аргаар явуулсан анхны судалгаа юм.

**29.** Энэ судалгаанаас үзэхэд хүн амын амьжиргааны түвшин 1992 оныг хүртэл харьцангуй жигд байлаа. Харин 1992-1995 онд шинээр баян, ядуу хүмүүс бий болж, 1995-2000 оны хооронд баян ядуугийн зөрүү улам даамжирсан байна. Уг судалгаанаас үзэхэд хотын хүн амын нэлээд хэсгийг ядуу болон нэн ядуу хүмүүс эзэлж байна гэжээ. Дундаж амьдралтай өрхийн тоо 1992-1995 онд багассан гэсэн судалгааны таамаглалыг энэ хугацаанд ядуу болон нэн ядуу өрхүүдийн тоо нэмэгдсэн гэсэн судалгаанд оролцогчдын дүгнэлт нотолж байна.

**30.** Энэ судалгаагаар хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлогч үзүүлэлтүүдийг эдийн засгийн, нийгмийн, эрүүл мэндийн, биеийн болон сэтгэлзүйн гэж ангилсан юм. Эдийн засгийн үзүүлэлтэд малын тоо, усны эх үүсвэр, бэлчээрт хүрэх зай, ажил буюу бизнес эрхэлж байгаа байдал, орон сууц эзэмшиж байгаа эсэх, өр ширгүй эсэх, тэтгэвэр, тэтгэмжээ цаг тухайд авч чадаж байгаа зэрэг орж байна. Нийгмийн үзүүлэлтүүдэд гэр бүлийн гишүүдийн тоо, хүүхдүүд боловсролд хамрагдах бололцоотой эсэх, өөрөө өөрийгөө хангах, хамаатан садан ба анд нөхөддөө туслах бололцоотой, баталгаатай амьдрал, амьдралын тайван нөхцөл хангагдсан зэрэг орж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь хүн амын амьдралын хэв маяг болон нөхцөл байдлаас ихээхэн хамаарна. Тухайлбал, хөдөөгийн хүмүүс сайхан амьдралыг малын тоо толгой, бэлчээр, усны хүрэлцээг чухалчлан үзэж байхад хот, суурин газрын хүмүүсийн хувьд энэ нь ажлын байр, худалдаа наймаа хийх орчин, эрүүл мэнд, бие сэтгэлийн аюулгүй байдалтай холбон тодорхойлж байна.

*"Аз жаргалтай сайн сайхан амьдрал гэдэг нь хувь хүн бие даан амьдралаа авч явах, гэр бүлийнхээ хэрэгцээг хангах, хэнээс ч хамаарахгүйгээр хувийн*

амьдралаа шийдвэрлэж чаддаг байх, үр хүүхдүүдээ боловсролтой болгож, эрүүл саруул амьдрахыг хэлнэ" гэж Хөвсгөл аймгийн Баянзүрх сумаас судалгаанд оролцсон хэсэг эмэгтэйчүүд тодорхойлжээ.

"Ажиллаж, эрүүл саруул, идэх хоолтой, өмсөх хувцастай, нийгэмтэйгээ хөл нийлүүлж алхаж чадаж байвал сайн амьдарч байна гэсэн үг" гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумаас судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлсон байна.

"Муу муухай амьдрал гэдэг нь хүүхэд, залуучууд нь боловсрол мэдлэггүй, өвчин зовлон нүүрлэсэн, бие бялдар оюун ухааны хэрэгцээгээ хангаж чадахгүй, ирээдүйдээ итгэлгүй амьдрахыг хэлнэ" гэж Төв аймгийн Жаргалант сумаас судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.

"Миний өр нэмэгдэж, түүнийг төлж чадахаа больж, хэмжээ нь тэнгэрт байгаа од шиг тоо тоймгүй болсон доо " гэж Өмнөговь аймгийн Сэврэй сумын ядуу эмэгтэй хэлсэн байна.

**31.**Судалгаанаас үзэхэд ядуу хүмүүсийн тоо хаа сайгүй нэмэгдсэн ба үүний шалтгаан нь үйлдвэр, аж ахуйн нэгжүүд олноороо дампуурсан, хүмүүс ажилгүй болсон, хоршоод хаагдсан, өмч хувьчлалын явцад ихээхэн алдаа гарсан, худалдааны хуучин сүлжээ үйл ажиллагаагаа зогсоосон, эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээ төлбөртэй болсон зэрэгтэй холбоотой байна. Одоо орлогын үндсэн эх үүсвэр нь тэтгэвэр болон тэтгэмж болохыг оролцогчид нотолж байлаа. Ядуурлын шалтгааныг ангилсан байдал нь ялангуяа ажилгүйдэл, бизнесийн орчин таатай бус, хувийн хэвшлийн салбарын боловсон хүчний эрэлт хэрэгцээ нь ажилгүйчүүдийн чадавхтай тохирохгүй зэрэг гэж тодорхойлогдсоноороо Хүн амын амьжиргааны түвшингийн судалгааныхтай ижил төстэй байлаа. Судалгаанд оролцогчид ядуурлаас үүдэн гарах үр дагаварт хүүхдийн сургууль завсардалт, эрүүл мэнд доройтох, тахир дутуу болох, сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөх, орон гэргүй болох, гэр бүл салах, өрх толгойлсон ганц бие эцэг, эх олшрох, архидалт ихсэх, өр зээлд баригдах, өлөн зэлмүүн хооллох зэргийг оруулсан байна.

**32.**Уг судалгаа нь ядуурлын шалтгаан нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад ажилгүй болох, орлого хэт доогуур орохтой холбоотой гэдгийг харууллаа. Орлогын ядуурал даамжрахад хүний аюулгүй байдал алдагдах, ядуучууд үйлчилгээнд хамрагдах нь хомсдох, засаглал хямрах, авилгал газар авах зэрэг ядуурлын бусад төрлүүдийг үүсгэдэг тул орлогын ядууралд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

### Хүснэгт 3. Хөдөлмөрийн насны хүн амын бүтэц, байршлаар, 1998 (хувь)

Орлогын бүлгээр	Ажиллагчид	Ажилгүйчүүд	Бусад	Бүгд
<b>Хөдөө</b>				
1. Нэн ядуу	37.6	38.8	23.6	100.0
2. Ядуу	48.3	27.3	24.4	100.0
3. Ядуу бус (бага зэрэг)	49.9	19.3	30.8	100.0
4. Ядуу бус (дунд зэрэг)	55.2	13.2	31.6	100.0
5. Ядуу бус (чинээлэг)	58.6	9.0	32.4	100.0
Бүгд	49.8	21.4	28.8	100.0
<b>Хот</b>				
1. Нэн ядуу	58.4	26.5	15.1	100.0
2. Ядуу	79.6	11.9	8.5	100.0
3. Ядуу бус (бага зэрэг)	83.3	6.5	10.1	99.9
4. Ядуу бус (дунд зэрэг)	81.3	7.2	11.5	100.0

5. Ядуу бус (чинээлэг)	80.8	4.4	14.8	100.0
Бүгд	77.9	10.3	11.8	100.0
<b>Улсын дүн</b>	<b>65</b>	<b>15.4</b>	<b>19.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

**Хүснэгт 4: Ажил эрхлэлтийн түвшин, 1998 (хувь)\***

	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус (бага зэрэг)	Ядуу бус (дунд зэрэг)	Ядуу бус (чинээлэг)
Хот, суурин газар	44.7	66.0	75.8	78.7	92.8
1995	49.2	63.9	72.2	80.7	86.8
1998	65.0	85.9	92.9	95.8	92.7
Хөдөө	68.0	87.0	92.7	91.8	94.8
1995					
1998					

\*Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэж буй хүнийг хөдөлмөрийн насны нийт хүн амд харьцуулав (1995 оны Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа)  
Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

**33. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаанд** хамрагдсан хүмүүс өрхийн эдийн засгийн баталгаагүй байдлаас гадна нийгэм, аюулгүй байдал, байгаль орчин, бие бялдрын баталгаагүй байдлыг тодорхойлжээ. Эдийн засгийн баталгаагүй байдал хамгийн гол нь ажилгүйдэл, зах зээлээс алслагдмал байдлаар илэрхийлэгдэж байгаа бөгөөд үүнээс үүдэж олон өрхийн хувьд тэтгэвэр, тэтгэмж нь тогтмол бэлэн мөнгөний орлогын цорын ганц эх үүсвэр болж байна. Олон нийтийг хамарсан арга хэмжээ, хөрөнгө оруулалт нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, хөдөө аж ахуйн уналтыг бууруулахаас гадна *байгаль орчны баталгаагүй байдал нь мал аж ахуйд муугаар нөлөөлж байна*. Малчид болон малын тоо өссөн боловч нутаг бэлчээр сэлгэн нүүх нь багассан нь бэлчээрийг талхлахын зэрэгцээ байгалын гамшиг, зуд, ой хээрийн түймэр, хортон мэрэгчдийн хор нөлөө байдлыг улам дордуулж байна. Байгаль орчны баталгаагүй байдалд ялангуяа шинээр малчид болсон хүмүүс илүүтэй өртөж байна. *Нийгмийн баталгаагүй байдал нь садан төрлийн холбоог алдагдуулахад хүргэж байна*. Ер нь 1990-ээс оноос садан төрлийн холбоо суларч айлууд хоорондоо хагас арилжааны маягтай харилцах нь нэмэгдсэн байна. Садан төрөл нь холдсон, нийгмийн сүлжээнд хамрагдаж чадахаа больсон айлууд хамгийн эмзэг байдалтай болов. Олон өрх, ялангуяа ядуу өрх *бие бялдрын баталгаагүй* нөхцөлд орж байна. Ажилгүйдэл, эдийн засгийн баталгаагүй байдлын улмаас нийгмийн эмх цэгц алдагдаж, архидалт, гэмт хэрэг өсч гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт ихэсч байна. Энэ бүх баталгаагүй байдал нэлээд өрхүүдэд том цохилт болж, дарамтанд олон хүнийг оруулж, ядуурал руу хөтөлсөөр байна.

**Шигтгээ 1. Баталгаагүй ба эмзэг байдлын хэлбэр**

Эдийн засаг	Ажилгүйдэл, зах зээлээс тусгаарлагдсан/алслагдсан байдал, худалдааны, арилжаа наймааны таатай бус нөхцөл, үнийн тогтворгүй байдал, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь төлөхгүй байх, бэлэн мөнгөний дутагдал, үндсэн хөрөнгө алдах болон өрөнд орох
-------------	---

Нийгэм	Нийгмээс тусгаарлагдах, ураг төрлийн холбоо сулрах, итгэл алдрах, хамтран ажиллаж чадахгүй байх, шинэ малчдын туршлагагүй байдал
Байгаль орчин	Бэлчээрийн талхлалт, бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийн хомсдол, бэлчээр булаацалдах, зуд, ган, үер, шороон болон элсэн шуурга, тал хээрийн түймэр, хортон мэргэчдийн хэт их тархалт, худаг усны болон өвөлжөөний хомсдол
Эрүүл мэнд	Архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, хулгай (ялангуяа малын хулгай), чанар муутай ундны ус, импортын хүнсний бараа, эм хэрэгсэл, ариун цэвэр, эрүүл ахуй муудаж, биеэ үнэлсэнээс эрүүл мэндийн эрсдэлд орох

Эх сурвалж: Оролцооны аргаар амьжиргааны түвшинг үнэлэх судалгаа, 2000

**34.** Монгол улсын нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн 1993 онд 390 ам. доллар байсан бол 1998 онд 380 ам. доллар болж буурч, дэлхийн 206 орноос 165-р байрт орсныг Дэлхийн банкны илтгэлд дурьджээ. Түүнчлэн Монгол Улсын хүний хөгжлийн индекс 1995 онд 0.669 байснаа 1998 онд 0.628 болж, Монгол Улс 1995 онд дэлхийн 174 орноос 101-р байрт байснаа 1998 онд 117-р байрт орж ухарсан байна.

### **III. Ядуурлыг бууруулах стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд**

**35.** Монгол Улсын Засгийн газар ядуурлыг бууруулах, Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хооронд Ядуурлыг бууруулах талаарх түншлэлийн гэрээг байгууллаа. Уг гэрээний гол зорилго нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын боловсруулсан "Стратеги-21" баримт бичигт тусгагдсан ядуурлыг бууруулах, хүний нөөцийг хөгжүүлэх олон улсын шалгуур үзүүлэлтүүдийг хангахад оршино. Монгол Улсын Засгийн газар 2005 онд нэн ядуу хүний тоог 25 хувиар, 2015 онд 50 хувиар бууруулах; амьжиргааны доод түвшингээс бага орлоготой хүний тоог 2005 онд 50 хувиар, 2015 онд дахин 25 хувиар бууруулах; 2005 онд нийт хүн амыг бага боловсрол эзэмшүүлэх, нярай болон 5-аас доош насны хүүхдийн эндэгдлийг 50 хувиар бууруулах зэрэг олон улсын хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэн эдгээрийг хангахад хүч чармайлт тавин ажиллаж байна.

**36.** Засгийн газраас дунд хугацаанд баримтлах макро эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөртөө хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зорилгоо хэрхэн хангах талаар тусгасан юм. Монгол улсын ядуурлыг бууруулах стратеги нь эдийн засгийн өсөлтийн дүнд бүрэлдсэн хуримтлалыг нийгмийн салбарын хөгжлийг түргэтгэх, хүн амд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад чиглүүлэх зорилготой юм. Эдийн засгийн өндөр өсөлтийг макро эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй шинэчлэлийг гүйнзгийрүүлэх, хувийн бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хангах болно.

**37.** Эдийн засгийн өндөр өсөлт нь хүн амын ядуурлыг бууруулах чухал хүчин зүйл боловч нөгөө талаас төр засаг, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа ч гол нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм. Улс орны хөгжилд иргэний

нийгмийн оролцоог аль болох өргөжүүлэх зорилгоор иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх талаар Засгийн газраас анхаарах ёстой. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулахад хүн ам, тэр дундаа нэн ядуу иргэдийн эрх, үүргийг хамгаалах асуудлыг өргөн тусгах үүднээс төр засаг, иргэний нийгмийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх болно. Иймээс Засгийн газраас боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулахаар дэвшүүлж буй зорилтуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын хүч чармалтайгаар хэрэгжүүлэх болно. Малчдын ядуурлыг бууруулах асуудал нь ихэвчлэн малчдын бүлэг буюу орон нутгийн хоршоодын бэлчээр болон мал аж ахуй, түүний эрсдлийн удирдлагыг сайжруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

## **А. Ядуурлыг бууруулах ерөнхий стратеги ба макро эдийн засгийн орчин**

**38.**Засгийн газрын макро эдийн засгийн бодлого нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өндөр хурдацтай өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад чиглэсэн дунд хугацааны хүрээнд боловсрогдсон юм. Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах гурван жилийн хугацаатай хөтөлбөр нь хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Иймд хөтөлбөрийн хугацаанд ДНБ-ий жилийн өсөлтийг 4-6 хувь, инфляцийн түвшинг нэг оронтой тоонд тус тус хүргэх зорилтыг дэвшүүлж байна. Мөн 2004 он гэхэд төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг ДНБ-ий 6 орчим хувь хүртэл бууруулна. Ингэснээр гадаад өрийн хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулах, валютын албан нөөцийн нийт хэмжээг импортын 16-17 долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд хүргэх боломжтой болно.

**39.**Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр нь макро эдийн засгийн удирдлагыг сайжруулах, хувийн хэвшил хөгжих таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Төсвийн шинэтгэлийн хүрээнд ил тод байдлыг хангах, хариуцлагын тогтолцоо, төсвийн хөрөнгийг хуваарилах, түүний зарцуулалтыг хянах арга хэрэгслийг боловсронгуй болгох арга хэмжээг эн тэргүүнд хэрэгжүүлэх юм. Банкны салбар дахь бүтцийн өөрчлөлт нь зах зээлийн зарчимд тулгуурласан мөнгөний шууд бус удирдлагын аргуудыг өргөн ашиглах, хяналтыг бэхжүүлэх, төрийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах явцыг түргэтгэхэд чиглэгдэнэ. Мөн санхүүгийн бус төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг шинэчлэх, хувьчлах хууль эрхзүйн орчин бүрдүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг аль болох нээлттэй болгох чиглэлийг баримтлана. Энэ зарчмын дагуу эрчим хүч, дэд бүтэц зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбаруудад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, өрийн сүлжээг багасгах боломжийг өргөжүүлнэ. Өмч хувьчлалын явцыг түргэтгэх, үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг дээшлүүлэх замаар эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог 80 орчим хувьд хүргэх болно.

### **Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт**

**40.**Эрчим хүч, банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, газар ашиглалт, эзэмшилтийн талаар шинэчлэлийн бодлого явуулж, өмч хувьчлалыг эрчимжүүлэх нь дунд хугацаанд хувийн хэвшилд



тулгуурласан эдийн засгийн өсөлтийг хангах гол зарчим болно. Төрийн өмчийг хувьчлах 2001-2004 оны үндсэн чиглэлийг УИХ батлаад байна. Арилжааны банкуудыг хувьчлах, эрчим хүчний салбарыг арилжааны горимд шилжүүлэх бүтцийн өөрчлөлтийг тэргүүн ээлжинд хэрэгжүүлнэ. Эрчим хүчний болон банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутагт эрчим хүч, дулаан, нефть бүтээгдэхүүн, санхүүгийн зуучлалын зохистой нийлүүлэлт, үйлчилгээгээр хангах цогц бодлого хэрэгжүүлнэ. Түүнчлэн ядуу хүмүүст нөлөөлөх эрчим хүч, дулаан, нефть бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг судалж хэрэгжүүлнэ. Өмч хувьчлалын хөтөлбөрийг бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулж, ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөрийн хүрээнд шинээр болон нийтийг хамарсан ажлын байр бий болгох, хувиараа хөдөлмөр эрхлэх үүсгэл санаачилгыг төрөөс түлхүү дэмжинэ.

**41.** Монгол Улсын эдийн засагт голлох үүрэгтэй үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг оновчтой шийдвэрлэх нь эдийн засгийн цаашдын хөгжилд чухал нөлөөтэй. Аж ахуйн нэгжүүдийг хувьчлахдаа эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, тэдгээрийг экспортын шинэ зах зээлтэй холбох чадавхтай стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах чиглэл баримталж байна. Үнэ цэнэ бүхий төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлахтай холбогдуулж өмнө нь УИХ-аас баталсан үл хувьчлагдах төрийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг цуцлах арга хэмжээг авав. Эхний ээлжинд Худалдаа, хөгжлийн банк, НИК, Говь зэрэг компаниудыг хувьчилна.

**42.** Төрийн өмчийн буюу төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчилна. Банкны салбарын хувьчлалын гол зорилго нь эдийн засгаа тэтгэх үр ашигтай, найдвартай санхүүгийн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэж байна. Арилжааны банкуудыг гадаад, дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах чиглэл баримталж байна. Банкны салбарт итгэх итгэлийг сэргээх зорилгоор дунд хугацаанд хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

**43.** Дунд хугацаанд банк, санхүүгийн салбарт хийх бүтцийн өөрчлөлтийн гол зорилго нь олон нийт, бизнес эрхлэгчид, иргэд зэрэг банкаар үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий банкны тогтолцоо бүрдүүлэх явдал юм. Дунд хугацаанд банкны үйл ажиллагаатай холбогдсон хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгоно. Арилжааны банкуудаас гадна банк бус санхүүгийн байгууллагууд хөгжих хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. Зээлдэгч, зээлдүүлэгч харилцан бие биедээ хариуцлагаа шууд хүлээдэг байх чиглэлээр Банкны тухай хуульд өөрчлөлт оруулж эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. Банкны удирдлага, ялангуяа зээлийн удирдлагыг эрс сайжруулах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх ажлыг улам эрчимжүүлнэ.

*"Ядуурлын гол шалтгаан нь үнийн өсөлт юм. Бензин, шатахууны үнийн өсөлт бидэнд маш их дарамт үзүүлдэг. Хэдийгээр бидний тэтгэвэр, тэтгэмж өсч байгаа ч гурил, будааны үнэ бараг түүнээс илүү хэмжээгээр өсч байгаа учир ямар ч нэмэр алга" гэж Дорнод аймгийн Хэрлэн сумын эрэгтэйчүүдийн бүлэг тодорхойлжээ.*

**44.** Мөнгөний бодлогын зорилт нь инфляцийн түвшинг бага буюу нэг оронтой тоонд хүргэхийн зэрэгцээ валютын нөөцийн зохистой түвшинг хангахад чиглэгдэнэ. Улсын санхүүгийн чадавхийг бэхжүүлснээр Засгийн газрын банкны байгууллагаас авах зээлийн хэмжээ буурч, ингэснээр хувийн хэвшлийн хөгжлийг

хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

*"Зээлийг маш сайн амьдралтай, эсвэл маш муу амьдралтай хүмүүст л өгөөд байх шиг санагддаг. Харин миний бодлоор бол зээлийг хэн төлж чадна түүнд л өгмөөр санагддаг. Тусламж зээл хоёрыг хооронд нь ялгаж салгах хэрэгтэй юм. Хамгийн ядуучууд л тэр тусламжийг авах хэрэгтэй байх"* гэж Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлжээ.

**45.**Валютын хөвөх ханшны тогтолцоог хэвээр хадгалж үргэлжлүүлнэ. Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлтийг удирдах, арилжааны банкуудад тавих шалгуур үзүүлэлтүүдийг хангуулах үүднээс мөнгөний шууд бус аргыг илүүтэй хэрэглэж, нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг улам өргөжүүлнэ. Банк, санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэх нь Засгийн газрын тэргүүлэх зорилтын нэг бөгөөд банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авна. Түүнчлэн Засгийн газраас тодорхой салбар, үйлдвэрийг дэмжихдээ банкны салбарын төлбөрийн чадвар болон төсвийн тэнцвэрт байдалд муугаар нөлөөлөх ямар нэгэн захиргаадалтын арга хэмжээ авахгүй байх болно. Улс орны санхүүгийн чадавх сайжрах, инфляцийн түвшин буурах, банкны байгууллагын төлбөрийн чадвар дээшлэхийн хэрээр банкны зээлийн нэрлэсэн хүүг бууруулж, бодит хүүг эерэг түвшинд хадгалах бодлого баримтална. Мөн санхүүгийн салбар дахь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар хадгаламж, зээлийн хүүгийн түвшингийн одоо байгаа зөрүүг багасгахаар тооцож байна.

**46.**Газрын шинэтгэлийг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн харилцаанд оруулах зорилгоор Газрын тухай багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулах явдал Засгийн газрын байгууллагуудын ойрын зорилт болж байна. Газрыг эдийн засгийн харилцаанд оруулахдаа удаан хугацаагаар түрээслэх, газрын төлбөрийн арга хэрэгслийг боловсронгуй болгох, үйлдвэрлэл, газар тариаланг хөгжүүлэх оновчтой хөшүүрэг болгон ашиглах бодлого баримталж байна.

**47.**Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг зэрэг нийгмийн үйлчилгээний салбарт бүтцийн өөрчлөлт хийж, төрийн өмчийн сургууль, эмнэлэг, соёлын газруудыг удирдлагын гэрээгээр ажиллуулах чиглэл баримтална.

### ***Хувийн хэвшилд тулгуурласан өсөлтийг хангах***

**48.**Засгийн газраас хэрэгжүүлж ирсэн нээлттэй эдийн засгийн бодлогыг үргэлжлүүлэх нь шилжилтийн дараагийн үе шатуудад үр ашигтай хөрөнгө оруулалтыг хийх, эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн нөхцөл болно. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих, орон нутагт үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор гааль болон төрөл бүрийн зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулна. Дунд хугацаанд Засгийн газрын зүгээс экспорт, импортыг хязгаарлах чиглэлтэй ямар нэгэн татварын шинэ төрлийг нэвтрүүлэх, тоон хязгаарлалт болон бусад ямар нэгэн төрлийн хоригийг тавихгүй байх болно. Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувийн жинг энэ 2001 онд байгаа 7 орчим хувиас 2004 онд 6 хувьд хүргэнэ.

**49.**Нээлттэй эдийн засгийн бодлогыг үргэлжлүүлж, чөлөөт худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлнэ. Засгийн газраас Монголыг дэмжигч орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай тогтвортой орчныг бүрдүүлнэ. Томоохон хөрөнгө оруулагч нартай тогтвортой байдлын гэрээ байгуулж ажиллана.

**50.** Дунд хугацаанд өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрүүдийг дэмжих бодлого баримтална. Хувийн хэвшил хөгжих таатай орчин бүрдүүлэх бодлогын хүрээнд зөвшөөрөл олгох арга хэрэгслийг хялбаршуулах, Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд онцгой анхаарна.

◆Өнөөгийн байдлаар Монголын ихэнх аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал ашиглалтын түвшин их доогуур байна. Хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгэр Үйлдвэрийн газрын бүтцийн өөрчлөлтийн төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн гол зорилго нь үйлдвэр, аж ахуйн газруудын бизнес төлөвлөгөө боловсруулах, удирдлагын ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна. Үүний үр дүнд Дарханы Нэхий ХХК зэрэг 10 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа сэргэж эхлээд байна.

◆Засгийн газар нь мэдээлэл солилцох, бизнес эрхлэх боломжийн талаар дотоод, гадаадад сурталчлах замаар хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллаж байна.

◆Засгийн газар болон хувийн хэвшлийн түншлэлийг бататгаснаар хүний нөөцийн чадавх бэхжиж байна.

◆Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих өөр нэг нөхцөл бол төрөл бүрийн зөвшөөрөл олгох журам, дүрмийг хялбаршуулах явдал юм. Одоогоор Үйлдвэр, худалдааны яам холбогдох байгууллагуудтай хамтран зөвшөөрөл олгох арга хэрэгслийн талаар судалгаа явуулж, нэгдсэн стандарт боловсруулахаар төлөвлөж байна.

### **Төсвийн бодлого**

**51.** Төсвийн тэнцвэртэй, ил тод байдал болон макро эдийн засгийн тогтворжилт нь Засгийн газраас макро эдийн засгийн өсөлтийг хангах болон ядуурлыг бууруулах талаар дэвшүүлсэн зорилтуудад хүрэх гол нөхцлүүд болж байна. Харин 2001 оны төвлөрсөн төсвийн төсөл нь нэлээд шахуу болсон төдийгүй нийт төсвийн алдагдлын хэмжээг ДНБ-ий 7.4 хувьд хүргэхээр тооцсон бөгөөд энэ харьцаа 2004 онд 6 орчим хувьд хүрэх юм. Төсөв, татварын дунд хугацааны бодлого нь макро эдийн засаг, түүний дотор санхүүгийн тогтвортой байдлыг хангах, улсын хэвшлийн хүрээг багасгах, хувийн хэвшил хөгжих таатай орчин бүрдүүлэх, төсвийн тэнцлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, ядуучуудад чиглэсэн төсвийн зарлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдэх болно. Төсвийн зарлагыг оновчтой зарцуулах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктэй хамтарч улсын салбарын шинэчлэлийн иж бүрэн хөтөлбөр болон улсын төсвийн зарлагын тойм судалгааг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд төсвийн төлөвлөлтийг сайжруулж, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, улмаар бага орлоготой иргэдэд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болно.

**52.** Ойрын хугацаанд төсвийн удирдлагын шинэчлэлийг дараах тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх болно. Үүнд:

◆Засгийн газрын бодлоготой уялдуулан төсвийн төлөвлөлтийг бодитой болгох;

◆ Төсвийн бүртгэл, тайлагналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Төсвийн тухай хуульд тусгагдсан тайлан, бүртгэл, банктай холбоотой шаардлагуудыг хатуу баримтлах;

◆ Төсвийн хөрөнгө болон бэлэн мөнгөний удирдлагыг боловсронгуй болгох;

◆ Нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх;

◆ Төсвийн зарцуулалт, бодлогын нөлөөллийн талаар бодлого боловсруулагчид, хууль тогтоогчид болон олон нийтэд мэдээлж байх замаар төсвийн ил тод байдлыг хангах;

◆ Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээ болон бусад гол салбаруудын хөрөнгийн зарцуулалтыг хянах зэрэг болно.

**53. Төсвийн төлөвлөлтийг бодитой болгоно.** Төрийн албаны удирдлагын шинэчлэлийн явцад төсвийн төлөвлөлтийг аль болох энгийн, нийтэд ойлгомжтой болгох нь чухал юм. Төсвийн төлөвлөлтийн одоогийн мөрдөж буй зарчим нь төдийлөн цогцолбор бус, хариуцлага тооцох арга хэрэгслийг хангалтгүй тусгасан байна. Дунд хугацаагаар төсвийг төлөвлөх зарчим эхлэл төдий байгаа бөгөөд 2002-2004 оны төсвийн хүрээнд макро эдийн засгийн гол үзүүлэлтэд үндэслэн зарлагын хязгаар, түүний салбарын хуваарилалтыг анх тогтоосон юм. Цаашид төсвийг дунд хугацаанд төлөвлөх цогц арга зүйг боловсруулах нь зүйтэй юм.

**54. Төвлөрсөн болон орон нутгийн төсвийн харилцаанаас улс орны санхүүгийн байдал, төвлөрлийн асуудал ихээхэн хамааралтай байдаг.** Иймээс ОУВС-ийн Төсвийн асуудал хариуцсан газрын мэргэжилтнүүдтэй хамтарч төсвийн хуваарилалт, хяналт, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хоорондын харилцааг боловсронгуй болгох талаар цогцолбор төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Орон нутгийн түвшинд татварын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, удирдлагын хэвтээ бүтцийг бүрдүүлэх, татварын суурийг өргөтгөх чиглэлээр татварын одоогийн мөрдөж буй тогтолцоог шинэчилнэ. Засгийн газраас татварыг татвар төлөгчөөр бус татварын төрлөөр хураах зорилгоор 2002 оноос эхлэн НӨАТ, онцгой албан татварыг төвлөрсөн төсөвт төвлөрүүлж, дараа нь орон нутагт хуваарилах зарчмыг хэрэгжүүлж эхлэнэ. Түүнчлэн төвлөрсөн төсвөөс орон нутагт хуваарилдаг шилжүүлгийг ил тод болгох үүднээс тусгай загварын дагуу хийх болно.

**55. Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг аль болох ил тод, хяналт шалгалт сайтай болгоход чиглэсэн арга хэмжээг төсвийн төлөвлөлтийг бодитой болгох ажлын хүрээнд хэрэгжүүлнэ.** Үүний зэрэгцээ төрийн сангийн шинэчлэлийг хэрэгжүүлж, төсөв захирагч нарын хариуцлагыг дээшлүүлэх, төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжих, төсвийн талаарх статистик мэдээллийг олон улсын стандартад нийцүүлэх, төрийн сангийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сан, үүний дотор өрийн удирдлагыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээ авна.

**56. Саяхан Төрийн сангийн газрыг шинээр байгуулж, холбогдох боловсон хүчнийг ажилд авав.** Ажиллах нягтлан бодогч нарыг нягтлан бодох бүртгэлийн шинэ тогтолцоо, олон улсын стандартуудын талаар сургалтад хамрууллаа. Ажиллах боловсон хүчнийг бэхжүүлэх зорилгоор төсвийн ерөнхий нягтлан бодогч нарыг томилох асуудлаар төсвийн захирагчид Санхүү, эдийн засгийн

яамтай зөвшилцөж байх журмыг Төсвийн тухай хуульд шинээр оруулж мөрдүүлэв. Мөн Засгийн газраас ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийг тусгасан журам батлан гаргалаа. Тоо, мэдээллийн чанарыг дээшлүүлэх зорилгоор төсвийн тайлагналтын талаар шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**57.**Төсвийн тоо, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах үүднээс Засгийн газрын болон мөнгөний статистикийн бүртгэлийг нэгтгэх арга хэмжээ авна. Бэлтгэл ажлын хүрээнд төвлөрсөн төсөвтэй харьцдаг төсвийн байгууллагуудын дансны тооллогыг явуулж, одоо орон нутагт явуулах бэлтгэл ажлыг хангаад байна.

**58.**Төрийн сангийн нэгдсэн данс байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүднээс тэг үлдэгдэлтэй данс, Монголбанкинд бүх төлбөр тооцоог төвлөрүүлэх ажлыг 11 байгууллагад туршилтын журмаар хийж байна. Уг туршилтын үр дүнг харгалзан цаашдын арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлнэ.

**59.***Төсвийн ил тод байдал:* ОУВС-аас гаргасан Төсвийн ил тод байдлыг хангах тухай заавар, стандарт болон кодуудын мөрдөлтийг хянах зааврын дагуу Монгол улс төсвийн үнэлгээгээ гаргаж тайлагналаа. Уг тайланг үндэслэн төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх, төсвийн хяналтыг сайжруулах талаар урт хугацааны зорилтуудыг тодорхойлох болно.

**60.***Төсвийн гүйцэтгэл, хяналт шалгалт:* Гарцад суурилсан төсвийн төлөвлөлтийн үндсэн зарчим нь аливаа үйл ажиллагааг гарах зардлаар нь бус харин хүрэх үр дүнгээр нь санхүүжүүлэхэд чиглэгдэнэ. Уг зарчмыг баримтлахад үр дүнгийн үзүүлэлтийг зөв тодорхойлох нь чухал юм. Энэ чиглэлээр төрийн захиргааны шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд нэлээд ажил хийгдсэн байна. Уг хөтөлбөрийн хүрээнд туршилтад 5 байгууллагыг сонгон ажиллуулж байна. Эдгээрийн гол зорилго нь тухайн байгууллагын үйл ажиллагааны орц, үүнтэй уялдсан үр дүн, түүнийг хянах үзүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Засгийн газраас ядуурлыг бууруулах талаар баримтлаж буй бодлогын хэрэгжилтийг эрүүл мэнд, боловсролын салбарын үр дүнгийн үзүүлэлтээр илэрхийлэх боломжтой учраас эдгээр салбаруудын төсвийн төлөвлөлтийн шинэчлэлд онцгой анхаарч байна.

## Б. Хүний тогтвортой хөгжил

61. Засгийн газар нийгмийн салбарт хуваарилсан төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх бодлого баримталж байна. Өнгөрсөн 3 жилд нийгмийн салбарт зарцуулсан төсвийн зарлага, үүний үр дүнг харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5. Нийгмийн салбарын төсвийн зарлагын дүн

	Төсвийн нийт зарлагад эзлэх хувь			ДНБ-д эзлэх хувь		
	1998	1999	2000	1998	1999	2000
<b>Нийгмийн салбарын нийт зардал</b>	<b>46.2</b>	<b>48.4</b>	<b>52.3</b>	<b>19.4</b>	<b>19.1</b>	<b>21.5</b>
Боловсролын үйл ажиллагаа	17.1	17.8	19.1	7.1	7.0	7.9
Эрүүл мэндийн үйл ажиллагаа	9.6	9.8	10.5	4.0	3.9	4.3
Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	15.1	16.4	17.2	6.3	6.5	7.3
Орон сууц, нийтийн аж ахуйн үйл ажиллагаа	1.1	1.3	1.6	0.5	0.5	0.7
Амралт, биеийн тамир, соёл, урлагийн үйл ажиллагаа	3.3	3.1	3.3	1.4	1.2	1.4

Эх сурвалж: СЭЗЯ, 2000

62. Төсвийн зарлагын удирдлагыг сайжруулах нь төсвийн тогтвортой байдлыг хангахад үндсэн алхам болно. Энэ хүрээнд 2002 онд болон түүний дараах жилүүдэд төрийн байгууллагууд дахь ажилтнуудын тоог цөөрүүлэх, цалингийн тогтолцоог уян хатан болгох тодорхой зорилт бүхий төрийн албан хаагчдын цалин хөлс, ажил эрхлэлтийн үр ашгийг дээшлүүлэх шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Засгийн газар, Дэлхийн банктай зөвшилцсөний үндсэн дээр нийгмийн үйлчилгээг ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд түлхэц өгөх чиглэлээр үзүүлэх, хамрах хүрээг оновчтой болгох төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Өндөр насны тэтгэвэртэй холбоотой бодлого нь нийгмийн даатгалын сангийн төлбөрийн чадварыг хангахад чиглэнэ.

63. Засгийн газрын үйл ажиллагааны нэн тэргүүний ач холбогдолтой чиглэлүүдийн нэг нь боловсрол, эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, хүн амын ажил эрхлэлт болон орлого бий болгох үйл ажиллагааг дэмжих замаар нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулан хүний тогтвортой хөгжлийг хангах явдал юм. Энэ ажлын хүрээнд боловсрол, эрүүл мэндийн салбарт дараах зорилтод хүрэхийг зорьж байна.

## Б.1. Боловсрол

"Малчид, ялангуяа ядуу өрхүүд, мөн ядуу бус ч олон малтай өрхүүд, түүнчлэн хөдөлмөрийн насанд хүрсэн гишүүн цөөтэй өрхүүд эрэгтэй хүүхдүүдээ сургуулиас нь гаргадаг тохиолдол нилээд байна. Бид хүнсээ зээлээр авсаар байгаад сүүлийн таван жилд 300 гаруй мянган төгрөгийн өртэй болчихлоо. Хөдөө байдаг манай хамаатнууд хоол, хувцаснаасаа илүүчлэн өгдөг байсан одоо цөөрлөө. Манай дунд хүү 4-р ангиасаа сургуулиасаа гарч одоо манай хамаатнуудад мал маллахад нь тусалж байна. Ингэж л өөрийгөө хооллож, хувцаслаж байна. Хүүхдүүд өсөх тутам тэдний зардал нэмэгдэх юм" гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын иргэн ярив.

64. Хүн амын амьжиргааны түвшингийн 1998 оны судалгаанаас үзэхэд Монгол Улсад боловсролын түвшин ядуурлын түвшинг тодорхойлох чухал үзүүлэлт болоод байна. Бүрэн дунд боловсрол эзэмшээгүй хүмүүсийн 60,3 хувь нь ядуу байхад дээд болон техник мэргэжлийн боловсролтой хүмүүсийн 17,7 хувь нь ядуу байна. Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын дүнгээс үзэхэд 8-15 насны хүүхдийн 1,5 хувь нь бичиг үсэг тайлагдаагүй байсан бол 2000 онд бичиг үсэг тайлагдаагүй хүүхдийн хувь хэмжээ 4,9 хувьд хүрч нэмэгдсэн байна. Энэ нь тэдгээр хүүхдүүдийг бичиг үсгийн боловсролтой болгохоос гадна дараагийн шатны боловсрол нөхөн олгох шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн байдал, боловсролын түвшингээр, 1998 (хувь)

Үзүүлэлт	Боловсролгүй	Анхан шатны	Дунд шатны	Техник мэргэжлийн	Дээд мэргэжлийн
Хот					
Ажиллагчид	26.7	37.1	38.0	51.6	67.5
Ажилгүйчүүд	23.3	22.9	28.3	23.0	11.3
Хөдөө					
Ажиллагчид	68.3	79.9	77.0	78.3	80.1
Ажилгүйчүүд	4.9	7.3	11.5	12.6	9.6

65. Хөдөө орон нутагт боловсролын түвшин харьцангуй доогуур байна. Монгол улсад 3-7 насны хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын үргэлжлэх хугацаа 5 жил байдаг. Цэцэрлэгт 2000/2001 оны хичээлийн жилд хүмүүжиж байгаа хүүхдийн тоо нийт цэцэрлэгт хамрагдвал зохих хүүхдийн тооны 32,1 хувийг эзэлж байна. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдийн тоо хотуудад харьцангуй өндөр байна. Тухайлбал, Улаанбаатарт нийт цэцэрлэгийн насны хүүхдийн 48,4 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байхад аймаг, сумдад энэ тоо 24,6 хувьтай байна. Хүн амын 2000 оны тооллогын дүнгээс үзэхэд 8-11 насны хүүхдийн 9,1 хувь, 12-15 насны хүүхдийн 18,3 хувь нь сургууль завсарджээ. Өөрөөр хэлбэл, 8-15 насны хүүхдийн 13,5 хувь нь сургуулийн гадна үлдэж суралцах эрхээ эдэлж чадахгүй байна. Хот, суурин газарт 8-15 насны 16,5 мянган хүүхэд сургууль завсардсан бол хөдөө орон нутагт энэ тоо 51,7 мянгад хүрээд байна.

66. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа хөвгүүд (29,4 хувь), охидын (31,9 хувь) тоо 2000/2001 оны хичээлийн жилийн статистикийн тоо мэдээнээс үзэхэд харьцангуй ойролцоо гарсан бөгөөд цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 30,6 хувь

нь цэцэрлэгт хүмүүжиж байна. Харин 8-11 насны хүүхдийн сургуульд хамрагдалт хүйсийн хувьд тэгш бус болж, 119 мянган охид, 117 мянган хөвгүүд сургуульд суралцаж байна. Хүйсийн ялгаа 12-15 насны хүүхдийн дунд хамгийн өндөр болж 94,2 мянган эрэгтэй, 105,3 мянган эмэгтэй хүүхэд сургуульд суралцаж байна. Дээрх ялгаа хот, хөдөөгийн хүүхдийн дунд өндөр байна. Хөдөө орон нутагт сургууль завсардсан 12-15 насны эрэгтэй хүүхдийн тоо 23,3 хувь, эмэгтэй хүүхдийн тоо 13,2 хувьд хүрээд байна. Анхан шатны болон дунд шатны боловсролын сургуульд 2000/2001 оны хичээлийн жилд суралцаж байсан хүүхдийн 52,3 хувь нь эмэгтэй байснаас 1-3 дугаар ангийн хүүхдийн 50,1 хувь, 4-7 дугаар ангийн хүүхдийн 53,4 хувь, 8-10 дугаар ангийн хүүхдийн 59,4 хувь нь эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл, хүйсийн тэнцвэр дунд сургуулиас эхлэн алдагдаж байна. Сургуулиа орхиж гарсан 8-15 насны хүүхдийн 61,7 хувийг хөвгүүд эзэлж байгаа нь сургууль завсардаж буй хүүхдийн дунд хүйсийн ялгаа их байгааг харуулж байна.

**67.** Хөдөө орон нутагт, ялангуяа сумдад хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж тааруу байна. Тухайлбал, 2001 оны байдлаар нийт 307 сумаас 203 суманд сургуулийн насны хүүхдийн 80-аас доош хувь нь сургуульд хамрагдсан гэсэн мэдээ байна. Нутаг дэвсгэр уудам, нүүдлийн соёл иргэншил зонхилж байгаагийн улмаас хүүхдүүд сургууль завсардаж байна. БСШУЯамнаас 2000 онд явуулсан судалгаанаас үзэхэд хөдөө орон нутаг дахь нийт хүүхдийн 15,1 хувь нь хөдөө аж ахуй эрхэлдэг (малаа малладаг) учраас сургуульд суралцдаггүй гэж хариулжээ. Хотод ийм хүүхдийн тоо 8,3 хувьтай байна. Мөн хөдөө орон нутгийн хүүхдийн 6,4 хувь, хотын хүүхдийн 1,2 хувь нь хот, суурин газар ажил эрхэлдгийн улмаас сургуульд суралцдаггүй гэжээ. Сургууль завсардсан хүүхдийн ихэнх нь эрэгтэй хүүхдүүд байна. Энэ судалгаанаас үзэхэд мал олонтой газар сургууль завсардсан хүүхдийн тоо өндөр байгаа нь харагдаж байна.

**68.** Малчдын хүүхдийг дотуур байраар хангахад хүндрэл бэрхшээл учирч байна. Монгол улсын хөдөөгийн хүн амын нягтрал улсын дунджаас харьцангуй бага учраас ихэнх сумдад зөвхөн ганц сургууль ажилладаг бөгөөд тэр нь малчдын гэрээс 10-300 км зайтай байдаг. Сургуульд хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 1960-1990 онд сумын сургуулиудын дэргэд хүүхдийн дотуур байр (ихэнх суманд түр барилга) барьж, түүнд суух сурагчдын хоол хүнс, бусад зардлыг улсаас бүрэн дааж ирсэн нь малчдын хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд чухал ач холбогдолтой байв. Ийнхүү сурах бололцоог бүрдүүлсний дүнд 1989 оны байдлаар дотуур байранд амьдарч байсан хүүхдийн тоо 75 мянгад хүрч, хөдөөгийн суурь боловсролын хамралт 90 хувь болж өссөн байна. Гэтэл 1991 оноос эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан дотуур байрыг хэвийн нөхцөлд ажиллуулах боломж муудаж, 50 гаруй сумдын дотуур байр хаагдсан байна.

**69.** Засгийн газраас 1994 онд дотуур байранд суух хүүхдийн хоолны зардлын хагасыг эцэг, эхээс нь гаргуулж байх шийдвэр гаргасан нь хөдөөд сургууль завсардалт нэмэгдэхэд ихээхэн нөлөөлжээ. Уг шийдвэрийн улмаас 1995 онд дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо 75 мянгаас 19,6 мянга хүртэл буурав. Дотуур байрны зардлыг төрөөс 2000 онд хариуцах шийдвэрийг сэргээсэн нь хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, сургалтыг сайжруулах нэг нөхцөл болов. Дотуур байранд амьдрах сурагчдын захиалгын тоо 38 мянгад хүрснээс 27,4 мянгыг нь 2000/2001 оны хичээлийн жилд байранд суулгасан байна.



**70.** Нөгөөтэйгүүр сургуульд суралцах орчин муу, дотуур байранд амьдрах нөхцөл шаардлага хангахгүй, хоол хүнс хүрэлцээгүй, сургалтын чанар тааруу байгаагаас эцэг эхчүүд хүүхдээ сургуульд суралцуулах хүсэл эрмэлзэл бага болж ирсэн тал байна. Удаан хугацаагаар гэрээсээ хол амьдарч хагас өлсгөлөн байдалтай байгаа тухай хөдөө орон нутгийн сурагчид мэдээлж байна. Мөн сургуулиуд эцэг эхээс сургуулийн анги, танхим засварлах, шинэчлэх, цэвэрлэх мөнгө хурааж байгаа нь эцэг эхчүүдэд хүндрэл учруулдаг байна. Эцэг эхтэйгээ амьдарч байгаа сурагчдын сурлагын амжилт хамаатан садан, найз нөхдийндөө буюу дотуур байранд амьдарч буй хүүхдийнхтэй харьцуулахад өндөр буюу 55,2 хувьтай байна. Дотуур байранд амьдарч буй хүүхдийн сурлагын амжилт 42,2 хувьтай буюу харьцангуй доогуур байгаа нь амьдрах орчин муу, багш нараас тавьж буй анхаарал сул байгаа нь хүүхдийн сурлагын түвшинд нөлөөлж байгааг нотолж байна.

*"Хүүхдүүдээ сургуульд нь явуулахын тулд бид хоёр хуваагдаж амьдарч байна.. Манай эхнэр сумын төвд хүүхдүүдээ хардаг, харин би мал дээрээ үлддэг. Энэ нь манай өрхийн жилийн зардлыг хоёр дахин өсгөдөг юм"* гэж Дорнод аймгийн Дашбалбар сумын эрэгтэй ярьсан байна.

**71.** Суурь боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж сүүлийн жилүүдэд буурч ирлээ. Хичээлийн байрны суудлын тоо нь нийт суралцагчдын дөнгөж 56.6 хувийг хангаж байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас төв рүү чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэнээс Улаанбаатар, томоохон хот, суурин газар, төвийн бүс нутгийн хүн амын нягтрал ихсэж, олон сургууль 3 ээлжээр хичээллэж, анги дүүргэлт 45-50-д хүрч, сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, хичээл болон хичээлээс гадуур арга хэмжээ зохион байгуулахад хүндрэл учруулж байна. Түүнчлэн 70.3 мянган ортой хүүхдийн цэцэрлэгт 79.3 мянга гаруй хүүхэд хүмүүжиж байгаа нь хүүхдийн цэцэрлэгт хамрагдвал зохих 3-7 насны нийт хүүхдийн 30 гаруй хувийг эзэлж байна. Сурагч багшийн тооны дундаж харьцаа 25:1 байгаагаас бага сургуулиудын хувьд 33:1, дунд болон ахлах ангиудад 20:1 харьцаатай байна.

**72.** Багш нарын чадвар дутмаг байгаа нь сургалтын чанарт муу нөлөө үзүүлж байна. Нийт багш нарын 8,6 хувь мэргэжлийн бус байна. Өмнөговь аймгийн 5 багш тутмын нэг, Баянхонгор, Дорнод, Сэлэнгэ аймгийн 7 багш тутмын нэг нь мэргэжлийн бус багш эзэлж байна. Мэргэжлийн бус багш нарын ихэнх нь зураг, хөдөлмөр, англи хэл, мэдээллийн технологи болон казах хэл заадаг байна. Энэ 2000/2001 оны хичээлийн жилийн эхний хагасын тоо мэдээнээс үзэхэд нийт багш нарын 62,2 хувь нь бакалаврын зэрэгтэй, 31,3 хувь нь их, дээд сургууль, коллежийн дипломтой байна. Дунд сургуульд мэргэжлийн 719 багш дутагдалтай байгаагаас 11 хувь нь бага ангийн багш, 10 хувь нь тооны багш хэрэгцээтэй байна. Мөн мэдээллийн технологи, монгол хэл, уран зохиол, англи хэл, хөгжмийн багш нар ихээхэн дутагдаж байна. Багш нар цалин багатайгаас ажиллах сонирхол тааруухан байна. Сурлагын амжилтын хяналт-шинжилгээний судалгаанаас үзэхэд нийт 264 багшаас 103 багш буюу 39 хувь нь илүү өндөр цалинтай ажил олдвол ажлаасаа гарахад бэлэн байгаа тухайгаа хэлжээ.

**73.** Сурлагын амжилтыг 1990 оноос өмнө олон улсын аргачлалаар тооцдоггүй байсан болохоор Монгол Улсын сургалт, багш нарын чанарт нарийвчилсан үнэлгээ өгөх буюу харьцуулан үнэлэх боломж бага байна. Ийм судалгааг анх 1999 онд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын

байгууллагын төслийн хүрээнд 4, 8 дугаар ангийн хүүхдийн дунд явуулсан юм. Уг судалгаанаас үзэхэд 4 дүгээр ангийн хүүхдийн сурлагын түвшин хангалттай байсан бол 8 дугаар ангид харьцангуй муу байв. Тухайлбал, сорилтод хамрагдсан нийт сурагчдын цөөн хэд нь л тооны өгөгдсөн бодлогыг бодож чадсан байна. Энэ асуудалд онцгой анхаарал тавих шаардлагатай боллоо. Бүрэн дунд боловсролын хугацааг харьцуулсан судалгаанаас үзэхэд Монгол Улс зэрэг 7 оронд бүрэн дунд боловсрол 10 жил байдаг бол 43 оронд энэ нь 11 жил, 123 оронд 12 жил, 43 оронд 13 жил, 4 оронд 14 жил байдаг байна. Энэ дүнгээс үзэхэд манай улсын бүрэн дунд боловсролын тогтолцоог 11-12 жил болгох бэлтгэлийг хангах шаардлагатайг харуулж байна.

**74.** Барилгын чанар, халаалт муудсанаас хүүхдийн цэцэрлэгийн 51,6 хувь, сургуулийн 88,2 хувь, дотуур байрны 80 хувь нь өвлийн улиралд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй байна. Санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүйгээс сургууль, дотуур байрны ердийн урсгал болон их засварыг хийхэд ихээхэн хүндрэл үүсч байна. Хөдөөгийн нийт 409 сургуулийн байр, 298 дотуур байранд их засвар хийхэд 12,4 тэрбум төгрөг шаардлагатай байна. Сургуулийн байр, сургалтын техник хэрэгслийн чанар муудсан нь сурах орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд сургуулийн байруудын өргөтгөл, засварын ажил бага хийгдсэнээс болоод сурах, багшлах хэвийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулж байна. Сургуулийн байр, ялангуяа дотуур байрыг засан сайжруулахгүйгээр сургалтыг зохих түвшинд явуулах боломжгүй юм.

**75.** Техник мэргэжлийн сургуулиуд хувийн хэвшлээс санал болгож буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаагаас эдгээрт суралцагчдын тоо 1990 оныхтой харьцуулахад бараг 2 дахин буурчээ. Иймээс техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг сургах буюу давтан сургах шаардлагатай байна. Техник мэргэжлийн сургуулиудын сургалтын тоног төхөөрөмж дунджаар 24 жил ашиглагдаж байгаа нь эдгээрийг яаралтай шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

**76.** Эдгээрээс үзэхэд сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад сурах, багшлах орчныг сайжруулах, хот, хөдөөгийн ялгааг багасгахад илүү анхаарал тавих шаардлагатай байна.

**77.** Боловсролын салбарт нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

(1) Сургуулийн өмнөх боловсролын хамрах хүрээг өргөтгөж хөдөө орон нутаг дахь цэцэрлэгүүдэд сурах орчныг сайжруулах. Хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг гэрээр олгох аргачлалыг нэвтрүүлэх

(2) Дотуур байранд амьдрах орчныг сайжруулснаар малчин өрхийн болон ядуу өрхийн хүүхдүүдэд суурь боловсрол олгох боломжийг нэмэгдүүлэх

(3) Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны сурах нөхцөл байдал, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах

(4) Хөдөөгийн сургуулиудын сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах

(5) Сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох бүх хэлбэрийг дэмжиж хөгжүүлэх

(6) Бага, дунд болон ахлах ангийн сургалтын агуулга, аргазүй, бүтэц болон чанарыг үнэлэх тогтолцоог сайжруулах

(7) Багш нарын сургалт, давтан сургалтыг сайжруулах

(8) Хэрэглэгчдийн сонирхол, нийгмийн хэрэгцээ болон зах зээлийн

эрэлттэй уялдуулан техник мэргэжлийн сургуулийн тогтолцоог бэхжүүлэх

## **Б.2. Эрүүл мэнд**

*"Эмнэлгийн үйлчилгээ их муу байна. Эмч дутагдалтай, эмнэлгийн үйлчилгээ нэр төдий л байна. Эмнэлэгт хэвтвэл шаардлагатай эм, тариураа өөрсдөө л олох болдог. Нэгэнт бид тэр бүр Улаанбаатар явж чадахгүй болохоор эм, тариураа жижиг наймаачдаас авах болох юм. Гэвч тэр нь чанар муутай, заримдаа хэрэглэх хугацаа нь хэтэрсэн байдаг. Хэрэглэх хугацаа нь хэтэрсэн эм хөдөөгийн хүмүүст зарж байгаа нь тэдний эрүүл мэндэд тун их аюултай гэж би боддог юмаа. Чанарын шалгалтаар худалдах зөвшөөрөл аваагүй бүтээгдэхүүн л орон нутагт зарагдаад байх шиг санагддаг юм"* гэж Өмнөговь аймгийн Сэврэй сумын Бүйлсэн багийн эмэгтэй ярьсан байна.

**78.** Эрүүл мэндийн салбарт одоогоор үндсэн гурван бэрхшээл тулгараад байна. Үүнд:

- Эхийн эндэгдэл өндөр байгаа бөгөөд дорвитой буурахгүй байна. Эрүүл мэндийн яамны Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн 2001 оны үнэлгээний тайлангаас үзэхэд эхийн эндэгдэл 1996-2000 онд дунджаар Улаанбаатар хотод 100000 амьд төрөлтөд 121, хөдөө орон нутагт 175 байсан байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 1998 онд явуулсан судалгаа боловсрол багатай эхээс төрсөн нялхас болон 5-аас доош насны хүүхдийн эндэгдэл нь дунд буюу дээд боловсролтой эхээс төрсөн хүүхдийн эндэгдлээс хавьгүй илүү байгааг харуулав. Нялхсын эндэгдэлд амьсгалын замын өвчин, үүнээс амьсгалын цочмог халдвар, хатгалгаа голлох шалтгаан болсон хэвээр байна.

- Сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин, халдварт шар, бруцеллөз зэрэг халдварт өвчний гаралт нэмэгдэж байна. Зуу мянган хүн тутамд 1999 онд вируст гепатитын өвчлөл 21,6 хувь, сүрьеэ 13,2 хувь, бруцеллөз 6,1 хувь, тэмбүү 6,1 хувь, заг хүйтэн 9,1 хувьтай байв. Өнөөдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Ази, Номхон далайн баруун бүсийн төвийн гаргасан ангиллаар Монгол Улс сүрьеэгийн өвчлөл маш өндөр гэсэн 7 орны тоонд орж байна. Сүрьеэгийн үндэсний төвөөс 2000 онд гаргасан судалгаанаас үзэхэд сүрьеэгээр өвчлөгчдийн 53,8 хувь ажилгүй хүмүүс эзэлж байна. Зарим халдварт өвчний үндсэн шалтгаануудын нэг нь хоол хүнсний дутагдалтай холбоотой байна.

- Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хүн амын нас баралтын шалтгаанд үндсэн өөрчлөлт гарч амьсгалын замын болон хоол боловсруулах эрхтний өвчлөлт, халдварт өвчний улмаас ихэвчлэн нас бардаг байсан бол одоо цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл (цус харвах болон зүрхний шигдээс өвчин), өмөн үү болон осолд орох, гэмтэж бэртэх явдал үндсэн шалтгаан болж хувираад байна.

**79.** Эрүүл мэндийн салбарт тулгарч буй томоохон асуудал бол эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийхэнд чиглүүлэх явдал юм. Хөдөө орон нутгийн оршин суугчид болон эмзэг бүлгийнхэн эрүүл мэндийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа бөгөөд энэ байдал улам хүндэрч байна. Эрүүл мэндийн удирдлагын мэдээлэл, боловсролын төвөөс 2000 онд явуулсан судалгаанаас үзэхэд амьжиргааны түвшин муу байх тусам амбулаторийн болон клиникийн үйлчилгээг ашиглах нь багасдаг байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж тааруу байгаа нь санхүүгийн хүндрэл (эрүүл мэндийн үйлчилгээний үнэ, эмийн болон тээврийн зардал өндөр), холбоо харилцаа сул хөгжсөн, эмнэлгийн үйлчилгээнээс

алс хол оршдог зэргээс голлон шалтгаалдаг байна. Төрөөс эрүүл мэндийн салбарт зарцуулдаг төсөв багассан бөгөөд энэ зардлыг нөхөх өөр эх үүсвэр хомс байна. Саяхнаас хэрэгжүүлж эхэлсэн эрүүл мэндийн даатгал нь голдуу үнэ өндөртэй хэвтэж эмчлүүлэх эмчилгээг санхүүжүүлэхэд зориулагддаг байна. Иймд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог өөрчлөх, өрхийн эмчилгээ болон эрүүл мэндийн бусад үйлчилгээнд татаас өгөх замаар эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил боловсруулалтын шатандаа явж байна. Нааштай өөрчлөлт гаргахын тулд эрүүл мэндийн даатгалын тогтолцоог илүү өргөн хүрээтэй болгох шаардлагатай байна.

**80.** Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай байна. Санхүүгийн хязгаарлагдмал эх үүсвэрийг эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад бус ихэвчлэн байшин барилгын засвар, халаалтад зарцуулж байна. Барилга, тоног төхөөрөмж муудаж, ялангуяа чухал шаардлагатай эм, эмчилгээний наад захын багаж хэрэгсэл хангалтгүй байгаа нь эмчилгээний чанар муудахад хүргэж байна. Төрийн өмчит эмнэлгүүдийн оношлогооны чадвар хангалтгүй байна. Одоогоор сумын 320 эмнэлгийн (эмнэлгийн үйлчилгээний анхан шатны нэгж) 66 хувь нь найдвартай үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Эрүүл мэндийн яам Сумын эмнэлгийг хөгжүүлэх хөтөлбөрийг Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг нь болно гэж үзэж байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сумын эмнэлгүүдийг эмчилгээний илүү сайн багаж, тоног төхөөрөмжтэй болгож, эмч нарыг сургаж, эрүүл мэндийн үндсэн үйлчилгээг стандартад нийцүүлж өөрчилнө.

**81.** Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг 3800-5200 хүнд үзүүлдэг эрүүл мэндийн тогтолцооны бие даасан анхдагч нэгжийг өрхийн эмнэлэг гэнэ. Өрхийн эмнэлгүүдийг ихэвчлэн аймгийн төв, хот, суурингуудад байгуулна. Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Дорноговь, Ховд, Хөвсгөл аймгуудад туршилтын журмаар өрхийн эмнэлэг байгуулан ажиллуулж байна. Одоогийн байдлаар 990 гаруй өрхийн эмч, 99 өрхийн эмнэлэг байгуулагдаад байна. Өрхийн эмнэлгээр эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх ажлыг Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд бүх аймагт хэрэгжүүлнэ.

Хүснэгт 7. Ядуурлын тархалт ундны ус болон дулааны хангамжийн эх үүсвэрээр (хувь)

Амьжир-гааны түвшин	Халаалт				Усан хангамж							
	Бүгд	Үүнээс: Халаалтын төрөл			Бүгд	Үүнээс: Усан хангамж, эх үүсвэрээр						
		Төвлөрсөн	Төвлөрөөгүй	Энгийн		Төвлөрсөн		Хамгаалалттай худаг	Хамгаалалтгүй худаг	Тээврийн ус	Гол, булаг, цас, мөсний ус	Бусад
<b>Улсын дүн</b>												
Нэн ядуу	100	13.8	4.9	81.2	100	16.0	12.0	21.8	16.6	11.7	31.7	2.2
Ядуу	100	17.2	1.5	81.3	100	17.9	13.6	20.9	13.9	10.6	34.8	1.8
Ядуу бус (б)	100	21.1	2.7	76.2	100	21.7	17.4	16.1	15.9	9.7	36	0.8
Ядуу бус (д)	100	25.5	2.3	72.2	100	28.3	22.2	15.0	17.5	6.1	30.8	2.3
Ядуу бус (ч)	100	31.1	2.4	66.4	100	33.3	29.7	16.3	15.3	4.6	30.4	0.0
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>22.5</b>	<b>2.8</b>	<b>74.8</b>	<b>100</b>	<b>24.2</b>	<b>19.7</b>	<b>17.5</b>	<b>16</b>	<b>8.3</b>	<b>32.8</b>	<b>1.4</b>

<b>Хот</b>												
Нэн ядуу	100	26.2	6.5	67.3	100	28.6	22.6	34.5	3.6	22.0	8.9	2.4
Ядуу	100	36.4	3.1	60.5	100	38.0	28.7	34.9	4.7	19.4	2.3	0.8
Ядуу бус (б)	100	49.1	5.9	45.0	100	50.5	40.9	26.8	3.2	16.8	2.7	0.0
Ядуу бус (д)	100	59.3	5.0	35.7	100	64.3	50.3	20.6	2.0	8.5	2.5	2.0
Ядуу бус (ч)	100	66.3	4.1	29.5	100	70.5	63.2	18.1	1.6	6.2	3.6	0.0
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>49.0</b>	<b>5.1</b>	<b>46.0</b>	<b>100</b>	<b>51.9</b>	<b>42.6</b>	<b>26.2</b>	<b>2.9</b>	<b>14.1</b>	<b>4.0</b>	<b>1.0</b>
<b>Хөдөө</b>												
Нэн ядуу	100	0.6	3.2	96.2	100	2.5	0.6	8.3	30.6	0.6	56.1	1.9
Ядуу	100	0.0	0.0	100	100	0.0	0.0	8.3	22.2	2.8	63.9	2.8
Ядуу бус (б)	100	0.3	0.3	99.3	100	0.3	0.0	8.1	25.3	4.4	60.6	1.3
Ядуу бус (д)	100	1.1	0.4	98.5	100	2.2	1.8	10.9	28.7	4.4	51.3	2.5
Ядуу бус (ч)	100	0.0	0.9	99.1	100	0.5	0.0	14.7	27.5	3.2	54.1	0.0
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>0.5</b>	<b>0.8</b>	<b>98.7</b>	<b>100</b>	<b>1.1</b>	<b>0.6</b>	<b>10.2</b>	<b>27.0</b>	<b>3.4</b>	<b>56.7</b>	<b>1.7</b>

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

**82.** Эрүүл мэндийн салбарын үндсэн хүндрэл бол түүний үр ашиг муу байгаатай холбоотой байна. Үүний үндсэн шалтгаан нь хэт жижигрүүлсэн санхүүжилт юм. Эрүүл мэндийн үйлчилгээ нь төв болон орон нутгийн засаг захиргааны мэдэлд байдаг бөгөөд Эрүүл мэндийн яамнаас тавьж буй хяналтаас хөндий байна. Улсын хэмжээнд нэн тэргүүний ач холбогдолтой асуудал, бодлого боловсруулахад нэмэр болохуйц эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байхгүй байна. Европын холбооны ТАСИС хөтөлбөрөөс санхүүжүүлсэн санхүүгийн удирдлагын төсөл нь үйл ажиллагааны түвшинд онц чухал шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн мэдээллийг өгөх эрүүл мэндийн санхүүгийн удирдлагын тогтолцоог 4 аймаг, 2 дүүрэг, гуравдагч шатны 3 эмнэлэгт хэрэгжүүлсэн юм. Энэ тогтолцоог улсын хэмжээнд хөгжүүлэх, эрүүл мэндийн үндэсний нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог цаашид боловсруулах ажил хийгдэж байна. Уг төслийн саналыг Парист болсон Зөвлөлдөх бүлгийн уулзалтын үеэр танилцуулсан болно. Дэлхийн банкны Төсвийн зарлагыг оролцооны аргаар үнэлэх судалгаанд хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ авах хэрэгцээ, эрүүл мэндийн үйлчилгээ авч буй хэв маягт тулгуурлан эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийг сайжруулах ерөнхий төлөвлөгөөг боловсруулахын чухлыг онцлон тэмдэглэсэн байна. Уг судалгаанд салбарын бүтээгдэхүүн, нэн тэргүүний ач холбогдолтой бүтээгдэхүүн болон дэд бүтээгдэхүүн, тэдгээр бүтээгдэхүүний өртгийг тодорхойлох шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн болно. Энэ чиглэлээр Эрүүл мэндийн яам болон эрүүл мэндийн гуравдагч шатны 3 байгууллагад Азийн хөгжлийн банкны Төрийн байгуулалтын шинэтгэл, санхүүжилтийн төслийн шугамаар туршилтын ажил эхлээд байна.

**83.** Гадаадын албан ёсны тусламжийн төрөл, агуулгыг тодорхойлох, эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэлийг дэмжихэд шаардлагатай загвар, төлөвлөлт, хэрэгжилт болон хяналтын үндэс суурь болгож Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөний тухай үзэл баримтлалыг баталсан болно. Сүүлийн үеийн туршлагаас үзэхэд эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэлийн суурь болж чадах ийм баримт бичиг боловсруулахад бэлтгэл ажил, тухайлбал, Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах урьдчилсан нөхцөл болгож Засгийн газар болон хандивлагч байгууллагуудын тэргүүлэх ач холбогдол өгч байгаа чиглэлүүдийг илүү зөв тодорхойлох замаар эрүүл мэндийн салбарыг илүү нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм. Энэ ажил нь Японы албан ёсны тусламжийн хөтөлбөрүүдийн хүрээнд олон төрлийн арга барил, хамтын ажиллагааны хэлбэрүүдийг хэрхэн хослуулан хэрэглэх байдлаар тодорхойлогдох бөгөөд ингэснээр техникийн туслалцаа үзүүлэх хэд хэдэн арга барилын хамгийн оновчтойг сонгох боломжтой болно. Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөний зорилго нь эрүүл мэндийн салбарын талаар дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээ явуулах, Эрүүл мэндийн яаманд стратеги төлөвлөлтийн чиглэл тогтоож өгөх, төлөвлөлтийн үйл явцад

хандивлагч байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх чиглэлээр хандивлагч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэрэгсэл бий болгох, төлөвлөлт, хяналт-шинжилгээний зүй зохистой арга хэрэгслийг боловсруулах, Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх төслийн жагсаалт гаргах, эрүүл мэндийн салбарын боловсон хүчин, судалгаа шинжилгээ, удирдлага болон төлөвлөлтийн чадварыг сайжруулах зэргээр тус салбарын чадавхийг дээшлүүлэх явдал юм.

### **Б.3. Хөдөлмөр эрхлэлт**

"Үйлдвэрүүд дампуурч, төсвийн байгууллагууд цомхотголд орсон нь олон хүнийг ажилгүй болголоо. Сэргэлэн, овсгоотой нь өөр тийш нүүгээд тийм бус нь эндээ хоцорсон юм" гэж Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлсон байхад "Найман жилийн өмнө боломжийн амьдралтай байсан айлуудын амьдрал аажмаар доошлон ядуу, нэн ядуу бүлэг рүү орсоор байгаагийн шалтгаан нь өмч хувьчлалыг буруу явуулж, олон үйлдвэр, аж ахуйн газрууд хаагдаж, улмаар ажилгүй хүмүүсийн тоо нэмэгдсэнд оршино" гэж Өмнөговь аймгийн Даланзадгад хотын иргэд өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн уналтын байдлын тухай ярьжээ.

**84.** Монгол Улсад ажилгүйдлийн түвшин нэлээд өндөр байна. Хүн амын амьжиргааны түвшингийн 1998 оны судалгаа явуулахад ажилгүйдлийн түвшин 15 орчим хувьтай байсан бол албан ёсны статистикийн мэдээгээр энэ нь 5,9 хувьтай байлаа. Ажилгүйдлийн хувь хэмжээ ийнхүү зөрүүтэй байгаа нь хүмүүс бүртгэлд бүрэн хамрагдаж чадахгүй, бүртгүүлэхэд ямар нэгэн хөшүүрэг, урамшуулал байхгүй, хөдөлмөрийн зах зээл сул хөгжсөн (мэдээлэл хомс бөгөөд ажилд орох боломж бага) зэрэгтэй холбоотой юм. Хөдөлмөрийн насны хүн амын жилийн дундаж өсөлт нийт хүн амын өсөлтөөс 1.5 дахин өндөр байна. Гэтэл ажиллах хүчний оролцооны түвшин 1992-2000 оны хооронд 75.8-аас 63 хувь болтлоо буурсан байна. Ажилгүй иргэдийн 65 гаруй хувь нь залуучууд, тэдний талаас илүү хувийг мэргэжилгүй бөгөөд дунд боловсролтой хүмүүс эзэлж байна. Мэргэжлийн сургалт хүрэлцээгүй байгаагаас ажилгүйдлийн түвшин өндөр байна. Ажилгүйдлийн түвшин мэргэжлийн сургалтад хамрагдах болон хөдөлмөр эрхлэх боломжоос хамааран хот, хөдөөд ялгаатай байна. Тухайлбал, улсын дунджаар 2000 оны эцэст ажилгүйдлийн түвшин 4,6 хувь байхад Улаанбаатар хотод 2,8 хувь байна. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшингийн уналт нь орлогын ядуурлыг бий болгох үндсэн шалтгаан болж байна.

**85.** Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны нөхцөлд хот, суурин газрын улсын үйлдвэрийн газрууд болон хөдөө орон нутгийн нэгдэл, сангийн аж ахуйнуудад тогтвортой ажил хийгээд дасчихсан ажилчдын хувьд 1990 оноос эхэлсэн үйлдвэрлэлийн уналт, бүтцийн өөрчлөлт, өмч хувьчлал нь хүмүүсийн орлогын найдвартай эх үүсвэрийг нь алдагдуулах шалтгаан болж улмаар ажилгүйдлийг нэмэгдүүлэн ард түмний амьдралд хүнд цохилт боллоо. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг ядуурлыг бууруулах үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах шаардлага тулгарч байна.

**86.** Засгийн газар 1995 онд Ажилгүйдлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг баталсан юм. Энэ хөтөлбөрийг 1996-2000, 2001-2010 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. Эхний үе шатанд эдийн засгийн өсөлтийг хангах таатай орчин бүрдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, хүмүүсийн хөдөлмөрийн ур чадварыг дээшлүүлэх, ялангуяа хөдөө орон нутаг жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоодыг хөгжүүлэх, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулах үйлчилгээг сайжруулах замаар нийт ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын 5,8 хувьд хүргэж бууруулах зорилт дэвшүүлсэн байна. Албан ёсны статистик тоо мэдээллээс үзэхэд энэ зорилтод хүрсэн мэт харагдаж байгаа боловч бодит ажилгүйдлийн хувь хэмжээ өндөр хэвээрээ байна. Хэрэгжүүлэх үед төсөл нь нэлээд амжилттай байсан боловч цаашид төсөл тогтвортой эсэх нь тодорхойгүй байна.

## Хүснэгт 8. Хэрэглээний бүлгээр дундаж орлогын хуваарилалт

Бүлэг	Орлого											
	Бүгд	Мөнгөн орлого			Биет орлого	Өрхийн аж ахуйн бус орлого	Хөдөө аж ахуйгаас		Өөрийн үйлдвэрлэлээс хэрэглэсэн	Бусдаас авсан бэлэг	Бусад	
		Бүгд	Цалин	Тэтгэвэр			Тэтгэмж	Хөдөө аж ахуй				Мал аж ахуй
<b>Улсын дүн</b>												
Нэн ядуу	100	50.6	36	11	3.6	0.8	2.8	0.2	8.1	21.1	13	3.4
Ядуу	100	37	29.1	6.7	1.3	0.5	5.4	0.2	12.8	32.4	8.7	2.9
Ядуу бус (б)	100	32.1	26.4	4.9	0.7	0.4	4	0.3	16.5	34.1	8.2	4.5
Ядуу бус (д)	100	32.5	27.6	4.5	0.4	0.2	9.9	0.2	16.1	29.8	7.7	3.5
Ядуу бус (ч)	100	29.4	24.8	4.2	0.3	0.1	12.4	0.2	9.9	28.8	13.4	5.9
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>33</b>	<b>27.2</b>	<b>5.1</b>	<b>0.75</b>	<b>0.29</b>	<b>8.5</b>	<b>0.2</b>	<b>13.3</b>	<b>30.1</b>	<b>10.1</b>	<b>4.4</b>
<b>Хот</b>												
Нэн ядуу	100	71.1	52	15.3	3.8	1.3	4.9	0.1	1.4	4.5	11.6	5.1
Ядуу	100	61	50.1	9	1.8	1	11.2	0	4.4	5.9	12.6	3.9
Ядуу бус (б)	100	59.1	51.2	6.9	1	0.6	9.4	0.3	3.1	5.6	12.2	9.6
Ядуу бус (д)	100	57.1	51.4	5.3	0.4	0.2	17.3	0.1	3	4.2	11.5	6.6
Ядуу бус (ч)	100	45	40.5	4.2	0.3	0.1	22.1	0.2	1.2	3.8	17.2	10.4
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>54.6</b>	<b>47.4</b>	<b>6.4</b>	<b>0.9</b>	<b>0.4</b>	<b>15.9</b>	<b>0.2</b>	<b>2.4</b>	<b>4.5</b>	<b>13.8</b>	<b>8.2</b>
<b>Хөдөө</b>												
Нэн ядуу	100	25.8	16.6	5.8	3.4	0.2	0.3	0.2	16.2	41.3	14.7	1.2
Ядуу	100	15.7	10.3	4.6	0.8	0.1	0.4	0.4	20.2	56	5.3	2
Ядуу бус (б)	100	13.6	9.5	3.6	0.6	0.2	0.3	0.2	25.7	53.5	5.5	1
Ядуу бус (д)	100	14.8	10.4	3.9	0.5	0.2	4.5	0.4	25.6	48.4	4.9	1.2
Ядуу бус (ч)	100	13.3	8.8	4.3	0.3	0.1	2.5	0.3	18.7	54.4	9.4	1.2
<b>Дундаж</b>	<b>100</b>	<b>14.8</b>	<b>10.1</b>	<b>4.1</b>	<b>0.6</b>	<b>0.2</b>	<b>2.3</b>	<b>0.3</b>	<b>22.6</b>	<b>51.7</b>	<b>7</b>	<b>1.2</b>

Эх сурвалж: Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, 1998

**87.** Тусгаар тогтносон улсуудын холбоонд үзүүлэх техникийн туслалцааны (ТАСИС) хөтөлбөр нь тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт явуулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээ бий болгох зэргээр Хөдөлмөр зохицуулалтын албаны чадавхийг бэхжүүлж, Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан юм.

**88.** Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ хөдөлмөр эрхлэх зохих хууль эрхзүйн болон бусад таатай орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Улсын Их Хурлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг батлуулж, эл хууль 2001 оны 6 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон юм. Энэ хууль нь:

- Сургалт, зөвлөлгөө, мэдээллээр хангах,
- Мэргэжлийн сургалт, давтан сургалт явуулах,
- Хувийн аж ахуй эрхлэлт, хоршоодыг дэмжих,
- Ажил олгогч нарыг дэмжих,
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах зэрэгт чиглэж байгаа юм.

**89.** Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль нь (2001 оны 6 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон)



гадаадад ажиллаж байгаа ажилчдын ажлын байрны найдвартай байдал, нийгмийн баталгааг сайжруулах, дотоодод ажилгүйдлийг багасгах, орлогын ядуурлын үндсэн шалтгаан болсон ажилгүйдлийг багасгах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах зэрэг зорилготой юм.

**90.** Хөдөө орон нутагт мэргэжлийн сургалт илүү шаардлагатай байгааг харгалзан Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар хэрэгжүүлэх "Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд орон нутагт мэргэжлийн сургалтын бүсийн төвүүдийг байгуулна. Сургалтыг явуулахдаа тухайн орон нутгийн хүн ам, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлана. Мөн техникийн болон мэргэжлийн сургалтыг зах зээлийн чиг баримжаатай уялдуулж өөрчлөн зохион байгуулах хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ. Энэ чиглэлээр мэргэжлийн сургалтыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

#### **Б.4 Нийгмийн хамгаалал**

*"Биднийг манай ахмадууд, тэтгэврийн хамаатнууд маань л тэжээж байна шүү дээ, тэгэхлээр бид ажил хиймээр байна"* гэж Төв аймгийн Баянцогт сумын залуучуудын бүлэг тодорхойлсон байхад *"Гэрлэх зардал өндөр учир ажилгүй, насанд хүрсэн маш олон залуучууд эцэг эхтэйгээ аж төрж тэднийхээ тэтгэвэрээр амьдарч байна"* гэж Архангай аймгийн Тариат сумын эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэг ярьсан байна.

**91.** Нийгмийн хамгааллын салшгүй хэсэг болох нийгмийн халамжийн тэтгэмж нь нийгмийн эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2 заалтад нийгмийн эмзэг хэсэгт (i) бие даан амьдрах чадваргүй тэжээн тэтгэх төрөл садангүй ганц бие ахмад настан, (ii) тахир дутуу хүн, бүтэн өнчин хүүхэд, (iii) нэн ядуу амьдралтай ахмад настан, (iv) олон хүүхэдтэй тахир дутуу хүн буюу нэн ядуу амьдралтай хүнийг хамруулахаар тодорхойлжээ. Хуулийн дээрх заалтын дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь үүсээгүй, бие даан амьдрах чадваргүй, тэтгэж туслах үр хүүхэд, ах дүү, төрөл садангүй хөгшид, тахир дутуу хүмүүс зэрэг 30.0 гаруй мянган хүн нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр авч байна. Олон хүүхэдтэй болон нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, өнчин хүүхдүүд зэрэг 200.0 гаруй мянган хүнд нийгмийн халамжийн сангаас тэтгэмж, тусламж олгож нийгмийн эмзэг хэсгийн 400 гаруй хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 9. Хүн амын ажил эрхлэлт, жилийн эцэст 1992-2000, (мянган хүнээр)

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
--	------	------	------	------	------	------	------	------	------

1.Хөдөлмөрийн насны хүн ам	1134.6	1133.6	1165.7	1186.7	1212.8	1229.9	1256.8	1279.3	1347.4
2.Эдийн засгийн идэвхтэй хүн ам	860.0	837.3	834.7	812.7	825.0	828.8	842.4	853.4	847.6
3. Ажиллагчид*	806.0	765.4	759.8	767.6	769.6	765.1	792.6	813.6	809.0
4.Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо	54.0	71.9	74.9	45.1	55.4	63.7	49.8	39.8	38.6
5.Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо	104.9	100.5	94.4	102.0	116.3	120.8	125.4	149.5	153.7
6.Хөдөлмөрийн насны тахир дутуу хүмүүсийн тоо	106.1	111.7	136.9	136.2	138.0	82.0	80.2	79.8	77.9
7.Ажилгүйдлийн түвшин (хувь)	6.3	8.6	9.0	5.5	6.7	7.7	5.9	4.7	4.6

Тайлбар: \*Гадаадад ажиллаж буй хүмүүс хамаарахгүй  
Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

**92.** Нийгмийн даатгал нь нийгмийн хамгааллын тогтолцоонд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Одоогийн байдлаар нийт ажиллагчдын 91,8 хувь нь заавал даатгалд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 22,5 хувь нь сайн дурын даатгалд, нийт хүн амын 92,2 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байна. Нийт 254,2 мянган өндөр настангуудын нэг хүнд ногдох дундаж тэтгэвэр 18,4 мянган төгрөг (2000 оны эцсийн байдлаар) байгаа нь цалингийн доод түвшингээс ялимгүй дээгүүр байна.

Хүснэгт 10. **Нийгмийн даатгалын сангаас олгосон өндөр насны тэтгэвэр (2000 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)**

Өндөр насны тэтгэврийн төрөл	Өндөр насны	Тэжээгчээ алдсаны	Тахир дутуугийн	Цэргийн өндөр насны	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	Нийт
Хүний тоо (мян.хүн)	171.6	34.8	32.7	9.3	5.7	254.2
Дундаж тэтгэвэр (мян.төг)	18.7	14.9	14.0	31.7	26.9	18.4

Эх сурвалж: СЭЗЯ

**93.** Одоогоор нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо нэмэгдэж байна. Иймд санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас зарим үйлчилгээг хувийн хэвшил болон нийгэм, хамт олонд шилжүүлэх, нийгмийн халамжийн байгууллагуудын төвлөрлийг багасгах, үйлчилгээг оновчтой хүргэх замаар санхүүжилт, хамралтын үр дүнтэй тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

**94.** Засгийн газар нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах, нийгмийн халамжийн хүрээг зохистой тодорхойлох замаар нийгмийн эмзэг бүлэгт, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан болон тахир дутуу хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилго тавьж байна. Азийн хөгжлийн банктэй хамтарч "Нийгмийн хамгааллын салбарыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд дараах бодлогуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

◆Нийгэм, хамт олонд суурилсан нийгмийн халамжийн төвлөрсөн үйлчилгээний өөр хувилбарыг нэвтрүүлэх

◆ Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг эмзэг бүлэгт чиглүүлэх зорилгоор нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээг оновчтой тодорхойлох

◆ Нийгмийн ажилтны үйлчилгээг өргөжүүлж, чанарыг дээшлүүлэх

## **В. Дэд бүтцийн хөгжил**

### **В.1. Эрчим хүчний хангамж**

*“Цахилгаан хэрэглэснийхээ хөлсийг зарим хэрэглэгчид төлөөгүйгээс шалтгаалан гэрэл таслах явдал түгээмэл байдаг, цахилгааны хангамж сайн биш, дизелийн цахилгаан үүсгүүрийнх нь чадал муу”* гэж Дорнод аймгийн Баяндун сумын 4 дүгээр багийн иргэд ярьсан байна.

**95.** Жижиг, дунд үйлдвэрийг хөдөөд хөгжүүлэх, ажлын байр бий болгох, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эмнэлэг, сургууль зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг эрүүл ахуйн болон техникийн нөхцөлийг хангахуйц орчинд бүрдүүлэхэд хөдөө орон нутагт эрчим хүчний найдвартай бөгөөд тасралтгүй хангамж шаардлагатай байна. Цахилгаан, дулаанаар хангагдаагүй өрхүүд ядуу өрхийн тоонд шилжих магадлал өндөртэй байна. Өнөөдрийн байдлаар хүн амын 14 хувь нь төвийн эрчим хүчинд холбогдоогүй сумуудад амьдарч байна. Эдгээр сумууд дизель хөдөлгүүр ашигладаг бөгөөд зардал нь их өндөр байна. Тийм учраас сумдын иргэд өдөртөө хэдхэн цаг эрчим хүч хэрэглэж байна. Эдгээр сумуудын сургууль, эмнэлэг зэрэг байгууллагууд өвлийн цагт хэвийн нөхцөлд ажиллах боломжгүй байгаа бөгөөд жижиг үйлдвэрүүд байнгын ажиллагаатай байж чаддаггүй. Дээрээс нь хүн амын 40 хувийг эзэлдэг малчин өрхүүд тогтмол эрчим хүчээр хангагдаагүй бөгөөд малчин өрхүүдийн 10 хувь нь л зөвхөн гэрэл чийдэн асааж ажиллуулах хүчин чадал бүхий жижиг цахилгаан үүсгүүртэй болсон байна.

Хүснэгт 11. Ядуурлын тархалт гэрэлтүүлэг ба түлшний эх үүсвэр, байршлаар (хувь)

Ядуурлын бүлэглэл	Гэрэлтүүлэг					Түлш					
	Бүгд	Үүнээс: Цахилгааны эх үүсвэрээр				Бүгд	Үүнээс: Түлшний төрлөөр				
		Цахилгаан	Тосон дэнлүү	Лаа	Бусад		Цахилгаан	Мод	Модны нүүрс	Аргал	Бусад
<b>Улсын дүн</b>											
Нэн ядуу	16.3	16.9	26.4	15.0	0.0	16.3	11.0	16.7	37.3	14.5	28.9
Ядуу	13.7	13.5	15.1	13.8	0.0	13.7	11.9	16.1	13.4	12.3	11.3
Ядуу бус (б)	25.9	23.6	26.4	28.6	25.0	25.9	24.7	28.4	14.9	25.2	23.2
Ядуу бус (д)	23.7	23.7	20.8	23.7	50.0	23.7	25.0	22.4	25.4	26.4	16.2
Ядуу бус (ч)	20.6	22.3	11.3	18.9	25.0	20.6	27.4	16.4	9.0	21.7	20.4
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
<b>Хот</b>											
Нэн ядуу	18.5	17.4	23.1	28.6	0.0	18.5	10.6	25.6	41.1	27.4	22.5
Ядуу	14.2	14.2	7.7	15.5	0.0	14.2	12.0	18.0	14.3	19.2	7.5
Ядуу бус (б)	24.2	24.3	23.1	23.8	0.0	24.2	24.1	25.6	14.3	27.4	25.0
Ядуу бус (д)	21.9	22.0	15.4	21.4	0.0	21.9	25.3	18.0	19.6	16.4	17.5
Ядуу бус (ч)	21.2	22.2	30.8	10.7	0.0	21.2	28.0	12.8	10.7	9.6	27.5
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>0</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
<b>Хөдөө</b>											
Нэн ядуу	14.4	15.5	27.5	13.5	0.0	14.4	19.0	12.6	18.2	12.3	31.4
Ядуу	13.2	11.4	17.5	13.7	0.0	13.2	9.5	15.2	9.1	11.1	12.7
Ядуу бус (б)	27.2	21.2	27.5	29.1	0.0	27.2	38.1	29.8	18.2	24.8	22.5
Ядуу бус (д)	25.2	29.0	22.5	23.9	0.0	25.2	19.0	24.4	54.5	28.1	15.7
Ядуу бус (ч)	20.0	22.9	5.0	19.8	0.0	20.0	14.3	18.1	0.0	23.8	17.6
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>0,0</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>

96. Хүн амын 50 хувь нь төвийн эрчим хүчний сүлжээнээс цахилгаан дулаанаар хангагддаг. Гэвч эрчим хүчний энэ сүлжээ нь хэт их төвлөрсөн, 100 хувь төрийн өмчит монополь үйлдвэрүүд юм. Энэхүү сүлжээ нь өөрөө сул тал ихтэй юм. Тухайлбал, Эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангахтай холбогдсон үнэ өртгийг хянаж зохицуулах чадваргүй, орчин үеийн зах зээлийн зарчимд нийцсэн үнэ тариф болон төлбөрийн уян хатан тогтолцоог хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, удирдлагын давхардсан байдал, санхүүгийн хүндрэлүүд хийгээд техникийн ба техникийн бус алдагдлууд байнга нэмэгдэж байгаа, эрчим хүчний сүлжээнд оруулж байгаа хөрөнгө оруулалт нь зөвхөн одоогийн ажиллаж байгаа тоног төхөөрөмжийг засварлах, үйлдвэрээ зогсоохгүйгээр ажиллуулахад л хүрэлцдэг гэх мэтийг дурьдаж болно. Тийм учраас эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх, зах зээлийн нөхцөлд тохируулан ажиллуулах хууль эрхзүйн орчин шаардагдаж байна.

97. Эрчим хүчний тухай хууль 2001 оны 2 дугаар сард батлагдсан болно. Энэхүү хуулиар эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хангах сүлжээнүүдийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлжээ. Тэгэснээр эрчим хүч үйлдвэрлэгч болон хэрэглэгч нарын хоорондох харилцаа, эрчим хүчний тусгай зөвшөөрлийг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу олгох журмыг тодорхой болгож Эрчим хүчний зохицуулах газар байгуулахаар болжээ. Зохицуулах газар нь эрчим хүчний үнэ тарифыг эрчим хүч хэрэглэгчийн төлбөрийн чадвар, хүн амд үзүүлэх нөлөө, эрчим хүч нийлүүлэгч байгууллагуудын эдийн засгийн өсөлт, ашигтай ажиллах нөхцөл зэрэгт нийцүүлэн тогтоох үүрэгтэй юм.

98. Нүүрсний уурхайнууд төрийн өмч давамгайлсан хувьцаат компаниуд байгаа бөгөөд нүүрсээ Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоосон үнээр борлуулдаг байна. Эрчим хүчний үйлдвэр, нүүрсний уурхайнуудын хооронд үүссэн өрийн сүлжээ улам нэмэгдэж байна. Энэхүү өрийг багасгах талаар нэлээд ажил зохиож байна. Өнгөрсөн 2000 оны 10 сараас өмнө хуримтлагдсан

өрийг тусгай хуваарийн дагуу барагдуулах, түүнээс (10 сараас) хойш нийлүүлэгдэх нүүрсний төлбөрийг цаг тухайд нь хийж байхаар тогтжээ. Энэ эр авлагыг барагдуулахад эрчим хүчний борлуулалтын орлогыг бүрэн цуглуулах асуудал ихээхэн нөлөөтэй юм.

**99.** Засгийн газар ядуурлыг бууруулахад эрчим хүчний салбарын нөлөөг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөөд байна. Үүнд: 40 сумыг төвийн эрчим хүчний сүлжээтэй холбох, 100,000 малчин өрхийг нарны эрчим хүчээр хангах, Улаанбоом, Дөргөн, Чаргайт, Үенчийн усан цахилгаан станцуудыг барих, Баянтээгийн цахилгаан станцыг байгуулах, түүнчлэн "Эрчим хүч түгээх сүлжээний алдагдлыг багасгах" нэртэй төсөл хэрэгжүүлэх зэрэг ажлууд орсон байна. Эрчим хүч дамжуулах сүлжээнээс бусад эрчим хүчний сүлжээний салбаруудыг хувьчилж, эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх бодлогыг Засгийн газар баримталж байна. Эрчим хүчний сүлжээний бүх алдагдлын 15 хувийг техникийн бус буюу хулгай, ядуу амьдралтай хүмүүсийн төлж чадаагүй төлбөр эзэлж байгаа юм. Эрчим хүчний алдагдлыг багасгахын тулд түгээх сүлжээг шинэчлэх, нарийн судалгааны үндсэн дээр уян хатан үнэ тарифын тогтолцоог тогтоох, ядуу болон бага орлоготой өрхүүдийн төлөөгүй хуримтлагдсан өрийг цуцлах арга хэмжээ авна. Хүн амын 54 хувь нь 2001 оны байдлаар эрчим хүчээр хангагдаж байна. Дээрх арга хэмжээг авснаар хангамжийн хувь 14 хувиар өсөх бөгөөд ингэснээр жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хот болон хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдэх орчин бүрдэх юм.

## **В. 2. Тээвэр**

*"Өнөөдөр нүүдэл хийхэд шаардагдах зардал өндөр байна. Бидэнд зусах газар хязгаарлагдмал, жил ирэх тутам л бэлчээр муудаж байна. Ус муутай, өндөр уулс ихтэй учир бид зусландаа гарахын тулд машин хөлсөлж 45 орчим километр замыг туулах болдог. Нүүхэд талдаа л 35000 төгрөг шаардагддаг"* гэж Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын хөдөөгийн багийн эмэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.

**100.** Тээврийн салбарын гол зорилго нь төвөөс алслагдсан бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нааштай нөлөө үзүүлэх, алслагдсан тусгаарлагдмал байдлыг даван туулахад туслах явдал юм. Өнөөдрийн байдлаар улсын чанартай авто замын сүлжээний 13 хувь, нийт замын сүлжээний 3 хувь нь хатуу хучилттай зам юм. Засгийн газар шинээр зам тавих болон ашиглаж байгаа замуудаа засварлах, замын ашиглалтыг сайжруулахад илүү их анхаарал хандуулж байна.

**101.** Зам тээврийн үйлчилгээг сайжруулснаар иргэдийг зах зээлд ойртуулах, нийгмийн болон улсын үйлчилгээг хүн амд зохих ёсоор хүргэх, хот, хөдөөд шинээр ажлын байр бий болгох зэргээр ядуурлыг бууруулахад тус дөхөм үзүүлэх юм. Муу зам, муу машин техник, чадвар муутай жолоочоос шалтгаалан замын осол их гарч байгаа нь ядуурал бий болгох нэгэн хүчин зүйл болдог ажээ. Тиймээс зам тээврийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх, түүний найдвартай, аюулгүй байдлыг хангах замаар бүс нутгийн алслагдсан байдлыг ойртуулахад анхаарал хандуулах шаардлагатай байна.

**102.** Зам тээврийн салбарт тавигдаж байгаа зорилтууд нь хотын болон орон нутгийн зам тээврийн үйлчилгээний хувьчлалыг үргэлжлүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх, бүс нутгийн болон орон нутгийн замыг сайжруулах, зам

тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг болно. Энэхүү зорилтуудыг биелүүлэхийн тулд замын дэд бүтцийг сэргээн хөгжүүлэх, одоогийн дэд бүтцийн үр ашгийг нэмэгдүүлэх, замын салбарт бүтцийн өөрчлөлт хийх, салбарын үйл ажиллагааг сайжруулах зэрэг ажлыг Засгийн газар хийх болно. Мөн төмөр замын тээврийн зардлыг багасгах, үйлчилгээг хөнгөн шуурхай болгох арга хэмжээг авах болно.

**103.** Мянганы зам төслийн хүрээнд ажилгүйчүүдийг зам барих ажилд өргөнөөр татан оролцуулах замаар ядуу иргэдийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Түүнчлэн энэхүү замын дагуу томоохон суурин газруудыг цогцолбороор байгуулахад анхаарал хандуулна. Мянганы зам нь Европ, Азийг холбосон тээврийг хөгжүүлэх үндэс суурь болох бөгөөд замын дагуух сум, суурин газрын эдийн засгийг хөгжүүлэхэд зохих түлхэц болж өгнө.

### **В. 3. Мэдээлэл ба харилцаа холбоо**

*“Мэдээллийг шуурхай болгох, мэдээллийн төв байгуулах, Оросын телевизийн хөтөлбөрийг хүлээн авдаг болох”* гэж Архангай аймгийн Тариат сумын Бөөрөлжүүт, Хорго багийн хүмүүс ярьсан байна.

**104.** Одоогийн байдлаар аймаг, сумын төвүүд 30000 км урт агаарын шугамаар, 900 км урт тоон болон 2100 км урт аналог радио релейн шугамаар, мөн 4200 км урт шилэн кабелийн сүлжээгээр хоорондоо холбогджээ. Мөн 131000 утасны шугамын хүчин чадалтай 332 холбооны станцууд ашиглагдаж байна. Нийт станцын 55 хувь нь тоон технологитой бөгөөд 100 хүн тутамд 4.6 утас ноогдож байна. Зуун мянган захиалагчийн хүчин чадал бүхий үүрэн телефон станц ажиллаж, одоо 100000 гаруй хэрэглэгчтэй болоод байна.

**105.** Холбооны салбарын гол зорилт нь хот, аймаг, сумын техник, технологийг шинэчилснээр үйлчилгээнийхээ чанар, хүртээмжийг сайжруулахад оршино. Энэхүү зорилтын хүрээнд радио, телевизийн студийн тоног төхөөрмжийг сайжруулах, дамжуулах сүлжээ болон телевизийн нэвтрүүлэг дамжуулах тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл хэрэгжүүлнэ. Шуудангийн үйлчилгээг хөгжүүлэх талаар ерөнхий төлөвлөгөө боловсруулж, зарим сум, суурин газруудад шинэ технологи нэвтрүүлнэ. Нарны зайн үүсгүүр үйлдвэрлэж сумдын холбооны салбаруудыг хангана. Харилцаа холбоо-2 болон Харилцаа холбоо-3 төслүүдийн хүрээнд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Увс, Завхан, Архангай, Хөвсгөл, Төв, Налайх, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн төвүүдийн холбоог тоон АТС-т шилжүүлж, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудын сумдын нэг цэгийн радио холбооны станцыг олон цэгийн станц болгоно. Бүх аймгуудын кабелийн шугамуудыг өргөтгөж ашиглалтанд өгнө. Зарим аймгуудад FM радио станцуудыг суурилуулна. Шилэн кабелийн сүлжээгээр Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудын төвийг холбож, холбооны тоног төхөөрөмжийг тоон сүлжээнд шилжүүлнэ.

**106.** Мэдээллийн дэд бүтцийн үйлчилгээг бий болгосноор цахим шуудан, зайн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээ, цахим үйлчилгээ болон бусад нийгмийн үйлчилгээг алслагдсан нутгуудад ашиглах боломжийг бүрдүүлнэ. Тэгэснээр хөдөөгийн иргэд заавал хот руу явж зарим үйлчилгээг олж авах шаардлагагүй болж үйлчилгээний үнэ ч гэсэн буурах болно. Бусад цахим үйлчилгээний төрлүүдийг бас хөгжүүлэх болно.

#### **В. 4. Нийтийн аж ахуйн ба ахуйн үйлчилгээ**

*“Манай сумын усны чанар муугаас элэгний өвчин их гардаг. Зарим хүмүүс сайн устай өөр худгаас ус зөөвөрлөж хэрэглэдэг хэдий ч зарим нь нөгөө л муу устай газраасаа хэрэглэж байна”* гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын төвийн эмэгтэй ярьсан байна.

**107.** Монголд хот руу нүүж суурьших явдал их түргэн өрнөсөн юм. Өнгөрсөн 10 жилд хөдөөгөөс хот, суурин газрууд руу шилжих коэффициент 0.8-аас 4.4-т хүрчээ. Нийт хүн амын 56.6 хувь нь 2000 оны байдлаар хот, суурин газарт амьдарч байна. Хөдөөгөөс хот руу нүүх нүүдэл үргэлжилж, нийт хүн амын 33 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Хүн амын амьжиргааны түвшингийн 1998 оны судалгааны дүнгээр аймгийн төвүүдийн хүн амын өсөлт - 1.6 хувь байхад ядуу хүмүүсийн тоо 5.8 хувиар өсчээ. Энэ нь аймгийн төвүүдэд ядуурлын түвшин харьцангуй өндөр байгааг харуулж байна. Хот, суурин газруудад ядуу хүмүүс олноор суурьшиж, хүн амын нягтрал их байгаа нь хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж, иргэдийн эрүүл ахуй, ариун цэврийн орчныг нэн тэргүүнд гэр хороололд сайжруулах шаардлага хурцаар тавигдаж байна.

**108.** Өнөөдрийн байдлаар Монголын хүн амын 30.8 хувь нь ундны цэвэр усыг төвлөрсөн сүлжээгээр авдаг, 24.8 хувь нь зөөврийн усаар хангагддаг, 38.5 хувь нь ус түгээх цэгүүдээс усаа авдаг, 9.1 хувь нь булаг шанд, гол, горхи, цас мөсний усыг өдөр тутмынхаа хэрэгцээнд хэрэглэдэг байна. Нэг ээлжиндээ 1533 хүнд үйлчлэх хүчин чадал бүхий 259 нийтийн халуун усны цэг байгаагийн 66 нь хэвийн ажиллаж сум, суурин газрын нийтийн халуун усны хангалт дөнгөж 19.7 хувьтай байна. Хүн амын 2000 оны тооллогын дүнгээр бүх хүн амын 50.6 хувь нь гэрт, 48 хувь нь байр орон сууцанд амьдардаг бөгөөд хүн амын 0.6 хувь нь гэр орон сууцгүй байна. Нийт хүн амын 24.6 хувь нь төвийн ахуйн суваг сүлжээнд холбогдсон, 49.5 хувь нь бохир усны сүлжээнд, 78.6 хувь нь хуурай хог хаягдлын үйлчилгээний сүлжээнд 1998 оны байдлаар холбогджээ.

**109.** Нийтийн аж ахуйн ба ахуйн үйлчилгээний гол чиглэлүүд:

◆ Хот, суурин газруудын, ялангуяа гэр хорооллын эрүүл ахуйн түвшинг сайжруулахтай холбогдуулж хог болон бохир усыг зайлуулах, бие засах газрыг тохижуулах ажлуудыг хийнэ.

◆ Сайн чанарын ундны усыг олон нийтэд хүргэх, усыг цэвэршүүлэх, зөөлрүүлэх чиглэлийн ажлуудыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.

◆ Орон сууцны тоог нэмэгдүүлэх төслүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

◆ Бүх аймаг, сумын төвүүдийг нийтийн халуун усны үйлчилгээтэй болгох зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

#### **Г. Бүс нутгийн ба хөдөөгийн хөгжил**

*“Шилжих хөдөлгөөний томоохон давалгаа 1996 оноос эхэлсэн юм. Говь-Алтай аймгийн айлууд Улаанбаатар, Хэнтий аймгийн Хэрлэн, Сэлэнгэ, Багануур, Эрдэнэт, Дархан-Уул, Борнуур луу олноороо нүүлээ. Нүүж байгаа айлууд ихэвчлэн тэндээ хамаатан садан, эсвэл найз нөхөдтэй, шилжих зардлаа даах чадвартай айлууд*

байдаг” гэж Улаанбаатар хотын эрэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.

**110.** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Монгол Улсын Их Хурал 2001 оны 6 сард баталжээ. Энэхүү үзэл баримтлалын гол зорилго нь бүс нутгийн байгаль, хөдөө аж ахуй, газар тариалангийн нөөцийг зөв ашигласнаар тухайн бүс нутагт эдийн засгийн өсөлт болон нийгмийн дэвшлийг түргэсгэж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах таатай нөхцлийг бий болгох, улмаар хүн амын хэт төвлөрлийг сааруулахад оршино.

**111.** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу тухайн бүс нутгийн иргэдэд сурах, амьдрах, мэдээллийг олж авах, тухайн бүс нутгийн амьдралд идэвхтэй оролцох, ижил тэгш боломжийг олгохоос гадна боловсрол, эрүүл мэнд, соёл, мэдээлэл, ахуйн үйлчилгээг жигд өргөжүүлэх юм. Бүс нутгийн хөгжлийг дэмжих хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх ажлыг дунд хугацаанд хийж, тухайн бүс нутгийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, дэд бүтцийн сүлжээг сайжруулах юм.

**112.** Гадаадын хөрөнгө оруулалтыг татаж түргэн хөгжих нөөц чадвар бүхий бүс нутгуудад хөрөнгө оруулалтын тааламжтай эрхзүйн орчныг бүрдүүлнэ. Эхний ээлжинд гадаад зах зээлд ойрхон Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын Үүдэд худалдааны чөлөөт бүсүүдийг байгуулж, мөн тодорхой хотуудыг бүс нутгийн төв болгон хөгжүүлнэ. Нөөц боломж бүхий бүсүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар уул уурхай, жуулчны салбарыг хөгжүүлнэ.

*“1997 оны ган, 1998 оны хуурай хавар өвс ургамлын гарц оройтсон зэрэг нь бэлчээрийн байдлыг доройтуулж олон ч мал үхсэн дээ. Нэг айл 50 үхэр, 30 хонь, 15 ямаагаа алдсан юм. Зарим өрхийн хамаг мал нь үхээд хот нь харлаж хоцорсон билээ”* гэж Ховд аймгийн Мөнххайрхан сумын багийн малчид хүүрнэв.

**113.** Статистикийн 1999 оны тоо баримтаар 267000 малчин өрхүүдийн 83.6 хувь нь 200 хүртэл толгой малтай, эдгээрээс 42.7 хувь нь 50-иас доош толгой малтай өрхүүд байна. Сүүлийн 2 жилийн ган, зуднаас болж малчин өрхүүдийн, ялангуяа цөөн толгой малтай өрхүүдийн амьдралын түвшин маш ихээр буурчээ. Өнгөрсөн жилийн зуданд (1999-2000) 15 аймаг, 158 сум нэрвэгдэж, энэ жилийн зуданд (2000-2001) бүх аймаг нэрвэгджээ. Нийт 2.4 сая толгой мал хорогдож 2400 малчин өрх малгүй болж, нэг мянган өрх 100-аас доош толгой малтай болсон байна. Малын тооллогыг 2001 оны 6 сард хийхээр төлөвлөсөн бөгөөд зудын үр дагаврыг зөв тодорхойлж, цаашдын бодлогыг боловсруулах болно. Тооллогын дүнг боловсруулж байна.

*“Бидний хувьд худаг маш чухал зүйл. Одоо бэлчээр ч муудаж эхэллээ. Хэрэв худаг ус байдагсан бол бид 20 километр ч хамаагүй явж арай илүү бэлчээр дагалгүй яахав дээ”* гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын хөдөөгийн багийн эрэгтэй малчдын бүлэг тодорхойлжээ.

**114.** Хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах хөтөлбөрийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд сум хөгжүүлэх хөтөлбөрт зам засвар, худаг ус гаргах, хуучин худгийг сэргээн засварлах, усжуулалт зэрэг дэд бүтэц хөгжүүлэх арга хэмжээг онцгойлон тусгаж хэрэгжүүлнэ. Бэлчээрийн удирдлага, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлууд нь сум хөгжүүлэх төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно. Бэлчээрийн талхагдалаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлчээрийн даацыг



зөв хуваарилж ашиглах шаардлагатай байна.

**115.** Олон улсын хөгжлийн байгууллагуудаас санхүүжүүлэхээр санал болгосон "Тогтвортой амьжиргааг хангах" төсөл нь ядуурлыг бууруулах үндэсний стратегийг хөдөөд амьжиргааг найдвартай, тогтвортой болгох үйл явцад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны чиглэл рүү шилжилт хийхэд туслах зорилготой юм. Санал болгож буй төсөл нь дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

**116. Бэлчээрийн эрсдэлийн удирдлага:** Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд тохиолддог зуд, ган, малын өвчин буюу үнийн хэлбэлзэл зэрэг эрсдэлийг багасгах цогцолбор стратеги боловсруулж хэрэгжүүлнэ. Төслийн бусад бүрэлдэхүүн хэсэгтэй хамтран малчид ган, зуданд нэрвэгдэж байгаа гол шалтгаануудыг тодорхойлж, эрсдэлийг хязгаарлахад туслана.

**117. Хөдөөгийн жижиг зээлийн үйлчилгээ:** Санхүүгийн болон зохион байгуулалтын хувьд тогтвортой жижиг зээлийн үйлчилгээг /хадгаламж болон зээлийн/ хөдөөгийн ядуу болон эмзэг бүлгийн иргэд, өрхүүдэд хүргэхэд энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт оршино. Жижиг зээлийн эрсдэлийг багасгах арга хэрэгсэл, зээлийн баталгааны хэлбэр болгон бага хэмжээний даатгалын тогтолцоог нэвтрүүлж болох юм.

**118. Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан:** Орон нутагт дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хамгийн чухал зүйл рүү чиглүүлэх, сонголт хийх, хамтран санхүүжүүлэх, хэрэгжүүлэх хамгийн үр ашигтай, олон нийтийн оролцоог хангасан, ил тод арга хэрэгслийг тогтоож хэрэгжүүлнэ. Ингэхдээ Засгийн газраас оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээтэй орон нутгийн нөөцийг уялдуулан дайчлах нь чухал байна.

**119.** Эдгээр төслийн 3 бүрэлдэхүүн хэсэг нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд ядуу ба эмзэг өрх, иргэдийн чадавхийг дээшлүүлж, орлогын эх үүсвэртэй болох боломжийг олгож, орон нутгийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих явдал юм.

*"Манайх зах зээлээс их хол, зөвхөн ганзагын наймаачид өөрсдөө бид нар луу ирдэг. Тэд өмч хөрөнгө, малынх нь тоогоор хүмүүсийг ялгаварлан харьцдаг, тэд малын хашаанд нь цөөхөн мал байвал шууд өнгөрөөд явчихдаг. Малчид дурандаж байгаад наймаачид түр буудалласан айлууд дээр өөрсдөө очдог. Хэдийгээр бид тэднийг бэлэн мөнгөтэй гэдгийг нь мэддэг боловч тэд бидэнтэй бэлэн мөнгөөр наймаа хийдэггүй. Тэд малын маань оронд бараа өгдөг. Харин заримдаа баян чинээлэг өрхүүдтэй том наймаа хийж байхдаа бэлэн мөнгөөр тохиролцдог. Тэд малыг маань шилж, сонгон хамгийн сайныг нь авдаг, гэвч бидэнд өгч байгаа зүйл нь тун ч өчүүхэн. Тэдэндтэй наймаа хийхэд шударга бус, хэцүү байдаг. Бидэнд хуучин байсан худалдааны агентын сүлжээ тун ч их үгүйлэгдэж байна" гэж Дорнод аймгийн Дашбалбар сумын эрэгтэйчүүдийн бүлэг тодорхойлов.*

**120.** Хөдөө орон нутагт урьд нь байсан худалдаа, бэлтгэлийн тогтолцоо бүрэн задарч хувийн хэвшилд шилжсэн бөгөөд шинэ тогтолцоо хараахан бүрдээгүй байна. Одоо дийлэнх сумдын төвд худалдаа, үйлчилгээ ТҮЦ-ийн хэлбэрээр явагдаж байна. Төвийн явуулын худалдаачид гол төлөв ноолуур бэлтгэх, өвөл мал нядлах үеэр хөдөө явж худалдаа арилжаа хийдэг. Гол бэрхшээл нь хот, хөдөөгийн хооронд үнийн зөрүү их байгаад оршиж байна. Тийм учраас Засгийн газар хөдөөгийн иргэд малчдад зах зээлийн мэдээлэл (үнэ

ханш, эрэлт, барааны чанар гэх мэт) хүргэх арга хэмжээг эрчимжүүлж байна. Банкны үйлчилгээг хөдөөгийн хэрэглэгч нарт цэгцтэй хүргэх зорилгоор Хөдөө аж ахуйн банк аймаг, сумдын худалдаа эрхлэгчдэд арилжааны зээл олгож эхлээд байна. Түүнчлэн "Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачилга" хөтөлбөр, "Хөгжлийн алтан сан" банк бус санхүүгийн байгууллага орон нутгийн 12 салбараар дамжуулан хөдөөд чиглэсэн санхүүгийн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын шугамаар нийтдээ 4 тэрбум төгрөгийн арилжааны зээлийг олгосон байна.

## Д. Байгаль орчны хамгаалал

*“Хөдөө чинь маш олон замтай шүү дээ. Гэхдээ бид бэлчээрийг хамгаалах, хөрсний элэгдлээс сэргийлэхийн тулд дахин дахин шинэ зам гаргахыг болиулах нь зүйтэй байгаа юмаа”* гэж Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэн ярив.

**121.** Манай орны нийгэм, эдийн засгийн хөгжил нь байгалийн нөөц баялгийн ашиглалтаас маш их хамааралтай байна. Байгаль орчныг зөв хамгаалж ашигласнаар ажлын байр бий болж, хүн амын эрүүл мэнд сайжирч, байгалийн төрөл зүйл хадгалагдаж үлдэх юм. Байгалиас бүрэн хамааралтай нүүдлийн мал аж ахуй, газар тариалан болон ашигт малтмал олборлолт манай орны үйлдвэрлэлийн салбарт зонхилж байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед олон хүн ажилгүй болж, амь зуухын эрхээр мал маллах, эрдэс олборлох, ан агнах, жимс самар түүх зэргээр байгаль орчинтой ихээхэн харьцах болсноос байгалийн нөөц баялаг хомсдон, байгаль орчны доройтол нэмэгдэж байна. Ийм учраас ядуурлыг бууруулах стратегийг тодорхойлохдоо нэг талаас иргэдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, нөгөөтэйгүүр байгаль орчныг хамгаалах шаардлагыг зохистойгоор уялдуулах нь чухал байна.

**122.** Цөлжилт, бэлчээрийн талхдал нь мал аж ахуй эрхлэн амьдардаг хүн амын 40 орчим хувийн амьжиргааны түвшинд муугаар нөлөөлж байна. Манай орны нийт бэлчээрийн 70 хувьд ямар нэг хэмжээгээр мал бэлчээж байгаа бөгөөд нэг га-гийн өвсний ургац 19-24 хувь буурсан байна. Малын тоо толгой өсч, мал малладаг өрхийн тоо нэмэгдэхийн хэрээр бэлчээрийн даац хэтэрч, худаг, хашаа хүрэлцээгүй болж байна. Малчид малгүй болж олон мянган өрх айл амьдралын эх сурвалжаасаа хагацаж, ядуурлын ирмэгт тулж очих аюул нүүрлээд байна. Иймд цөлжилттэй тэмцэх, бэлчээрийн талхагдлыг бууруулах чиглэлээр цогцолбор арга хэмжээ авах, элсний нүүлтээс хамгаалах ногоон зурвас байгуулах, ганд тэсвэртэй нутгийн уугуул ургамлыг тарималжуулах, бэлчээрийг сэлгүүлэн ашиглах, газрын шинэтгэлийг явуулах зэрэг бодиттой ажлыг орон нутгийн захиргаа, иргэдийн өргөн оролцоотойгоор зохион байгуулна.

**123.** Монгол улс 1992 онд батлагдсан Үндсэн хуулиараа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулж, газар нутаг, байгалийн баялгаа ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна гэж заасан билээ. Энэхүү тулгуур зарчимд үндэслэн Монгол улс нийгэм нь байгальдаа зохицон тогтвортой хөгжих, экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлэх бодлого баримталж байна. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхзүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, 1994 оноос хойш байгаль орчны 25 хуулийг Улсын Их Хурлаар батлуулсан болно. Түүнчлэн Биологийн төрөл зүйлийг хамгаалах, Цөлжилттэй тэмцэх, Усны тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр зэрэг 20 орчим бие даасан хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Монгол улс 1994 оноос байгаль орчны чиглэлийн олон улсын 10 конвенцид нэгдэн орсон болно. Хэдийгээр байгаль орчныг хамгаалах бодлого, эрхзүйн орчин бүрдсэн боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь тус улсын хөрөнгө санхүүгийн нөөц хомс, байгаль орчныг хамгаалах үйлст иргэд, байгууллагын оролцоо дутмаг, энэ талаар орон нутгийн засаг захиргааны хариуцлага, чадавх сул, байгалийн нөөцийг ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд тавьж буй төрийн хяналт, зохицуулалт хангалтгүй байгаа зэрэгтэй холбоотой юм. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн “Хүрээлэн байгаа орчин ба

тогтвортой хөгжил”, “Эрх тэгш байдал ба нийгмийн бодлого” бүрэлдэхүүн хэсгүүдэд дэвшүүлсэн зорилтын хүрээнд байгаль орчныг хамгаалах үүсгэл санаачлагын үндсэн дээр ядуурлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулаад байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд цөлжилттэй тэмцэх, ойжуулах, хот орчмын бохирдлыг багасгах болон газрын шинэчлэлийг эрчимжүүлэх зэрэг үйл ажиллагаа явагдах юм. Эдгээр үйл ажиллагаа нь байнгын болон түр зуурын ажлын байр бий болгох нэмэлт ач холбогдолтой юм. Энэхүү арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлснээр байгаль орчны доройтол бага ч гэсэн хэмжээгээр буурч ядуу иргэдэд ач тусаа өгөх юм.

**124.** Агаарын бохирдол нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарлаж, хүн амын байгаль орчны аюулгүй байдалд занал учруулж байна. Гэр хорооллын 75 мянган айл өрх жилдээ 200 гаруй мянган тонн нүүрс, 160 мянган шоометр мод түлж, орчин тойрондоо үнс хогийг ил задгай хаяж, агаарыг бохирдуулж, өвчлөлийг нэмэгдүүлж байна. Хотын нэг оршин суугчид 90 кг хорт утаа ногдож байгаа нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд нийт хүн ам, ялангуяа хүүхдийн дунд амьсгалын замын эрхтний өвчлөл зонхилж байна. Гэр хороолол нь энэхүү агаарын бохирдлын гол эх сурвалж болж байна. Их Британийн Элчин сайдын яамны санаачилсан агаарын бохирдлыг багасгах туршилтын төсөл амжилттай хэрэгжсэний үндсэн дээр Засгийн газар Даян дэлхийн байгаль хамгаалах сан (GEF)-ийн тусламжтайгаар агаарын бохирдлыг бууруулах эрхзүйн үндсийг боловсронгуй болгох, гэр хорооллын ядуу 75000 айл өрхийг түлш бага хэрэглэдэг, бүрэн шаталттай зуухаар хангах, автомашинаас ялгарах бохирдуулах бодисын хэмжээг хянах, цахилгаан станц болон уурын зуухнуудыг утааны шүүлтүүрээр хангах зэрэг арга хэмжээ авч байна. Эдгээр арга хэмжээг хослуулан хэрэгжүүлсэнээр ядуучууд бодитой үр ашгийг нь хүртэхийн зэрэгцээ экологийн нөхцөл сайжирна.

**125.** Хатуу хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх явдал нь Монгол улсын тулгамдсан зорилт болоод байна. Улсын хэмжээнд 3145 га талбайг хамарсан 447 заагдсан цэгт хог хаягдлыг ил задгай хаяж 11115 га газар хог хаягдлаар бохирджээ. Дүүрэг, хороодын 1999 оны дүнгээс үзэхэд Улаанбаатар хотын хэмжээнд 3 төвлөрсөн хог хаях цэг байдаг боловч эдгээр нь өдөртөө цуглардаг 500,000 шоокилометр хатуу хог хаягдлыг өөртөө шингээж чаддаггүй байна. Хогийг шатаадаг нь агаарын бохирдлыг нэмэгдүүж байна. Тиймээс хатуу хог хаягдлыг зайлуулж, боловсруулах нь хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Агаарын бохирдлыг бууруулах, хатуу хог хаягдлын удирдлагыг сайжруулах талаар ард иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гарах үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжин урамшуулна. Хог хаягдлыг ангилан ялгах болон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна. Энэхүү арга хэмжээ нь ажлын байр шинээр бий болгож хог хаягдлын цэгүүдийн орчинд амьдардаг иргэдийн эрүүл мэндийг сайжруулахын сацуу хатуу хог хаягдлыг зөв зайлуулж боловсруулах явдал нь ялангуяа хүүхдүүдэд ихээхэн ач тустай юм.

*“ Тэд хогийн савнаас юу л олно түүнийгээ л хэрэглэж амьдарч байна даа. Манай энд Тожилийнхон буюу хог ухагчид гэж нэрлэгддэг олон залуу, хөгшин хүмүүс байдаг. Тэд ихэвчлэн ажилгүй, мөнгөгүй, тус дэм авах хамаатан садангүй, найдах хүнгүй, боловсролгүй буюу амьдрахын тулд юу ч хийх сонирхолгүй хүмүүс байдаг юм. Тэдний амьдрал ямар хэцүү байдгийг танд хэлэхэд үнэхээр хэцүү байна.”* гэж Улаанбаатар хотын Багануур дүүргийн эмэгтэй ярьсан байна.

**126.** Монгол Улсын нутаг дэвсгэрийн 8.1 хувийг ой мод эзэлдэг бөгөөд энэ

нь 1990 оныхтой харьцуулахад 2 дахин багасчээ. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан судалгаагаар манай улс дэлхий нийтийн жишгээр ойн нөөцөөр ихээхэн ядуу орны тоонд хамрагдаж байна. Сүүлийн 10-аад жилд ажилгүйдэл, ядуурлын улмаас хууль бусаар түлшний зориулалтын мод бэлтгэх явдал газар авсны зэрэгцээ 1996 оноос хойшхи хугацаанд 6.0 сая орчим га талбай ойн түймэрт өртсөн нь ойн нөөцийг үлэмж бууруулав. Мод үржүүлгийн газар байгуулах, ойжуулах, ойн түймэрт өртөж дутуу шатсан мод, модны нүүрсийг ашиглах, түймрээс хамгаалах зурвас байгуулах, түймрээс сэргийлэх зэрэг ажилд орлого багатай, ядуу иргэдийг татан оролцуулснаар байнгын болон түр ажлын байрыг олноор нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Самар, жимс, эмийн ургамал зэрэг байгалийн дагалт баялгийг зохистой ашиглуулах замаар орлогын нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэхийг дэмжиж байна.

*“ Энэ оны хувьд хар зуд боллоо. Энэ хавар бүх л малаа алдах байх гэж бид бодож байлаа. Энэ ч бидний амьжиргаанд нөлөөлнө шүү дээ”* гэж Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын иргэн ярьсан байна.

**127.** Манай орны ихэнх бүс нутагт цас, зуд, цасан болон шороон шуурга, ой хээрийн түймэр, үер усны аюул, хөнөөлт шавьж, хортон мэрэгчдийн өсөлт зэрэг 10 гаруй төрлийн гамшигт үзэгдэл байнга тохиолдож, давтамж нь нэмэгдэж байна. Байгалийн гамшгийн аюулын улмаас улс орны эдийн засагт жил тутам асар их хохирол учирч хотын ядуучуудын эгнээг өргөжүүлж байна. Байгалийн гэнэтийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх, удаан хугацааны бодлого боловсруулж хүн амыг энэхүү аюул гамшигт нэрвэгдэх эрсдлийг багасгах шаардлагатай байна.

**128.** Монголд нийт урт нь 67 000 км болох 4113 том, жижиг гол мөрөн, 500 шоокилометр усны нөөц бүхий 3060 том жижиг нуурууд, 7000 гаруй тогтмол ундратай булаг шанд байдаг бөгөөд 659 квадраткилометр талбай бүхий 262 мөсөн гол, 120 рашаан, хөрсөн доорхи усны 139 нөөц газрууд байдаг. Монгол улсын нийт усны нөөц 38.8 шоокилометр бөгөөд түүнээс 34.6 шоокилометр нь ашиглаж болох нөөц юм. Ашиглаж болох усны бүх нөөцийн 64 хувь буюу 22 шоокилометр нь гадаргуугийн ус байхад 36 хувь буюу 12.6 шоокилометр нь хөрсөн доорх гүний ус юм байна. Дэлхийн дундажтай харьцуулахад нэг хүнд ногдох ус ашиглалт 3-4 дахин бага байна. Том хот, суурин газруудын гэр хороололд амьдардаг оршин суугч өдөртөө 8-10 литр ус хэрэглэдэг гэсэн судалгааны дүн гарсан бөгөөд энэ нь эрүүл мэндийн шаардлагыг хангах түвшингээс 5 дахин бага байна. Усны нөөц 1999 оны байдлаар бага байснаас болж говь талын бүс нутгийн нэлээд олон сумдын усны хангамж ихэд хязгаарлагдмал байсан байна. Сум, суурин газруудын 38 хувьд оршин сууж байгаа хүн амын ундны усны чанар нь эрүүл мэндийн шаардлагыг нэг буюу нэгээс илүү үзүүлэлтээр хангахгүй байгаа нь тогтоогджээ.

**129.** Байгаль орчны үнэлгээний тухай Монгол Улсын хууль 1998 онд батлагдсан ба одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэ хуулийн дагуу байгалийн баялаг ашигладаг аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн үйлчилгээ, барилга байгууламжууд болон тэдгээрийн өргөтгөл зэрэг бусад төслүүд байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаад үнэлгээ хийх үүрэгтэй Байгаль орчны яамыг байгуулсан юм. Байгаль орчны үнэлгээний ойлголт манай улсад харьцангуй шинэ ойлголт учраас энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд томоохон бэрхшээлүүд учирч байгаа юм. Тухайлбал, энэ хуулийг гарахаас өмнө байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчинд үзүүлсэн нөлөөг үнэлэх ёстой болж байгаа юм. Судалгаанаас үзэхэд улсын үйлдвэрийн газрууд мөнгөгүйгээс

болж байгаль орчны үнэлгээг харьцангуй бага хийлгэдэг. Мөн түүнчлэн байгаль орчны үнэлгээний эрхзүйн орчин хангалтгүй, хуулийг хэрэгжүүлэх болон үнэлгээг хянах арга хэрэгсэл өнөөдрийн шаардлагыг хангахгүй байна. Тийм учраас Байгаль орчны үнэлгээний тухай хуулийг сайжруулах зорилгоор одоогийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн төслийг бэлдэж Засгийн газраар хэлэлцээд УИХ- д өргөн барьсан болно.

**130.** Байгаль орчныг хадгалж хамгаалахад орон нутгийн санаачлага, үйл ажиллагаа гол үүрэг гүйцэтгэх ёстой. Байгаль орчныг хадгалж хамгаалахад орон нутгийн оролцоог Засгийн газар байнга дэмжиж ирсэн болно. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд байгаль орчныг хамгаалах үүрэг бүхий төрийн байгууллагууд ажил үүргээсээ ТББ болон иргэдэд шилжүүлж болно хэмээн заажээ. Өнөөдрийн байдлаар байгаль орчны чиглэлийн 100 гаруй ТББ ажилладаг бөгөөд тэдгээрээс 40 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Түүнээс гадна аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлуудын дэргэд орон нутгийн санаачлагыг дэмжих, үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлэх орон нутгийн зөвлөл ажилладаг. Харамсалтай нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутгийн санаачлага хязгаарлагдмал, хуулийн мэдлэг хомс, ядуурал их байгаа учраас байгалийн баялгийг хууль бусаар ашиглах явдал /мод огтлох, ан агнах/ өргөн хүрээтэй байна. Олон нийтийг, тэр дундаа ядуу иргэдийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр соён гэгээрүүлэх, байгаль орчны үйл ажиллагаанд өргөн хүрээтэйгээр татан оролцуулах нь их чухал болоод байна.

**131.** Засгийн газар Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний тухай тогтоолыг 1995 онд баталж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Дэлхийн банкаар зуучлуулан Норвегийн сангийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний хүрээнд 1995 оноос хойш гарсан байгаль орчны ба бусад салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах чиглэлээр УИХ дээрх хөтөлбөрийг хянан боловсруулсан байна. Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний зорилт нь байгаль орчиндоо зохицсон, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хүн ардын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, байгалийн нөөцийг зохистой ашигласнаар ядуурлыг бууруулах явдал юм. Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээ нь нийт 11 бүлэгтэй юм. Энэхүү хөтөлбөр нь стратегийн 5 зорилтыг биелүүлэхэд чиглэгдэж байна. Үүнд: Байгаль орчны бодлогын зохицуулалт ба эрхзүйн орчныг боловсронгуй болгох, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны удирдлага болон байгалийн баялгийн удирдлагыг сайжруулах, байгаль орчны судалгаа, үнэлгээ, мэдээлэл ба хяналтын тогтолцоог бий болгох, экологийн боловсрол болон олон нийтийн оролцоог дээшлүүлэх, бохирдолд тавих хяналт болон байгалийн төрөл зүйлийг хадгалахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг болно. Энэхүү хөтөлбөрт тэргүүлэх чиглэлийн төслүүдийг тодорхойлж, байгаль орчны чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлжээ.

## **Е. Засаглал**

*“Сумын захиргааныхан бидний ажилд маш их нөлөөтэй байх ёстой, гэртэл тэд хүнд хүрч ажиллахгүй байна.”* гэж Төв аймгийн хөдөөгийн багийн иргэд хэлсэн байна.

**132.** Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг 2000 оноос боловсруулан хэрэгжүүлж байна. Бодлого боловсруулагчид болон үр

шимийг хүртэгчид зөвшилд хүрэх нь асар ач холбогдолтой юм. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр нь Засгийн газрын байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, иргэний нийгмийн дэмжлэгэтэйгээр үндэсний хэмжээнд бодлого хэрэгжүүлэх замаар ядуурлыг бууруулах стратегийн бодлогын чиглэл, уялдаа холбоо, тогтвортой байдлыг хангана.

**133.** Засгийн газрын бодлого боловсруулах, Улсын Их Хурлаар хууль батлуулахаас хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, олон нийт түүний санаа бодлыг засаглалд оролцуулах нь ихээхэн амаргүй ажил билээ. Гэхдээ хэрэв ингэж чадвал бодлого нь жинхэнэ нийгмийн бодлого болох бөгөөд хэрэгжилтэд нь нийгмийн бүх салбар оролцож гэмээнэ маш үр ашигтай, тогтвортой байх болно. Чухамхүү ингэж л сайн засаглал нь хүний аюулгүй байдлыг хангасан орчин бий болгох юм.

**134.** Сайн, зохистой засаглалыг тогтоохын тулд Засгийн газар дараах үндсэн хоёр зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

◆ Засаглалын хямралыг арилгаж, хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг тогтоох

◆ Шүүхийн тогтолцоо, чөлөөт хэвлэл мэдээллийн бие даасан байдлыг хангах замаар иргэний үндсэн эрх, ардчиллын үндсэн зарчмуудыг баталгаажуулах чанд ёс суртахуун бүхий ардчилсан иргэний нийгмийг байгуулах

**135.** Эдгээр зорилтыг биелүүлэхийн төлөө дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шийдвэр төгс байна. Үүнд:

◆ Засгийн газрын байгууллага, бизнесийн үйл явцын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, гүйцэтгэх үйл ажиллагаа, санхүү, төлөвлөлт, тайлагналт, хариуцлагын удирдлагын арга хэрэгслийг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээний чанар, хариуцлагыг нэмэгдүүлж, нэр хүндийг нь өргөх

◆ Нийгмийн үйлчилгээний удирдлагын мэдээллийн тогтолцооны сүлжээг байгуулах, түүний найдвартай байдлыг орчин үеийн технологийг ашиглах үндсэн дээр хангах, гүйцэтгэх салбарын шийдвэр гаргах, хэрэгжүүлэх арга хэрэгслийг боловсронгуй болгох

◆ Засгийн газрын байгууллагуудын дотоодын болон гадны ажиглалт үнэлгээний зохих арга хэрэгслийг бүрдүүлэх

◆ Хууль, шүүхийн байгууллагын эрх мэдэл, зохион байгууллалтын эрхзүйн үндсийг бэхжүүлэх талаар олон талт арга хэмжээ авах, шүүхийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлийг гүнзгийрүүлж, шүүхийн байгууллагын хэнээс ч үл хамаарах бие даасан байдлыг хангаж, түүний нэр хүндийг дээшлүүлэх

◆ Хэвлэлийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, түүний хариуцлагын тогтолцоог сайжруулах замаар төрийн бодлогыг ард түмэнд хүргэх ажлыг сайжруулах

◆ Нийгмийн үйлчилгээний хариуцлагын тогтолцоог сайжруулж, хээл хахууль, авилга, гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэх

◆ Олон нийттэй харилцах харилцааны удирдлагыг сайжруулж, төрийн байгууллагын үйл ажилагааны ил тод байдлыг хангаж, ТББ-тай ажил хэргийн ойр дотно харилцаатай болох асуудлыг бүх талаар дэмжих

## **Г.Дунд хугацааны зорилтууд**

**136.** Дараах хүснэгтэд Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөртэй холбогдол бүхий макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн харуулав.



Хүнэгт 12. Макро эдийн засгийн хүрээ, 1997-2004

	1997	1998	1999	2000*	2001**	2002**	2003**	2004**
I. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	25.5	27.6	27.2	33.6	33.6	32.7	32.6	32.6
II. УРСГАЛ ОРЛОГО	24.7	26.5	26.5	33.2	33.1	32.0	32.0	32.0
1. Татварын орлого	19.7	18.8	19.7	25.0	25.7	24.9	24.9	24.9
1.1. Орлогын албан татвар	7.5	5.1	4.2	6.0	5.7	5.8	6.0	6.2
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	2.6	3.2	3.3	3.8	3.3	3.3	3.3	3.3
1.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар	4.6	5.6	6.5	7.3	8.0	7.9	7.9	7.8
1.4. Гаалийн албан татвар	2.4	3.0	2.9	3.9	4.0	4.0	3.9	3.8
1.5. Онцгой албан татвар	0.6	0.8	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.7
1.6. Гадаад худалдааны татвар	1.1	0.2	1.0	2.1	2.7	2.0	2.0	1.9
1.7. Бусад татвар	1.0	1.0	1.0	1.1	1.3	1.2	1.1	1.1
2. Татварын бус орлого								
III. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	5.0	7.7	6.8	8.2	7.4	7.2	7.1	7.2
IV. ТУСЛАМЖ	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	0.7	1.0	0.7	0.5	0.5	0.6	0.6	0.6
II. УРСГАЛ ЗАРЛАГА	34.5	41.9	39.4	40.5	41.0	39.8	39.2	38.6
1. Бараа ба үйлчилгээ	23.1	27.2	26.7	30.1	30.5	29.0	28.6	28.1
1.1. Цалин хөлс	15.4	19.0	17.8	20.2	19.8	18.7	18.4	18.0
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	5.4	6.8	6.9	8.2	7.5	7.1	6.9	6.7
2. Зээлийн үйлчилгээний зардал	10.0	12.2	10.9	11.9	12.3	11.6	11.5	11.4
3. Татаас ба шилжүүлэг	2.5	1.4	1.9	1.7	1.7	1.7	1.5	1.5
3.1. Улсын үйлдвэрийн татаас	5.2	6.8	7.1	8.1	8.0	7.6	7.6	7.5
3.2. Шилжүүлэг	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
Зудын хохирол нөхөх зардал	5.2	6.8	7.0	8.1	7.9	7.6	7.6	7.5
III. ХӨРӨНГИЙН ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0	0.0	0.0	1.0	1.0	1.0	1.0
	11.4	14.6	12.7	10.4	10.5	10.8	10.6	10.6
Урсгал тэнцэл								
Нийт тэнцэл	1.6	-0.7	-0.2	3.1	2.7	3.1	3.4	4.0
Санхүүжилт:	-9.1	-14.3	-12.2	-6.8	-7.3	-7.1	-6.6	-6.0
1. Гадаад (цэвэр)	9.1	14.3	12.7	6.8	7.3	7.1	6.6	6.0
2. Дотоод (цэвэр)	11.1	8.4	11.4	6.4	4.9	6.8	6.1	5.7
3. Эх үүсвэрийн дутагдал	-2.1	5.9	1.2	0.4	0.3	-1.6	-0.4	-0.1
	0.0	0.0	0.0	0.0	2.2	1.9	0.9	0.5

Эх сурвалж: СЭЗЯ, Тэмдэглэл: \*\*Хэтийн тооцоо

137. Дээрх хүснэгтэд макро эдийн засгийн дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлсний дүнд хүрэх үндсэн зорилтуудыг харуулав. Энэ бодлого нь дараах үйл ажиллагаанд чиглэх юм. Үүнд:

◆ Эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн салбарыг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, сайн засаглалыг тогтоох замаар ядуурлыг багасгах үндсэн

стратегийг хэрэгжүүлнэ.

◆ Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, санхүү, мөнгөний оновчтой бодлого явуулах, бизнес хөгжих таатай орчныг бий болгох, өрсөлдөөнт үйлдвэрлэлийг дэмжих замаар хувийн хэвшлийн хөгжилд тулгуурлан эдийн засгийн өсөлтийн хурдцыг нэмэгдүүлнэ.

◆ Төсөв, санхүүгийн хувьд төсвийн зарцуулалтыг ил тод болгох, хариуцлага, сахилга батыг сайжруулахад чиглэсэн шинэчлэлд тэргүүлэх ач холбогдол өгч, төсвийн хуваарилалтыг оновчтой болгоно.

◆ Банкны хяналтыг сайжруулах, төрийн өмчийн банкуудыг хувьчлах ажлыг эрчимжүүлэх, зах зээлд нийцсэн мөнгөний бодлогын шууд бус зохицуулалтын тогтолцоонд шилжүүлэхэд чиглэсэн банкны бүтцийн өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

#### **IV. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг боловсруулах зохион байгуулалтын бүтэц**

**138.** Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2000 оны 10-р сард Дэлхийн банк, Олон улсын валютын сантай хамтран уулзалт, семинарыг зохион байгуулсан юм. Энэхүү семинарт төрийн бус байгууллага, хандивлагчдын төлөөлөгчид, орон нутгийн төлөөлөгчид өргөнөөр оролцож, эл баримт бичгийг боловсруулах чиглэл, удирдамж болон анхаарал төвлөрүүлэх асуудлуудын талаар хамтран хэлэлцсэн болно. Энэ нь баримт бичиг боловсруулах үйл явцын эхлэл байсан юм.

**139.** Санхүү, эдийн засгийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар тэдгээр яамд, Монгол банк, Үндэсний статистикийн газар, судалгаа шинжилгээний болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулан ажиллууллаа (тушаалыг хавсаргав). Баримт бичгийн эхний хувилбарыг ажлын хэсэг 2000 оны 10-р сард бэлэн болгож Дэлхийн банкинд илгээсэн юм. Түүнээс хойш баримт бичгийг эцэслэн боловсруулах үйл явц оролцооны зарчимд тулгуурлан тасралтгүй үргэлжилж байна.

**140.** Энэ хугацаанд Дэлхийн банк, Соросын сан хамтран Хөгжлийн төлөө хэлэлцүүлгийг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулсан нь харилцан мэдээлэл солилцох үр дүнтэй арга хэмжээ болсон юм. Хөгжлийн төлөө үндэсний хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоог хангахад ихээхэн анхаарсан нь бас нэг онцлог байлаа. Энэхүү хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, яам, газар, орон нутгийн удирдлагын төлөөлөгчид, хандивлагчидын төлөөлөгчид, төрийн бус байгууллагууд, олон нийт, тэр дундаа ядуучуудын төлөөлөгчдийг урьж оролцуулсан юм. Уг арга хэмжээнд Засгийн газар идэвхтэй оролцсон бөгөөд хэлэлцүүлгийн үр дүнг энэхүү баримт бичгийг боловсруулах явцад анхааран үзэж зарим саналуудыг төсөлд тусгаж байна.

**141.** Олон улсын байгууллагаас зохион байгуулж байгаа семинар, ярилцлагад төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг өргөнөөр оролцуулан баримт бичиг боловсруулах чадавхийг бэхжүүлэхэд Засгийн газар тусгайлан анхаарч байна. Дэлхийн банк, Монгол Улсын Засгийн газар

хамтран төрийн бус байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, оролцоог хэрхэн хангах талаар санал солилцов.

**142.** Баримт бичгийг боловсруулах явцад Засгийн газрын байгууллагууд өөрсдийн хариуцсан асуудлын чиглэлээр оролцож байна. Санхүү, эдийн засгийн яамны ажлын хэсгийнхэн бусад гишүүд, тэдгээрийг хариуцсан удирдлагуудад ажлын явцыг байнга танилцуулан, тэдний санал бодлыг тухай бүр тусгаж, дахин танилцуулах замаар ажлаа зохион байгуулж, салбарын яамдтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Энэ баримт бичигт яамд, төрийн бус байгууллагууд, түүнчлэн олон улсын байгууллага, хандивлагчдын саналыг тусгаж байна. Мөн төрийн бус байгууллагын төлөөлөгчидтэй саналаа солилцож, ядуурал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, байгаль орчин зэрэг чиглэлээр хамтран гүйцэтгэх ажлаа улам нарийвчлан тодорхойлсон болно. Мөн 5, 6-р саруудад ажлын хэсэг хэд хэдэн удаа уулзаж стратегийн тэргүүлэх асуудлууд, хяналт-шинжилгээ хийх шалгуурууд болон бодлогын хэв загвар (матриц)-ыг хэлэлцсэн юм. ЯБСББ-ийн бүрэн хувилбарыг бүрдүүлэхийн тулд салбар болгонд нэмж оруулах мэдээллүүдийг тодорхойлж өгсөн болно. Түүнчлэн төсөлд санал авахаар хандивлагч байгууллагуудад илгээсэн болно. Дэлхийн банкны байнгын төлөөлөгчийн газар болон Дэлхийн банкны төв алба энэхүү төсөлд онцгой анхаарал хандуулсан юм. Дэлхийн банкны ажилтнууд холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хэд хэдэн хамтарсан уулзалтуудыг зохион байгуулсан юм. ЯБӨХ болон ЯБСЗББ-ийг хооронд нь уялдаа холбоотой байлгахад анхаарч, төсвийн тухай хавсралтад зохих анхаарлаа хандуулсан болно.

**143.** Саяхан зохион байгуулагдсан хандивлагчдын зөвлөлдөх уулзалтын үед тэмдэглэгдсэн ядууралтай холбоотой санал, зөвлөмжүүд, ОУВС-тай урьдчилсан байдлаар тохирсон Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн үзүүлэлт, бодлогын арга хэмжээ зэргийг энэхүү баримт бичигт тусгасан болно.

**144.** Засгийн газраас Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулах ажлыг Зохицуулах хороог байгуулж ажиллуулна. Зохицуулах хороо нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд, хандивлагчдын төлөөлөгчдөөс бүрдэж, ажлаа Засгийн газарт тайлагнана. Уг хороог Санхүү, эдийн засгийн сайд тэргүүлнэ. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн төсөл боловсруулах үүрэгтэй салбар дундын ажлын хэсгийг байгуулна. Ажлын хэсэг нь Зохицуулах хороонд ажлын үр дүнгээ тайлагнана. Түүнчлэн макро эдийн засгийн асуудал эрхэлсэн ажлын дэд хэсгийг Санхүү, эдийн засгийн яам, Дэд бүтцийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам болон Төв банкны төлөөлөлтэйгөөр; нийгмийн асуудал эрхэлсэн ажлын дэд хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Байгаль орчны яамны төлөөлөлтэйгөөр тус тус байгуулах бөгөөд хуульзүй, засаглал, иргэний нийгмийн оролцооны асуудал эрхэлсэн ажлын дэд хэсэгтэй байна. Эдгээр ажлын хэсгүүд ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсгийг бүрэн боловсруулах үүрэг хүлээнэ. Мөн Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ажлын хэсгүүд хөтөлбөр, төслүүдийн уялдаа холбоог хангах асуудлыг давхар хариуцана.

## **V. Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг боловсруулах,**

## **хэрэгжүүлэх оролцоог хангах**

**145.** Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад оролцооны аргыг өргөн ашиглана. Баримт бичгийг боловсруулах явцад төрийн бус байгууллагуудаар тодорхой салбар, асуудлыг судлуулах, тэдгээрийг бүс нутгийн уулзалтуудад идэвхтэй оролцуулах, ТББ-ын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах, ТББ-ын төлөөлөгчдийг ажлын дэд хэсэг, Үндэсний зохицуулах хороонд орж ажиллуулах зэргээр тэдний өргөн оролцоог хангах болно. Оролцоог зохион байгуулахдаа Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, ажлын хэсгээр ажиллах үйл ажиллагааны хэлбэрт тулгуурлана.

**146.** Орон нутгийн болон үндэсний зөвлөлдөх, санал солилцох уулзалтууд, ажил төрлийн зөвлөлдгөөн, бусад арга хэмжээнүүдэд төрийн өндөр албан тушаалтан, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, орон нутгийн удирдлагууд, хандивлагч байгууллагуудын төлөөлөгчид, хувийн хэвшлийнхэн, төрийн бус байгууллагууд, иргэд, ялангуяа ядуучууд, нийгмийн эмзэг бүлгийнхний төлөөллийг оролцуулах болно.

**147.** Стратегийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх үйл хэрэгт өргөн олны оролцоог хангах үүднээс түүний агуулга, чиглэл, төлөвлөсөн арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, олон нийтийн санаа бодол, дуу хоолойг сонсох талаар хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллана.

**148.** ЯБСББ боловсруулах явцад холбогдох бүх чиглэлийн төлөөлөгчдийг оролцуулсан хэд хэдэн хамтарсан үйл ажиллагааг явуулахаар төлөвлөж байна. (Хавсралтыг үзнэ үү)

## **ҮІ. Хяналт-шинжилгээ (мониторинг)-ний үзүүлэлтүүд**

**149.** Засгийн газрын хүн амын ядуурлыг бууруулах стратегийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэх нэг утвар нөхцөл нь үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт-шинжилгээ хийх явдал юм. Үүний тулд Засгийн газар хүн амын ядуурлыг бууруулах стратегийн зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд шаардлагатай хүн амын амьжиргааны түвшингийн үзүүлэлтүүдээр мэдээллийг тогтмол цуглуулах, дүн шинжилгээ хийх, хэвлэн нийтлэх тохиромжтой арга хэрэгслийг буй болгон сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. Үндэсний статистикийн газар амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгааны үр дүнг эцэслэн боловсруулж, ядуурлын холбогдолтой мэдээллийг чанарын үзүүлэлтээр баяжуулна. Эдгээр мэдээллийг хэвлэн нийтэлж байх болно.

**150.** Засгийн газраас НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлсэн Хүүхдийг хөгжүүлэх талаар баримтлах үйл ажиллагааны тухай үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэнэ. Хүүхдийн төлөө 2001 онд болох дэлхийн дээд хэмжээний уулзалтад бэлтгэх зорилгоор "Хүүхэд хөгжил" судалгааг явуулав. Судалгаагаар цуглуулсан эх, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн хангамж, дархлаажуулалтад хамрагдсан байдал, цэвэр усны хангамж болон бусад асуудлын талаарх мэдээлэлд боловсруулалт хийж, үр дүнг хэвлэн нийтлэнэ.

**151.** Засгийн газар ядуурлын талаар хяналт- шинжилгээ (мониторинг) хийх судалгааны нэгжийг байгуулна. Уг нэгж нь ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ хийх үүрэг хүлээнэ. Зохих дадлага, туршлага бүхий төрийн бус байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулна. Энэ нь Засгийн газрын тэргүүлэх чиглэл, бодлогыг хамарсан Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн бодлогын хэрэгжилтийн цогцолбор үнэлгээний нэгэн хэсэг нь байх болно.

**152.** Засгийн газар төлөвлөсөн зорилгодоо хүрэхийн тулд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалт, эх, нялхсын эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бага болон дунд сургуульд хамрагдалт, дархлаажуулалт зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн ядуурлыг бууруулах стратегийнхаа хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх талаар хүчин чармайлт гаргана.

**153.** ЯБСЗББ-ийг боловсруулах явцад зарим бэрхшээлтэй тулгарч байлаа. Үүнд:

А. Мэдээллийн олдоц хангалтгүй байна. Хэдийгээр статистикийн байгууллага, бусад газрууд, олон улсын байгууллагаас гаргасан тоо баримт байгаа боловч ядуурал, эмзэг бүлэг зэргээр нь ангилсан тоо, мэдээ хомс байна. Тухайлбал, үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээний талаар мэдээлэл байдаг боловч ядуучуудад хэрхэн нөлөөлж буй талаар дүгнэлт хийх боломжгүй байна;

Б. Засгийн газрын дэвшүүлсэн эн тэргүүний зорилго бол эдийн засгийн өсөлтийг хангаснаар ядуурлыг бууруулах явдал юм. Гэвч үүнийг хэрэгжүүлэх онол, аргазүйн нэгдсэн ойлголт төдийлөн бүрдээгүй байна;

В. Стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах явцад холбогдох байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тогтолцоо, үндэсний чадавх хангалтгүй байна. Иймд эдгээр зүйлээр техникийн туслалцаа авах

шаардлагатай байна.

\* \* \*

### Хүснэгт 13. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүд, 1997-2004

	1997	1998	1999	2000*	2001**	2002**	2003**	2004**
ДНБ-ний өсөлт (хувиар)	4.0	3.5	3.2	1.1	1.4	4.0	5.0	6.0
Аж үйлдвэр (хувиар)	-3.3	4.2	1.1	7.5	6.6	5.5	5.7	5.8
Хөдөө аж ахуй (хувиар)	4.3	6.4	4.2	-16.8	-8.7	0.5	3.0	5.3
Хэрэглээний үнийн индекс (жилийн эцэст)	20.5	6.0	10.0	8.1	8.0	6.0	5.0	5.0
Хэрэглээний үнийн индекс (жилийн дундаж)	36.6	9.4	7.6	11.6	8.8	6.0	5.0	5.0
Гадаад валютын цэвэр нөөц (сая ам.доллар)	137.5	124.6	156.7	190.9	209.2	237.1	259.8	284.2
Импортын хэмжээ (7 хоногийн)	12.3	11.4	11.9	14.2	14.8	16.0	16.5	17.0
<i>ДНБ-нд эзлэх хувь</i>								
Нийт орлого	25.5	27.6	27.2	33.6	33.6	32.7	32.6	32.6
Урсгал орлого	24.7	26.5	26.5	33.2	33.1	32.0	32.0	32.0
Татварын орлого	19.7	18.8	19.7	25.0	25.7	24.9	24.9	24.9
Нийт зарлага ба цэвэр зээл	34.5	41.9	39.4	40.5	41.0	39.8	39.2	38.6
Урсгал зарлага	23.1	27.2	26.7	30.1	30.5	29.0	28.6	28.1
Төсвийн урсгал тэнцэл	1.6	-0.7	-0.2	3.1	2.7	3.1	3.4	4.0
Нийт төсвийн тэнцэл	-9.1	-14.3	-12.2	-6.8	-7.3	-7.1	-6.6	-6.0
Санхүүжилт	9.1	14.3	12.7	6.8	7.4	7.1	6.6	6.1
Гадаад (цэвэр)	11.1	8.4	11.4	6.4	4.9	6.8	6.1	5.7
Дотоод (цэвэр)	-2.1	5.9	1.2	0.4	0.3	-1.6	-0.4	-0.1
Эх үүсвэрийн дутагдал					2.2	1.9	0.9	0.5
<i>Гадаад худалдаа, сая ам.доллар</i>								
Экспорт	569.5	462.3	454.3	537.1	549.2	601.0	647.5	692.9
Импорт	-538.3	-582.4	-567.3	-687.3	-698.9	-733.2	-771.1	-819.2
Худалдааны тэнцэл	31.1	-120.1	-113.0	-150.2	-149.7	-132.2	-123.6	-126.3
<i>ДНБ-нд эзлэх хувь</i>								
Урсгал дансны тэнцэл (албан ёсны шилжүүлэг ороод)	7.1	-7.8	-6.3	-7.0	-7.3	-7.1	-6.1	-5.9
Урсгал дансны тэнцэл (албан ёсны шилжүүлэг ороогүй)	1.3	-13.2	-13.7	-17.2	-16.7	-14.7	-13.4	-12.7
Гадаад өрийн эзлэх хэмжээ	57.4	77.4	93.9	88.0	89.4	93.6	94.2	93.1
ДНБ оны үнээр (тэр.төг)	832.6	817.4	925.3	1044.6	1152.4	1270.4	1400.6	1558.9
ДНБ-ний дефляторын өсөлт (хувиар)	23.8	-5.2	9.7	11.7	8.8	6.0	5.0	5.0
Валютын ханш/ 1 ам. доллар, төг/Ж.Э	813.2	902.0	1072.4	1097.0	.....	.....	.....	.....
Валютын ханш/ 1 ам.доллар, төг/Ж.Д	790.0	840.8	1021.9	1076.7	.....	.....	.....	.....
Хүн амын тоо, мян.хүнээр	2311.3	2344.5	2373.5	2407.5	2443.6	2480.2	2517.4	2555.2
ДНБ (сая ам.доллар)	1054.0	972.1	905.5	970.2	1019.9	1077.8	1156.1	1256.9

Тайлбар: \*Урьдчилсан \*\*Хэтийн тооцоо  
Эх сурвалж: СЭЗЯ

Хүснэгт 14. Эрүүл мэндийн салбарын үзүүлэлтүүд, 1990-1999

	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Дундаж наслалт, жилээр	--	--	62.8	--	--	63.8	--	64.3	65.1	--
Эрэгтэй, жилээр	--	--	60.7	--	--	62.1	--	61.1	62.7	--
Эмэгтэй, жилээр	--	--	64.9	--	--	65.4	--	67.7	67.6	--
Дутуу жинтэй төрсөн нярай, 2.5 кг-аас доош хувь	4.4	5.0	6.3	6.0	6.6	6.4	5.5	5.9	5.1	5.0
Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага, ДНБ-нд эзлэх хувь	5.5	5.8	4.1	3.8	4.1	3.7	3.6	3.8	3.3	3.8
Эндэгдэл: Нярайн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд хувь	64.4	62.6	59.5	61.2	48.0	44.4	40.0	39.6	35.3	37.3
5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд хувь	--	--	--	82.6	67.8	62.0	56.4	55.6	47.8	49.0
Эхийн эндэгдэл, 100000 амьд төрөлтөд хувь	119	131	203	240	212	185	175	145	158	175
Эмчийн хяналтад төрсөн, хувь	99.0	99.0	99.0	98.0	98.0	99.0	99.5	99.8	99.3	99.0
Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийн олдоц, хувь	--	--	15.0	--	--	28.0	38.0	42.0	44.2	--
Үр дөндөлт, 1000 эмэгтэйд хувь	59.5	60.5	52.8	35.3	29.5	30.7	25.3	20.3	14.0	15.5

Эх сурвалж: Эрүүл мэндийн яам



Хүснэгт 15: Боловсролын салбарын үзүүлэлтүүд, 1990-1999  
(хувь)

	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
<b>А. БАГА АНГИЙН</b>										
Нийт элсэлт	105.8	91.0	81.5	78.7	86.0	93.4	95.3	102.2	102.9	103.8
Эмэгтэй	106.4	91.5	82.4	79.8	86.6	93.6	96.1	103.2	103.4	104.4
Эрэгтэй	105.4	90.5	80.6	77.5	85.4	93.1	94.4	103.2	103.4	103.4
Элсэх нас, жилээр	105.3	8	8	8	8	8	8	101.2	102.5	103.1
Хугацаа, жилээр	83	3	3	3	3	3	4	82	84	84
<b>Б. ДУНД АНГИЙН</b>										
Нийт элсэлт		84.6	79.1	81.5	80.2	77.2	65.9			
Эмэгтэй		--	90.4	91.0	89.4	85.1	72.3			
Эрэгтэй		--	68.0	72.2	71.1	69.3	59.4			
Элсэх нас, жилээр	94.1	11	11	11	11	11	12	60.8	70.9	76.8
Хугацаа, жилээр	97.6	5	5	5	5	5	4	66.5	76.9	82.4
	90.7							55.0	65.0	71.1
<b>В. АХЛАХ АНГИЙН</b>										
Нийт элсэлт	115	30.9	30.3	29.7	31.5	34.4	50.1			
Эмэгтэй		--	39.5	39.5	41.8	45.0	63.3			
Эрэгтэй		--	20.9	19.7	21.0	23.6	36.7			
Элсэх нас, жилээр	41.9	16	16	16	16	16	16	49.3	31.2	34.1
Хугацаа, жилээр	51.0	2	2	2	2	2	2	61.0	38.1	40.7
	32.8							37.3	24.2	27.4
<b>СУУРЬ БОЛОВСРОЛ*</b>										
Нийт элсэлт	162	87.1	80.1	80.3	82.8	84.3	82.4			
Эмэгтэй		--	87.1	86.1	88.1	88.8	85.7			
Эрэгтэй		--	73.2	74.5	77.4	79.7	79.1			
Элсэх нас, жилээр	98.7	8	8	8	8	8	8	82.3	87.5	90.6
Хугацаа, жилээр	101.0	8	8	8	8	8	8	85.6	90.6	93.6
	96.4							79.0	84.4	87.5
<b>ЕРӨНХИЙ ДУНД БОЛОВСРОЛ (Б+В)</b>										
Нийт элсэлт	88	67.4	64.1	65.0	63.9	63.4	59.9			
Эмэгтэй		71.7	74.5	74.5	73.4	72.1	68.9			
Эрэгтэй		63.0	53.7	55.7	55.7	54.6	50.9			
Элсэх нас, жилээр	79.2	11	11	11	11	11	12	56.9	58.0	63.2
Хугацаа, жилээр	84.1	7	7	7	7	7	6	64.6	64.2	69.0
	74.2							49.1	51.8	57.2
	117							126	126	126

Тэмдэглэл: Суурь боловсрол нь бага ангийн болон дунд ангийнхныг хамруулна.  
Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

## Ашигласан материалын жагсаалт

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2000
2. Монгол Улсын Засгийн газрын Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн бодлогын баримт бичиг, 2001
3. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 1996-2000 оны тайлан, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн газар, 2001
4. Хүн амын амьжиргааны түвшингийн судалгаа, ҮСГ, 1995, 1998
5. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа, ҮСГ, 2000
6. Ядуурлын тайлан, ҮСГ, 1994
7. Ядуурлыг бууруулах түншлэлийн гэрээ, Монгол Улсын Засгийн газар, АХБ, 2000
8. Монгол улсын өнөөгийн байдлын жишиг үнэлгээний төсөл, НҮБХХ, 2000
9. Монгол Улсад НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ, НҮБХХ, 2000
10. Хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах төсөл, Дэлхийн банк, 1999
11. Монгол Улсын Хүн амын тооллогын дүн, ҮСГ, 2000
12. Эдийн засаг, санхүүгийн бодлогын талаар ОУВС-тай байгуулах санамж бичгийн төсөл, 2001
13. Тэжээллийн судалгааны тайлан, 1999
14. Ерөнхий болон дунд сургуулийн 2000/2001 хичээлийн жилийн мэдээ, БСШУЯ, 2000
15. Статистикийн эмхтгэл, 1998, 1999
16. Зөвлөлдөх бүлгийн 8-р уулзалт, 2001
17. Улсын төсвийн зарлагын тойм судалгааны санамж бичгийн төсөл Дэлхийн банк, 2001
18. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001
19. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2001
20. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, 2001
21. Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, 2000
22. ЮНЕСКО-гийн жилийн статистик, 2000-2001
23. Монгол Улс: Зөрчилдөж байгаа зорилтууд, хурдацтай өсөлт болон ядуурлыг бууруулах стратегийн чиглэлүүд, Дэлхийн банк, 2000

Хавсралт 1. Ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Завсрын үзүүлэлтүүд	2000	Эцсийн үр дүнгийн үзүүлэлтүүд	2004
Макро эдийн засгийн тогтворжилт	Валютын ханшны хэлбэлзэл (+, -), хувь Мөнгөний өсөлт, хувь ДНБ-д урсгал дансны алдагдлын эзлэх хувь ДНБ-д төсвийн урсгал дансны тэнцлийн эзлэх хувь	2.3 17.5 7.0 3.1	Эдийн засгийн өсөлт, хувь ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь Инфляцийн түвшин, хувь Ажилгүйдлийн түвшин, хувь	6.0 6.0 5.0 4.5
Боловсрол	Суурь боловсролын насны хүүхдийн сургуульд хамрагдсан хувь Амьдрах ухааны сургалтанд хамрагдсан ерхийн нийт өрхөд эзлэх хувь Дотуур байранд амьдрах шаардлагатай малчдын хүүхдийн хэдэн хувийг дотуур байраар хангасан	88.6 29.7	Анхан болон суурь боловсрол олгох сургалтын чанарыг үнэлэх "сурлагын амжилтын хяналт-шинжилгээ" түүвэр судалгааны дүнгээр одоогийн үзүүлэлтүүд өсч, хот, хөдөөгийн ялгаа зааг багассан байх Нэгдүгээр ангид элсэгчдээс хэдэн хувь нь хугацаандаа суурь боловсрол эзэмшиж байгаа	
Эрүүл мэнд	0-1 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдсан хувийн жин Суулгалт өвчнөөр өвчилсөн 0-5 насны хүүхдийн хувийн жин Амьсгалын замын цочмог халдвараар өвчилсөн 0-5 насны хүүхдийн эзлэх хувийн жин Нийт төрөлтөд гэртээ төрсөн эхийн эзлэх хувийн жин Цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувийн жин 40 хувь байгааг 30 хувь болгож бууруулах Сүрьеэгийн эмийн хангамж, хүрэлцээ сайжирсан байдал Оношлогоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлэх, хувь Сумын эмнэлэгт үзүүлсэн хүний тоо	94 18.9 66.3 1-ээс доош 40	Төрөхийн улмаас эндсэн эхийн тоо, 100 000 амьд төрөлтөд	
Ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал	Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, мян Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	38,6	Ядуурлын хувийн жин, хувь	
Бус нутгийн хөгжил	Эрчим хүчний хангамж, хувь Холбоожуулалт, хувь Усан хангамж, хувь		Хүн амын шилжилтийн түвшин (хөдөөнөөс хот руу), хувь	
Засаглалын чадавх, иргэний оролцоо	Мэдээлэл, интернэтийн хүртээмж, хувь Радио, телевизийн станцын тоо Төсвийн мэдээллийн дэлгэрэнгүй хэвлэн нийтлэл, жилд удаа	3 4	УИХ болон нутгийн сонгуульд сонгогдсон эмэгтэйчүүд, хувь Сонгуульд оролцсон сонгогчдын хувь, (хүйсээр) Засгийн газарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хувь	

Хавсралт 2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын хэв загвар (матриц)

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа
1. Макро эдийн засгийн тогтворжил-тийг бататгаж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.	Эрчим хүч, санхүүгийн салбар дахь бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, хувьчлалыг эрчимжүүлэх, хувийн хэвшил хөгжих таатай орчин бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг 2004 онд 6 хувьд хүргэнэ.	Засгийн газар	2001-2004
	Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг 2001 онд 17.2 хувиас 2004 он гэхэд 12.7 хувьд хүргэнэ. Гадаад худалдааны таатай орчин бүрдүүлж, түүнд сөргөөр нөлөөлөх тарифын болон тарифын бус саад хоригийг багасгана	Засгийн газар	2001-2004
	Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, ялангуяа банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх арга хэмжээ авна.	Засгийн газар Монголбанк	2001-2004
	Зээл, тусламжийн ашиглалт, зохицуулалтыг сайжруулж, өрийн удирдлагыг боловсронгуй болгоно.	Засгийн газар, Монголбанк	2001-2004
	Дэд бүтцийн хөгжлийг сайжруулан эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлнэ.	Засгийн газар	2001-2004
2. Улсын төсвийн удирдлага болон татварын тогтолцоог боловсронгуй болгоно.	Улсын төсвийн алдагдлын ДНБ-нд эзлэх хувийг 2004 онд 6 хувь хүртэл бууруулна. Татварын бааз суурийг өргөтгөж, татвар цуглуулалтыг сайжруулна.	СЭЗЯ	2001-2004
	Төсвийн төлөвлөлт, бүртгэл, хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно. Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг боловсруулна.	СЭЗЯ	2001-2004
	Төсвийн санхүүжилтийг боловсронгуй болгох, үр дүнгээр санхүүжүүлэх журамд шилжинэ. Төсөв захирагч нарын хариуцлагыг өндөржүүлнэ. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлуулна.	СЭЗЯ	2001-2004
	Эрдэнэт үйлдвэрийн санхүүгийн тайлан, тэнцэлд хөндлөнгийн хяналтыг хийнэ.	Засгийн газар	2001-2002
	Татварын байгууллагуудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, байцаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлнэ.	Засгийн газар, УТЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Орон нутгийн татварын албадыг бэхжүүлж, нэмэгдсэн өртгийн албан татварын цуглуулалт, хуваарилалт, хяналтыг сайжруулна.	Засгийн газар, УТЕГ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Банкуудын зээлийн эрсдэлийн сангаас авах татварыг хүчингүй болгоно.	Засгийн газар	2001
3. Төсвийн зарлагын удирдлагыг шинэчлэн сайжруулна.	Төсвийн зарлагын тойм судалгааг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хийж, судалгааны үр дүнд гарах зөвлөмжид тулгуурлан цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	СЭЗЯ	2001-2002
	Төрийн байгууллагын шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоог нэвтрүүлж туршина.	СЭЗЯ	2001-2004
	Инфляцийн түвшинг нэг оронтой тоонд хүргэх бодлого явуулна.	СЭЗЯ	2001-2004

	Инфляцийн түвшинг нэг оронтой тоонд хүргэх бодлого явуулна.	СЭЗЯ	2001-2004
4. Мөнгө, зээлийн оновчтой бодлогыг явуулна.	Банкинд газар, тээврийн буюу бусад үйлчилгээний бэлтгэл, ажлын байр, хөрөнгө, хувийн болон салбар агууламж зэвгийг боддог үйлдвэрсруулна.	СЭЗЯ, Монголбанк Монголбанк	2001-2004
	Зах зээлийн зарчмаар тодорхойлогдсон валютын ханшны тогтолцоог үргэлжлүүлнэ.	Монголбанк	2001-2004
	Банкны салбар дахь бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, төрийн өмчийн оролцоотой арилжааны зарим банкуудыг хувьчилна.	Засгийн газар	2001-2004
5. Банк, санхүүгийн салбарыг эрүүлжүүлнэ.	Банк бус санхүүгийн байгууллагуудын хөгжлийг дэмжинэ.	Засгийн газар, Монголбанк	2001-2004
	Хөдөө орон нутагт банк, санхүүгийн үйлчилгээг ойртуулах арга хэмжээ авна.	Монголбанк	2001-2004
	Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, даатгалын компаниудын хариуцлагыг дээшлүүлнэ.	Засгийн газар	2001-2004
	Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж, үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ. Банкны бүтцийн өөрчлөлтийн бондыг стандартжуулна	Засгийн газар, Монголбанк	2001-2004
	Өмч хувьчлалыг үргэлжлүүлж, үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийг хувьчилна.	Засгийн газар	2001-2004
	Томоохон аж ахуйн нэгжийг хувьчлахдаа эдийн засаг, санхүүгийн үр ашиг нэмэгдэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, экспортын шинэ зах зээлтэй холбох чадавх бүхий стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах чиглэл баримтлана.	Засгийн газар	2001-2004
6. Бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлнэ	Шинээр хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн удирдлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	Засгийн газар	2001-2004
	Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийж, эрчим хүчний салбарыг арилжааны горимд шилжүүлнэ. Эрчим хүч, дулааны үнийн өсөлтийн ядуучуудад нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авна.	Засгийн газар	2001-2004
	Газрын тухай шинэчилсэн хуулийг батлуулна.	Засгийн газар	2001-2004
	Хувийн хэвшлийн өсөлтийг хангахад улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг, түүнчлэн харилцаа холбоо, зам тээвэр ба бусад дэд бүтцийн салбарын хөгжилд гадаадын зээл, тусламжийг түлхүү ашиглана.	ДБЯ	2001-2004
	Зах зээлийн мэдээллийн тархаалтыг сайжруулна.	СЭЗЯ, ҮХЯ	2001-2004
7. Хувийн хэвшил давамгайлсан эдийн засгийн өсөлтийг дэмжих таатай орчин бүрдүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсролд хамрах хүрээг өргөтгөх, ялангуяа амьжиргааны доод түвшингээс бага орлоготой өрхийн хүүхдийн хамралтын хувийг нэмэгдүүлнэ.	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2000-2004
	Тахир дутуу хүүхдийг цэцэрлэг, сургуульд хамруулах, ердийн хүүхэдтэй хамт сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлнэ.	БСШУЯ, НХХЯ аймаг, нийслэлийн Засаг дарга	2000-2004
	Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх, тэднийг хөгжүүлэх чиглэлээр богино хугацааны төвлөрсөн сургалт явуулна.	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2000-2004

хамрах хүрээг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Хөдөөгийн сургуулийн хичээлийн ба дотуур байрыг засварлах, халаалт, цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэнэ.	БСШУЯ, нийслэлийн дарга аймаг, Засаг	2001-2004
	Нэн ядуу, ядуу өрхийн хүүхдийн сурах бололцоог сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд нэн ядуу, ядуу өрхийн сургуулийн өмнөх насны ба ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг хоол, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцсаар хангахад дэмжлэг үзүүлнэ.	БСШУЯ, НХХЯ аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Сургууль завсардсан хүүхэд, залууст нөхөн боловсрол эзэмшүүлж, ядуу иргэдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг эрс бууруулна.	БСШУЯ, нийслэлийн дарга аймаг, Засаг	2000-2004
	Амьдрах арга ухаан, техникийн боловсрол, мэргэжлийн баримжаа олгох сургалтын хүрээг нэмэгдүүлнэ.	БСШУЯ, НХХЯ аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
9. Эрүүл мэндийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ялангуяа хөдөөгийн болон ядуу, эмзэг бүлгийн хүн амд илүү үр ашигтайгаар хүргэнэ.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгож, эрүүл мэндийн суурь үйлчилгээг сайжруулна.	ЭМЯ, СЭЗЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Эмнэлгийн суурь тусламжийн багцыг тодорхойлж, стандартыг тогтооно. Эрүүл мэндийн даатгалын сангийн хуваарилалтыг сайжруулна.	ЭМЯ, СЭЗЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг түвшин бүрт тодорхой стандартыг тогтоож хэрэгжүүлнэ.	ЭМЯ, СЭЗЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Сумын эмнэлэг, эхчүүдийн төрөхийн өмнөх амрах байрыг засварлах, тохижуулах, зайлшгүй шаардлагатай эм, багаж хэрэгслэлээр хангахад чиглэсэн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулна.	ЭМЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Эхийн эндэгдлийг бууруулах стратегийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.	ЭМЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин, ДОХ, вируст гепатит болон халдварт өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	ЭМЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
	Дархлаажуулалтын сан байгуулан ажиллуулна.	ЭМЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004
10. Хөдөлмөрийн зах зээлийн хууль эрхзүй, эдийн засгийн орчныг бүрдүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлогыг дэмжин ажиглалтыг	Хөдөлмөр эрхлэлтийн тухай, Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах тухай хуулиудыг батлуулна.	НХХЯ, ХЗДХЯ	2001-2002
	Хөдөлмөрийн тухай, Ажилгүйдлийн даатгалын тухай хуулийг хянан сайжруулна.	НХХЯ, ХЗДХЯ	2001-2002
	Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, урт хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг ХЗА-аар дамжуулан сургалтад хамруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	НХХЯ, аймаг, нийслэлийн дарга Засаг	2001-2004

ажил-гүйдлийг бууруулна.	Дэд бүтцийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн нийтийг хамарсан ажил зохион байгуулна.	НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2002-2004
	Тахир дутуу иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	НХХЯ, Монголын тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	2001-2004
	Ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн бичил зээлийн үйлчилгээг өргөжүүлнэ.	ХХААЯ, НХХЯ	2001-2004
	Өмч хувьчлал, бүтцийн өөрчлөлтийн улмаас чөлөөлөгдөх хүмүүсийг урьдчилан тооцоолж, хөдөлмөр эрхлэлт, сургалтын асуудлыг хувьчлалын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.	ТӨХ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
11. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж орлогын баазыг нэмэгдүүлэх чиг-лэлээр шинэ тогтолцоо, хууль эрхзүйн орчин бүрдүүлнэ	Малчид болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг нийгмийн даатгалд хамруулах шинэ тогтолцооны үзэл баримтлал, хууль тогтоомжийг боловсруулна.	НХХЯ	2001-2004
	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	НХХЯ, СЭЗЯ	2001
	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулна.	НХХЯ, УНДЕГ	2001-2002
12. Эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлж, даатгалын үйлчилгээг оновчтой болгоно.	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, мэргэжлийн сургуульд суралцагчид, бага орлоготой иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах, тэдний өөрсдийн болон төрөөс төлдөг шимтгэл хураамжийн хэмжээг жигд болгох, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	НХХЯ, ЭМЯ	2001
	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийг Засгийн газар, ажил олгогч, даатгуулагчдын тэгш оролцоотой болгох, эрүүл мэндийн даатгалын бодлого, үйл ажиллагааг нийгмийн хамгааллын асуудалтай уялдуулан удирдах, хяналт тавих чиглэлээр хуульд өөрчлөлт оруулна.	НХХЯ, ЭМЯ	2001
13. Нийгмийн халамжийн хүрээг оновчтой тогтоож, халамжийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.	Өрх гэрт хүүхэдтэй ажиллах, нийгмийн тулгамдсан бэрхшээлийг даван туулахад нь туслах зорилгоор нийгмийн ажилтныг бэлтгэх төв байгуулах төсөл хэрэгжүүлнэ.	НХХЯ, БСШУЯ	2001-2004
	Хүүхэд гэр орондоо эх эцгийнхээ хайр халамжид өсч торних нөхцөлийг бүрдүүлэхэд түлхүү анхаарна.	Засгийн Газар	2001-2004
	Ядуу, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг үнэ төлбөргүй дотуур байр, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцсаар хангах, эрүүл мэндийн суурь үйлчилгээ үзүүлэх болон даатгалд хамруулах, өндөр настан, тахир дутуу иргэдийг эмчилгээ, сувилгааны болон нөхөн сэргээлтийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна.	БСШУЯ, НХХЯ, СЭЗЯ, ЭМЯ	2001-2004
14. Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн үйл	Гаалийн тогтолцоог уян хатан болгосноор бүс нутгуудад хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг дэмжих эрхзүйн орчин бүрдүүлнэ.	Засгийн газар	2001-2004

хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Бүс нутгуудын байгаль орчны даац, чадавх, хүн амын хэрэглээний онцлогт зохицуулан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.	Засгийн газар	2001-2004
15. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг нэмэгдүүлнэ	Ойг нөхөн сэргээх, цөлжилтөөс хамгаалах болон хот цэцэрлэгжүүлэх ажилд ядуу, орлого багатай иргэдийг өргөнөөр оролцуулна.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Байгалийн нөөц баялгийн ашиглалтын явцад эвдэрсэн, сүйтгэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлнэ.	БОЯ, ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Ховор амьтан, ургамлыг өсгөн үржүүлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	БОЯ	2001-2004
16. Байгалийн нөөц баялаг, дагалдах бүтээгдэхүүнийг зүй зохистой ашиглахад чиглэсэн орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачлагыг хөхиүлэн дэмжинэ.	Түймэрт шатсан, хорхой шавьжид идэгдсэн ойг цэвэрлэх замаар иргэдийн түлшний болон ахуйн хэрэглээний модны хэрэгцээг хангах арга хэмжээ авна.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Айл өрхүүдийг хувиараа жимс, мөөг, зөгийн аж ахуй эрхлэх, байгалийн бусад дагалдах баялагийг ашиглах ажилд дэмжлэг үзүүлнэ.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Байгалийн нөөцийг зохистой ашиглах, амьжиргаагаа дээшлүүлэх чиглэлээр иргэдийн дунд сургалт зохион байгуулна.	БОЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
17. Агаарын бохирдлыг багасгах, хот, суурин газрын хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, дарж булах ажлыг зохион байгуулна.	Хот, суурин газрын хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, ажилгүй иргэдийг татан оролцуулах арга хэмжээ авна.	Аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Хог хаягдлыг дарж булах ажлыг ажилгүй иргэдийн хүчээр зохион байгуулан хийлгэж, түр ажлын байр гаргана.	Аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Дулааны цахилгаан станц, уурын зуухнуудад шүүлтүүр тавих замаар агаарын бохирдлыг багасгах, ядуу айл өрхийг бүрэн шаталттай, түлш бага хэрэглэдэг гэрийн зуухаар хангах арга хэмжээ авна.	БОЯ, ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
18. Хүн амын амьдрах орчныг сайжруулж, байгаль орчны хамгаалалтыг өргөжүүлнэ.	Хөдөө, орон нутагт усны эх сурвалжийн чанарыг сайжруулна	БОЯ, ДБЯ, аймаг, сумдын Засаг дарга	2001-2004
	Сумуудад усны эх сурвалжийн тоог нэмэгдүүлнэ.	БОЯ, ДБЯ аймаг, сумдын Засаг дарга	2001-2004
19. Байгаль орчинд өгөх үнэлгээ хийх	Байгаль орчинд өгөх үнэлгээний тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004



хууль эрхзүйн орчныг сайжруулах, байгаль хамгаалах ажлыг зохион байгуулна.	Байгаль орчинд үзүүлсэн нөлөөллийн үнэлгээ өгөх ажилд улсын байгууллагуудыг оролцуулна.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
	Хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулна.	БОЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004
20. Аймаг, сумдын хүн амын нийтийн аж ахуйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Бүх аймаг, сумдыг халуун усны газартай болгох арга хэмжээ авна.	ДБЯ, аймаг, сумдын Засаг дарга	2001-2004
	Ядуу, орон гэргүй иргэдийг орон сууцаар хангах төсөл боловсруулан хэрэгжүүлнэ.	ДБЯ, аймаг, сумдын Засаг дарга	2003-2004
	Нийслэл, аймгийн төвийн гэр хорооллын хүн амын усан хангамжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.	ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2001-2004